

ТЭРБУМ МОД

BILLION TREES



Тэрбум мод



www.billiontreesmongolia.com

*Байгаль эхээ хайрлан хүндлэх нь
Монгол түмний өв, соёл
Revering mother earth is the living
legacy and heritage of the Mongolian people*



СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИ
EDITORIAL TEAM

| | |
|---|--|
| С.Энхжаргал "Тэрбум мод хөдөлгөөн" ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга | S.Enkhjargal Chairman of the Steering Committee, "Billion Trees Movement" NGO |
| Г.Энхтайван "Тэрбум мод хөдөлгөөн" ТББ-ын Гүйцэтгэх захирал | G.Enkhitaivan Executive Director "Billion Trees Movement" NGO |
| Б.Булган "Тэрбум мод хөдөлгөөн" ТББ-ын Төслийн менежер | B.Bulgan Project Manager "Billion Trees Movement" NGO |
| Б.Мөнхзаяа "Тэрбум мод хөдөлгөөн" ТББ-ын Төслийн менежер | B.Munkhzaya Project Manager "Billion Trees Movement" NGO |
| З.Борбилмаа Редактор | Z.Borgilmaa Editor |
| Г.Дашдулам Сэтгүүлч | G.Dashdulam Journalist |
| Б.Золзаяа Орчуулагч | B.Zolzaya English translator |
| Л.Өлзийжаргал Дизайнер | L.Ulzijargal Designer |
| Н.Батмөнх Гэрэл зурагчин (Сэтгүүлийн нүүр хуудасны гэрэл зургийг) | N.Batmunkh Cover photo by |



"Тэрбум мод хөдөлгөөн"
ТББ нь олон нийтийн
оролцоо, ил тод байдлыг
хангах зорилготой.

"Тэрбум мод хөдөлгөөн" ТББ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжин идэвхжүүлэх, сурталчлан таниулах, хөндлөнгийн хяналт, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах зорилгоор 2022 онд байгуулагдсан. Бид уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилттэй тэмцэх, бэлчээрийг хамгаалах хүрээнд ойжуулалт, нөхөн сэргээлтийг тогтвортой хөгжлийн зорилгод нийцүүлэн олон талт үйл ажиллагаа явуулж байна.

"Billion Trees Movement" NGO was established in 2022 to support, promote, and strengthen the "Billion Trees" National Movement initiated by the President of Mongolia. The organization aims to enhance public awareness, ensure transparency, encourage community participation, and provide independent oversight of the initiative. We carry out diverse activities aligned with sustainable development goals, focusing on afforestation and ecological restoration to mitigate the impacts of climate change, combat desertification, and protect rangeland ecosystems.

РЕДАКЦИЙН ЗУРВАС

Урт замын аялалд уудам тэнгэрт дүүлж яваа Танд энэ өдрийн мэндийг хүргэн мэндчилье.

Шим ертөнцөд мод таривал сав ертөнцөд буян хураана. Монголын Бурханы шашинтны Гандантэгчэнлин хийд, "Тэрбум мод хөдөлгөөн" ТББ хамтран энэхүү буяны үйл хэрэгт монголчуудаа уриалж буй сайхан мэдээгээр уншигч таныг угтахдаа таатай байна.

Хүн төрөлхтний ирээдүйг мэдээллийн технологийн дэвшилгүйгээр төсөөлөх аргагүй ч хэчнээн гайхамшигтай техник, технологи байгаад байгалийн аугаа хуулийн өмнө өнөөхөндөө, магадгүй цаашдаа ч хүчин мөхөсдөхийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Яг үүнийг сануулах мэт Монголын говиос голомтолсон шар шороон шуурга Азийн өндөр хөгжил бүхий, тэр дундаа технологи үйлдвэрлэгч Япон, Солонгос, Хятад зэрэг улс орнуудад нүдэнд ил харагдахаас үл үзэгдэх хүртэл аюул учруулж буй талаар сэтгүүлийнхээ энэ удаагийн дугаарт бид хөндсөн юм. Монголын шар шороон шуурганы үүсэлд юу нөлөөлж байгаа, яаж түүний дэгдэлт, давтамжийг багасгах вэ гэдэгт усны мэргэжилтнүүдийн гайхалтай шийдлийг танилцуулах болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн", нууруудыг сэргээх, хамгаалах хөтөлбөрүүд зөвхөн бидний хэрэг бус олон улсын өмнө хүлээх үүрэг гэдгийг ойлгоход бидний нийтлэл тусална.

Энэ дугаарын нэгэн гайхалтай нийтлэл нь гайхамшигт ойн тухай байх болно. Ойгоос үндсэн 25 мянга орчим үнэр ялгарч, хоорондоо урвалд орон хэдэн саяар тоологдох үнэр болж хувирдаг нь тус бүрдээ үүрэгтэй, бас зорилготой байдгийг бид мэдэх билүү?

Монгол тахийг сэргээн нутагшуулсан Хустайн нурууны байгалийн цогцолборт газарт зөвхөн тахь бус экосистем бүхэлдээ сэргэж амьтан, ургамал олшрон үржих таатай нөхцөл бүрдсэн төдийгүй нэгэнтээ мөхөн устаж байсан тахийг одоо байгальд нь тавих цаг болжээ.

Залуу хүн амтай Монгол Улсад энэхүү хүчин зүйл нь ямар ирээдүйг авчрах, яаж үүнийг төрийн бодлогоор дэмжих талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Залуучууд, спортын бодлогын зөвлөх Д.Даваадоржийн ярилцлага танд эрч хүч, эрмэлзлийг мэдрүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Мод тарих хөдөлгөөн эхэлснээс хойш хэн, хэчнээн мод хаана суулгаж, тоолуур хэдэд хүрснийг анзаарвал Та баярлах болно. Учир нь "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн" бол улс үндэстнээрээ оролцож буй гайхалтай бүтээн байгуулалт гэдгийг ойлгох болно.

"Тэрбум мод" сэтгүүлийн маань шинэ дугаартай хамт зорчиж буй Таны гал морин жилийн цог золбоо, аз хийморь, амжилт бүтээл есөн цагаан хүлгийн шандаст давхиан дунд урагшлан дүүлэхийн өлзий ерөөлийг өргөө.

EDITORIAL MESSAGE

We extend our greetings to you on this day as you journey beneath the vast open sky.

There is a saying that planting a tree in this world brings merit in the next. It is our pleasure to welcome you, our reader, with the good news that Gandantegchinlen Monastery of Mongolian Buddhism, together with the "Billion Trees Movement" NGO, is inviting all Mongolians to take part in this virtuous endeavor.

The future of humanity is unimaginable without advances in information technology. Yet, no matter how far technology develops, we must still recognize that before the greater laws of nature, we remain limited. The yellow dust storms rising from the Mongolian Gobi are a clear reminder of this, reaching across borders and affecting even the most technologically advanced countries in Asia, including Japan, Korea, and China, in ways both visible and unseen. In this issue, we take a closer look at this challenge and share perspectives from water specialists on what lies behind these storms and how their impact might be reduced.

This issue also highlights that the "Billion Trees National Movement", initiated by the President of Mongolia, along with efforts to restore and protect lakes, is not only a national priority but also something we are responsible for on a broader, international level.

One of the features in this issue turns to the quiet wonder of forests. Did you know that forests release around 25,000 primary scents, which interact to create millions of distinct aromas, each with its own role and purpose?

At Khustai National Park, where the Przewalski's horse has been reintroduced, the story goes beyond a single species. The ecosystem as a whole has recovered, creating the conditions for both plant and animal life to thrive once again. What was once on the brink of disappearance is now ready to return fully to the wild.

In Mongolia, a country with a young population, this demographic factor holds significant promise for the future. An interview with D. Davaadorj, Advisor to the President of Mongolia on youth and student development policy, offers insight into how this potential can be supported through public policy and is certain to inspire energy and aspiration.

Since the launch of the tree-planting movement, observing who has planted how many trees, where they have been planted, and how far the count has come is sure to bring a sense of pride. It shows that the "Billion Trees" National Movement is a truly remarkable effort carried forward by the entire nation.

As you read this new issue of the "Billion Trees Movement NGO Movement" magazine, we extend our sincere wishes for your strength, good fortune, and success in the Year of the Fire Horse, as you move forward with the spirit and momentum of nine white steeds.



АГУУЛГА

content



60 **ТЕХНОЛОГИЙН ЭСРЭГ ЗАРЛАСАН БАЙГАЛИЙН ДАЙНД БУУЖ ӨГӨХ ҮҮ?! WILL WE SURRENDER TO NATURE'S WAR ON TECHNOLOGY?**



34 **МОНГОЛЫН ЦАГААН САР: ХОЙМОРТ ЗАЛАХУЙ MONGOLIA'S LUNAR NEW YEAR**

Цагаан сар нь билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэнд тэмдэглэдэг шинэ эхлэл, цэвэр ариун, эв нэгдлийг бэлгэддэг баяр. The festival symbolizes renewal, purity, and unity.



19 **"МОНГОЛЫН ЗАЛУУ ХҮН АМ БОЛ ИРЭЭДҮЙН ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР ЮМ"**

"THE DRIVING FORCE OF MONGOLIA'S FUTURE DEVELOPMENT IS ITS YOUTH"

Энэ залуу бүтэц бидэнд юу өгч байна вэ? Нэг талаас ажиллах хүчний нөөц ихтэй, шинэ санаа, инновацийг дэлгэрүүлэх бэлэн үе давамгайлж байгаа нь улсын хөгжил хурдацтай, дэвшилттэй хөгжих боломжийг өгч чадна. What does this youthful structure offer? On the one hand, a large labour force and a generation ready to spread new ideas and innovation create favourable conditions for rapid and progressive development.

26



ТАХИЙН ХАМТ ИТГЭЛ, ХАРИУЦЛАГА УХААЛАГ БОДЛОГО НУТАГШСАН ХУСТАЙ KHUSTAI: WHERE SHARED TRUST, RESPONSIBILITY, AND LONG-TERM WISDOM HAVE TAKEN ROOT

51 **МОНГОЛ БАХАРХАЛ-2025: ЭВ НЭГДЭЛ, АМЖИЛТ, ШИНЭЧЛЭЛ MONGOL PRIDE 2025: UNITY, ACHIEVEMENT, RENEWAL**



2025 он Монгол Улсын хувьд сорилт, шинэчлэл, эв нэгдэл, бахархлаар дүүрэн жил байлаа. Дэлхий дахины өөрчлөлт, уур амьсгалын сорилт, эдийн засгийн савлагаан дунд монгол хүн оюун ухаан, ур чадвар, зориг тэвчээр, нэгдмэл хүчээрээ ялгарч чадсан юм. Энэ жил Монгол Улс олон

улсын тавцанд шинэ амжилт, итгэл найдвар, түүхэн үзүүлэлтүүдээр дүүрэн байв. The year 2025 was one of challenge, change, unity, and pride for Mongolia. In the midst of global shifts, climate pressures, and economic uncertainty, the Mongolian people stood out through their intelligence, skill, courage, and resilience, united as one. It was a year marked by new accomplishments, renewed confidence, and historic milestones on the international stage.

4



ДИЖИТАЛ АРТЫН НЭГЭН ТӨРӨЛ (ФОТО БОЛОН УРАН ЗУРГИЙН ХОСЛОЛ)-Г ХӨГЖҮҮЛЭГЧ УРАН ЗУРААЧ Д.ЭНХБААТАРЫН "ЦАЦАЛ" НЭРТЭЙ БҮТЭЭЛИЙГ ТОЛИЛУУЛЖ БАЙНА.

FEATURED HERE IS "TSATSAL," A WORK BY ARTIST D. ENKHAATAR, WHO DEVELOPS A DISTINCTIVE FORM OF DIGITAL ART THAT COMBINES PHOTOGRAPHY AND PAINTING.

2026 оны нэгдүгээр улирал

BILLION TREES

Урт холын аялал тань тухтай, хожим эргэх цаг дор аяллын богц амжилт, дурсамж, түүхээр дүүрэн болтугай. May your long journey be comfortable, and when you return later, may you carry success, memories, and stories along with your "travel bag".



Цацал
Tsatsal



Зургийг Д.Энхбаатар: Төв аймаг, Аргалант сум, Ард дулааны ам, 2022 он
Tuv province, Aргalant soum, Ard Dulaanii am, Photo by Enkhbaatar.D
[f](#) [i](#) Enkhee Dambii



UNCCD
COP17
ULAANBAATAR 2026



United Nations
Convention to Combat
Desertification

ЭХ БАЙГАЛИА СЭРГЭЭ ИТГЭЛ НАЙДВАРАА БАДРААЯ

2026.08.17-28

УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС

ЭХ ГАЗРЫН

40%

доройтсон



**АМЬЖИРГАА, БИОЛОГИЙН
ОЛОН ЯНЗ БАЙДАЛ БОЛОН
УУР АМЬСГАЛД ХОХИРОЛ
УЧРУУЛЖ БАЙНА.**

ЯСМИН ФУАД:

“COP17 хүн төрөлхтний суурь хэрэгцээ болох хүнсээр биднийг хангадаг малчид, нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн итгэлийг сэргээх үйл явдал гэдгийг онцолмоор байна. Монгол Улс COP17 бага хурлыг хүлээн авагч улсын хувиар зохион байгуулалтын бэлтгэл ажлаа идэвхтэй, хариуцлагатай хангаж байгаад талархал илэрхийлье. НУБ-ын Суурин зохицуулагчийн газар болон Конвенцын Нарийн бичгийн даргын зүгээс тус бага хурлыг амжилттай зохион байгуулахад бодлогын болон зохион байгуулалтын бүх талаар дэмжлэг үзүүлж, цаашид Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажиллана” гэв.

Цөлжилт, газрын доройтол, ган гачиг

Цөлжилт, газрын доройтол, ган гачиг (DLDD) нь Монгол Улсад тулгамдсан томоохон сорилтуудын нэг юм. Монгол орны нийт газар нутгийн 77% (120.3 сая га) талбай нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй цөлжилтийн нөлөөнд өртөөд байна. Ойролцоогоор 23% (30 сая. га) талбай ноцтой доройтолд орсон гэж үнэлэгдэж байна. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн төсөөллөөр хэтдээ буюу ирэх зуунд манай орны цаг агаар мэдэгдэхүйц дулаарч, хур тунадасны давтамжийн өөрчлөлт үргэлжлэх төлөвтэй байгаа нь цөлжилт, гангийн эрсдэлийг улам нэмэгдүүлэх хандлагатай байна.

Цөлжилттэй тэмцэх тухай НУБ-ын Конвенцын тухай

Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц (ЦТНУБК) нь газрын тогтвортой ашиглалтыг хангах, цөлжилт, газрын доройтол, ган гачиг зэрэг тулгамдсан асуудлыг хэлэлцэх 197 талуудын нэгдэн орсон олон улсын эрх зүйн баримт бичиг юм. Энэ нь хүн ам, нийгэм,

улс орнуудыг баялгаа нэмэгдүүлэх, эдийн засгаа өсгөх, хүнс, цэвэр ус, эрчим хүчний хүртээмжийг хангахад дэмжлэг үзүүлдэг

Монголын нүүдлийн соёл нь



уудам тал хээр, цөл, ой, уулсын байгальтай салшгүй холбоотойгоор бүрэлдэн хөгжиж, малчид ургамал ногоог нөхөн төлжүүлэхийн тулд улирлаа дагаад бэлчээрээ сэлгэж ирсэн өвөрмөц үнэт өв юм. Ардын хөгжим, үндэсний наадам, уламжлалт гар урлал, ёс заншил нь өнөөг хүртэл хадгалагдан, бахархал болон оршсоор байна. Монголын соёл, уламжлал нь байгаль хамгаалах арга ухаантай нягт уялдаатай бөгөөд үндэстний үнэт зүйлсийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг болдог.

Цөлжилттэй тэмцэх тухай НУБ-ын конвенцын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга хатагтай Ясмин Фуад Монгол Улсад 2026.02.03-2026.02.06-ны өдрүүдэд албан ёсны айлчлалыг хийв.

Талуудын 17 дугаар бага хурлын ЦЭНХЭР БҮС-д зохион байгуулах сэдэвчилсэн өдрүүдийн хөтөлбөр:

Санхүүжилтийн өдөр (8 дугаар сарын 24): Газрыг өргөн хүрээнд нөхөн сэргээхийн тулд өдөрт ойролцоогоор 1 тэрбум ам.долларын санхүүжилт шаардлагатай боловч одоогийн санхүүжилт үүнээс үлэмж бага байна.

Энэхүү өдрөөр Сангийн сайд нар, хөгжлийн банкууд, олон улсын санхүүгийн байгууллагууд болон хувийн хэвшлийн төлөөллийг нэгтгэн, санхүүжилтийн зөрүүг багасгах, томоохон хөрөнгө оруулалтын боломжийг бүрдүүлэхэд анхаарна.

RESTORING LAND RESTORING HOPE

Desertification, Land Degradation, and Drought

Desertification, land degradation and drought (DLDD) are among Mongolia's most pressing challenges. An estimated 76.9% of the country's land area (120.3 million hectares) is affected, with about 23%, nearly 30 million hectares, severely degraded. Overgrazing and unsustainable land use are significant drivers, posing serious risks to food security, pastoral livelihoods, and ecosystem stability. Moreover, due to climate change, future climate projections for Mongolia highlights significant warming trends and shifts in precipitation patterns over the next century, which induces desertification and drought challenges.

About the UNCCD

The United Nations Convention to Combat Desertification (UNCCD) is an international legal framework brings together 197 Parties to promote sustainable land use and to address the critical challenges of DLDD. It supports countries and communities in strengthening livelihoods, economic growth, and access to food, water and energy through sustainable land management.

Mongolia's nomadic culture nomadic pastoralism in Mongolia, where herders move their livestock seasonally to reduce stress on rangelands, ensuring vegetation regeneration which is a unique and invaluable cultural heritage that has evolved in close harmony with its vast steppes, deserts, forests, and mountains. Folk music, vibrant festivals, traditional handicrafts, and customs continue to be preserved as sources of national pride. Mongolian culture and traditions are deeply intertwined with nature and form an integral part of the nation's core values.

Ms. Yasmine Fouad, Executive Secretary of the United Nations Convention to Combat Desertification, paid an official visit to Mongolia from February 3 to February 6, 2026.

She stated: "COP17 is an event that



aims to restore the confidence of herders and pastoralists who provide us with food is a fundamental necessity for humanity." Executive Secretary Yasmine Fouad also expressed her appreciation for Mongolia's active and responsible efforts in preparing for COP17 as the host country. She reaffirmed that the UN Resident Coordinator's Office and the Convention Secretariat will provide full policy and organizational support to ensure the successful convening of the conference, and will continue to work closely with the Government of Mongolia.

Blue Zone Thematic days at the COP17

Finance (24 August): Restoring land

at scale requires around one billion US dollars per day, but current funding falls far short. Finance Day will bring together ministers of finance, development banks and the private sector to help close this gap and unlock large-scale investment.

Water (25 August): By 2050, three out of four people worldwide are projected to face drought. Water Day will advance proactive drought risk management and strengthen cooperation on the integrated management of water resources.

Land and People (26 August): Rangelands support the livelihoods of some 500 million people, but remain among the most undervalued ecosystems globally. Land and People's Day will place the voices of land stewards at the heart of discussions, highlighting the perspectives of Indigenous Peoples, local communities, pastoralists, youth, women and civil society organizations.

Food Systems and Soil Health (27 August): By 2050, the world will need to produce at least 50 per cent more food, even as food systems remain the leading driver of land degradation globally. Food Systems and Soil Health Day will connect soil restoration to food security, agricultural productivity and the livelihoods of farming communities.

STEPPE ACTION AGENDA

The Steppe Action Agenda is a long-term action and policy legacy programme being developed by Mongolia, in close cooperation with international partners and the UNCCD, in the lead-up to and beyond COP17. It is designed to ensure to deliver tangible, lasting outcomes, moving beyond dialogue toward scaled implementation, investment mobilization and measurable impact on the ground. It consists of 3 Main Pillars:

Rangeland Flagship Initiative

Mongolia and the UNCCD are jointly leading a ten-year global program to promote sustainable pastoralism, climate-resilient rangeland use, and land restoration in drylands through structured public-private partnerships.

Усны өдөр (8 дугаар сарын 25): 2050 он гэхэд дэлхийн дөрвөн хүн тутмын гурав нь гангийн эрсдэлд өртөх төлөвтэй байна. Усны өдрөөр гангийн эрсдэлд урьдчилан бэлтгэх менежментийг сайжруулах, усны нөөцийн нэгдсэн менежментийг дэмжих, ус ба газрын нэгдсэн төлөвлөлтийг уялдуулах хамтын ажиллагааг өргөжүүлэхэд төвлөрнө.

Газар ба хүн төвт өдөр (8 дугаар сарын 26): Бэлчээрийн экосистем нь дэлхий даяар 500 орчим сая хүний амьжиргааг дэмждэг боловч хамгийн дутуу үнэлэгдсэн экосистемүүдийн нэг хэвээр байна. Энэ өдөр газар ашиглагчдын дуу хоолойг сонсож, уугуул болон нутгийн иргэд, малчид, нүүдэлчид, залуучууд, эмэгтэйчүүд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог онцолно.

Хүнсний систем ба хөрсний эрүүл мэндийн өдөр (8 дугаар сарын 27): 2050 он гэхэд дэлхийн хүнсний хэрэгцээг хангахын тулд хүнсний үйлдвэрлэлийг дор хаяж 50 хувиар нэмэгдүүлэх шаардлагатай боловч өнөөгийн хүнсний систем нь газрын доройтлын гол шалтгаан хэвээр байна. Энэ өдрөөр газрын нөхөн сэргээлтийг хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн бүтээмж болон фермер, малчдын амьжиргаагаар уялдуулах шийдлүүдийг хэлэлцэнэ.

ТАЛ ХЭЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тал хээрийн төлөвлөгөө нь Монгол Улсын олон улсын түншүүд болон ЦТНУБК-тай хамтран боловсруулсан COP17-г утгаж, мөн

түүнээс цааш хэрэгжүүлэх урт хугацааны үйл ажиллагаа, бодлого юм. Энэхүү төлөвлөгөө нь хэлэлцүүлгээр хязгаарлагдах бус, хэрэгжилтийг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг хөдөлгөх, газар дээрх бодит, хэмжигдэхүйц үр дүнд хүрэх тогтвортой, бодитой өөрчлөлтийг бий болгоход чиглэсэн. Тал хээрийн төлөвлөгөө нь үндсэн гурван тулгуур чиглэлээс бүрдэнэ.

Бэлчээрийн тэргүүлэх санаачилга:

ЦТНУБК нь нүүдлийн мал аж ахуйн тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй бэлчээрийн ашиглалт, гандуу бүс нутгийн хөрсний нөхөн сэргээлтийг дэмжихэд чиглэсэн арван жилийн хугацаатай дэлхийн хэмжээний хөтөлбөрийг хамтран манлайлан хэрэгжүүлж байна. Энэхүү санаачилга нь төр-хувийн хэвшлийн түншлэлийг системтэйгээр нэгтгэн, олон улсын түвшинд бодит үр дүн гаргах зорилготой.

Гандуу бүс нутгуудын газар-усны уялдаа холбооны санаачилга:

Гандуу бүс нутгийн ус, газрын нөөцийг нэгдсэн байдлаар удирдах бүс нутгийн болон олон улсын түншлэлийг хөгжүүлж, гангийн эсрэг тэсвэртэй байдлыг бэхжүүлэх, хөрсний чийгийн нөөцийг хадгалах нь хуурай бүс нутгийн хүнсний үйлдвэрлэлд онцгой ач холбогдолтой юм. Энэ нь төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэсэн бүс нутгийн уялдаа холбоог бий болгоно.

Байгальд суурилсан шийдэл бүхий дэд бүтцийн санаачилга:

Газарт төвлөрсөн төлөвлөлт болон байгальд суурилсан шийдлүүдийг нэгтгэн хэрэгжүүлэх энэхүү дэлхийн санаачилга нь төр-хувийн хэвшлийн түншлэлийг өрнүүлж, байгаль орчинд ээлтэй тогтвортой дэд бүтцийн талаар НҮБ-ын Байгаль орчны Ассамблейн тогтоолуудын хэрэгжилтийг ахиулахад чиглэнэ.

УЛААНБААТАР ХОТ COP17-Г ЗОХИОН БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛЭЭ ХАНГАЖ БАЙНА

Монгол Улс 2026 онд болох COP17 бага хурлыг амжилттай зохион байгуулахын тулд бүх зохион байгуулалтын бэлтгэл ажлыг бүх талд ханган ажиллаж байна. Монголын нийслэл Улаанбаатар хот дэлхийн өнцөг булан бүрээс хүрэлцэн ирэх төлөөлөгчдийг угтан авах бэлтгэлээ нарийвчилсан төлөвлөгөөний дагуу хийж байна.

ХУРЛЫН БАЙРШЛЫН ТОЙМ:

COP17 хурлын талбай нь үрашигтай зохион байгуулалт, тогтвортой хөгжил, хүртээмжтэй байдлыг нэн тэргүүнд тавин төлөвлөгдсөн. Үндсэн авто замаас олон нийт болон VIP зогсоол руу чиглэсэн хоёр тусгай нэвтрэх зам төлөвлөгдөж, эдгээр нь НОГООН БҮС-д шууд холбогдоно. Мөн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс дугуй болон шатл автобусны зориулалтын чиглэл гаргах бөгөөд энэ нь байгальд ээлтэй, үр ашигтай тээврийн шийдэл байх юм.

Дэлгэрэнгүй: <https://unccdcop17.org/>



Water-Land Nexus Initiative

This initiative promotes integrated management of water and land resources in drylands through regional and international partnerships to enhance drought resilience and soil moisture retention.

Nature-Based Solutions for Sustainable Infrastructure Initiative

This global initiative integrates land-use planning with nature-based solutions through public-private partnerships to advance UN Environment Assembly resolutions on sustainable infrastructure.

ULAANBAATAR IS GEARING UP TO HOST COP17

Mongolia is working diligently to ensure that all the practical arrangements are in place for successful COP17 in 2026. Ulaanbaatar, our capital city, is undergoing careful preparations to welcome delegates from around the world.

CONFERENCE VENUE

The COP17 site is designed for efficiency, sustainability, and accessibility. Two dedicated access

routes from the main road will lead to public and VIP parking areas, directly connecting to the Green Zone. Dedicated bicycle and shuttle routes from the National Park will support environmentally friendly transport.

Furthermore: <https://unccdcop17.org/>



ХУС МОД-ЦАГААН ОЙ ДЭЭГҮҮР НИСЭХҮЙ

Монголын тэнгэрээс харагдах намуухан гоо үзэсгэлэн



**BIRCH TREES- FLYING
OVER THE WHITE FOREST**

Онгоц аажмаар хөөрөхөд хотын дүр зураг алсарсаар үүлний цаанаас цайран харагдах ой мод үзэгдэнэ. Тэр дунд цагаан судал мэт харагдах модод бол Монголын хойд нутгийн хусан ой. Дээгүүр нь нисэхэд энгийн атлаа газар дээр нь очиход сэтгэлд үлдэх онцгой мэдрэмж төрүүлдэг байгалийн гайхамшиг юм.

Хус мод бол Монголын байгалийн намуухан гоо үзэсгэлэн. Цагаан холтос нь нарны гэрэлд зөөлөн гялалзаж, салхинд хийсэх навчсын шивнээ нь байгалийн хөг аялгууг зүрхэнд эгшиглүүлнэ.

Цагаан холтостой, намуухан төрхтэй хус модыг харахад л сэтгэл тайвширдаг. Монгол орны хойд бүсийн ой тайгад зонхилон ургадаг энэхүү мод нь зөвхөн байгалийн нэгэн бүрэлдэхүүн бус, хүний сэтгэл, ахуй соёл, уламжлалтай гүн гүнзгий холбоотой.

Монголын хойд бүс Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Хэнтийн ой тайгад хус зонхилон ургана. Ялангуяа намрын улиралд алтлаг шар өнгөөр солонгорох хусан ой нь тэнгэрээс харахад байгалийн зурсан зураг шиг үзэсгэлэнтэй.

ХУС МОДНЫ ЖИЛИЙН ДӨРВӨН УЛИРЛЫН ӨНГӨ

БАЙГАЛИЙН ЧИМЭГ, ЭКОСИСТЕМИЙН ТУЛГУУР

Хус мод нь зөвхөн үзэсгэлэнтэй төдийгүй байгаль хамгааллын чухал нөөц юм. Хөрсийг хамгаалж, чийгийн тэнцвэрийг хадгалж, ойн нөхөн сэргээлтэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хус мод нь хүйтэн сэрүүн уур амьсгалд тэсвэртэй. Ойд хөрсний элэгдлийг багасгаж, бусад ургамал, амьтдын амьдрах орчныг бүрдүүлдэг нь түүнийг экосистемийн “чимээгүй хамгаалагч” болгодог.

МОНГОЛ АХУЙ, СОЁЛ ДАХЬ ХУС МОД

Монголчууд хус модыг эрт дээр үеэс цэвэр ариуны бэлгэдэл хэмээн үздэг. Тиймдээ ч хусны үйсэн дээр чухал нандин түүхээ бичиж ирсэн. Мөн хус модыг гэрийн тооно, багана, эмээл, хөгжмийн зэмсэг урлах зэргээр ахуй соёлдоо хэрэглэдэг байсан.

Зарим нутгийн тахилга, зан үйлд хус модыг онцгойлон хэрэглэдэг нь байгальтайгаа зохицон амьдрах монгол ухааны илэрхийлэл юм.

ЭРҮҮЛ МЭНД, ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ ЦЭН

Хусны шүүс нь амин дэмээр баялаг, бие цэвэрлэх, дархлаа дэмжих үйлчилгээтэй хэмээн уламжлалт анагаах ухаанд хэрэглэсээр ирсэн. Нас бие гүйцсэн хус модноос нэг удаад 10 хүртэлх литр шүүс гардаг. Монголчууд хусны шүүсийг авч хэрэглэхдээ модыг аль болох гэмтээхгүйгээр дахин сэргэх нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн хусны нүүрс, давирхайг арьс, үе мөчний зарим өвчинд ашигладаг нь судалгаагаар, батлагдсаар байна.





Гэрэл зургийг ургамал судлаач, доктор М.УРГАМАЛ
Photo by Botanist, Doctor Urgamal.M



ХУС МОДНЫ ЖИЛИЙН ДӨРВӨН УЛИРЛЫН ӨНГӨ

ХАВАР-СЭРЭХ МӨЧ

Хаврын эхэнтэй зэрэгцэн хус мод цасан доороос амь орж, нахиалж эхэлнэ. Нялх ногоон навч дэлбээлж, ой шинэ амьсгалаар дүүрнэ. Энэ бол хус мод байгальд эрч хүч, сэргэлтийн дохио өгдөг цаг.

ЗУН - АМЬДРАЛЫН ДУНДАХ ТАЙВШРАЛ

Зуны улиралд хус мод бүрэн навчилж, ойн сэрүүн сүүдэр болон хувирна. Цагаан холтос, ногоон навчны зохицол нь аялагчдын нүдийг баясгаж, ойн цэнгэг агаар сэтгэл сэргээнэ. Алхалт, амралт, бясалгалд хамгийн тохиромжтой зуны хусан ой.

НАМАР-АЛТЛАГ ДУРСАМЖ

Намар хус модны навч алтран шаргалтаж, ой байгалийн урлан мэт хувирна. Энэ бол хус модны хамгийн гоёмсог төрх. Намар цагт шаргалтан гялалзах хусан ой нь Монголын байгалийн хамгийн үзэсгэлэнт дүр төрхүүдийн нэг бөгөөд хэн хүний сэтгэлийг татан байгаль хамгааллын үнэ цэнийг сануулдаг.

ӨВӨЛ-ЧИМЭЭГҮЙ ГОО ҮЗЭСГЭЛЭН

Өвөл хус мод навчгүй ч цагаан холтос, хар толбо нь цасан дунд тодрон харагдана. Хүйтнийг тэсвэрлэн зогсох хусны мөчир бүр байгалийн тэсвэр, даруу хүчийг илэрхийлнэ. Чимээгүй ариун мэт энэ л төрх нь өвлийн нэгэн бэлгэдэл гэлтэй.

ХУС МОДОО ХАЙРЛАХ НЬ

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хууль бус мод бэлтгэл зэргээс шалтгаалан хусан ой цөөрөх хандлагатай болсон. Иймд хус модыг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах нь зөвхөн байгаль хамгаалагчдын үүрэг бус хүн бүрийн үүрэг юм.

Хус мод бол Монголын ой, байгаль, соёлын салшгүй нэгэн хэсэг. Цагаан холтосны цаана байгалийн тэнцвэр, хүний сэтгэлийн амар амгалан, өв соёлын үнэ цэн нуугдаж байдаг. Түүнийг хайрлан хамгаалах нь ирээдүйдээ үлдээх өв билээ.

The gentle beauty seen from Mongolia's Sky As the plane slowly takes off, the cityscape gradually fades away, and beyond the clouds, pale stretches of forest begin to appear. Those white, ribbon-like lines are the birch forests of northern Mongolia. Seen from above, they appear simple and calm, yet when visited on the ground, they leave a deep and lasting impression, one of nature's quiet wonders. The birch tree embodies Mongolia's gentle natural beauty. Its white bark softly shimmers in the sunlight, while the whisper of its leaves swaying in the wind plays a natural melody that resonates in the heart. Just looking at a birch tree with its white bark and modest appearance brings a sense of calm. Predominantly growing in the taiga forests of northern Mongolia, this tree is not merely a component of nature but is deeply intertwined with human emotion, daily life, culture, and tradition.

In the northern regions of Mongolia Selenge, Bulgan, Khuvsgul, and Khentii birch trees grow abundantly throughout the forested landscapes. Especially in autumn, when the birch forests turn shades of golden yellow, they resemble a painting drawn by nature itself when viewed from the sky.

A NATURAL ORNAMENT AND A PILLAR OF THE ECOSYSTEM

Birch trees are not only beautiful, they are also an important resource for environmental protection. They help safeguard soil, maintain moisture balance, and play a vital role in forest regeneration. Well-adapted to cold and cool climates, birch trees reduce soil erosion and create habitats for other plants and animals, making them "silent guardians" of the ecosystem.

BIRCH TREES IN MONGOLIAN DAILY LIFE AND CULTURE

For centuries, Mongolians have regarded the birch tree as a symbol of purity and sacredness. Birch bark has also long been used to record important and precious histories. In addition, wood has been widely used in traditional daily life, for crafting the crown and pillars of a ger, saddles, and musical instruments. In certain regions, birch trees are given special significance in rituals and ceremonial practices, reflecting the Mongolian philosophy of living in harmony with nature.

HEALTH AND MEDICINAL VALUE

Birch sap is rich in vitamins and has long been used in traditional medicine for its cleansing properties and immune-supporting benefits. From a mature birch tree, up to 10 liters of sap can be collected at a time. When harvesting birch sap, Mongolians traditionally take great care to minimize damage to the tree, ensuring its ability to regenerate.

In addition, birch charcoal and resin have been used to treat certain skin and joint conditions, and modern scientific studies continue to confirm these traditional practices.

THE FOUR SEASONS OF THE BIRCH TREE

Spring – The Moment of Awakening

With the arrival of spring, birch trees awaken beneath the melting snow as sap begins to flow. Tender green leaves unfold, filling the forest with new breath. This is the season when birch trees signal renewal, vitality, and the quiet strength of nature.

Summer – Calm in the Heart of Life

In summer, birch trees stand fully leafed, creating cool shade within the forest. The harmony of white bark and green leaves delights the eye, while the fresh forest air refreshes the spirit. A summer birch forest is an ideal place for walking, rest, and quiet reflection.

Autumn – Golden Memories

In autumn, birch leaves turn golden yellow, transforming the forest into a natural gallery. This is the birch tree at its most graceful. The shimmering golden birch forests are among Mongolia's most beautiful landscapes, drawing the heart closer to nature and reminding us of the value of conservation.

Winter – Silent Beauty

In winter, though leafless, birch trees stand out against the snow with their white bark. Each branch enduring the cold reflects nature's resilience and quiet strength. This serene and almost sacred presence has become a symbol of winter itself.

LOVING AND PROTECTING THE BIRCH TREE

In recent years, birch forests have been declining due to climate change and illegal logging. Therefore, the sustainable use, restoration, and protection of birch trees are not only the responsibility of environmentalists but the duty of every individual.

The birch tree is an inseparable part of Mongolia's forests, nature, and cultural heritage. Behind its white bark lies the balance of nature, the peace of the human spirit, and the value of cultural traditions. Protecting and cherishing the birch tree is among the purest legacies we can leave for future generations.

ХУС МОД ОЙ СЭРГЭЭХ ЧУХАЛ НӨӨЦ

Монголд ургадаг хусны төрөл:

Цагаан хус

- Хамгийн түгээмэл
- Ой тайгын бүсэд ургадаг

Дүүжин хус

- Ховор
- Гоёлын ач холбогдолтой

Бутлаг хус

- Чийглэг, намгархаг газар ургадаг
- Хөрс хамгаална

Одой хус

- Өндөр уулын бүсэд ургадаг
- Хүйтэнд тэсвэртэй

ХУСНЫ ШИНЖ ЧАНАР

Өндөр: 15-25 метр хүртэл өндөр ургадаг

Хэлбэр: Шулуун их биетэй, нарийн салаалсан мод

Холтос: Цагаан өнгөгэй, нимгэн хуурай хальстай

Навч: Өндгөн хэлбэрийн, ирмэг нүхтэй ногоон навчтай, намар цагаар шар болж унадаг.

Насжилт

- Дундаж: 80-120 жил
- Ихдээ: 140-150 жил

Экологийн ач холбогдол

- Хортон шавьж, өвчнөөс хамгаалдаг бодис ялгаруулдаг
- Хөрс тогтоон барина
- Чийгийн горим сайжруулна
- Ойн нөхөн сэргээлтийг дэмжинэ
- Биологийн олон янз байдлыг дэмжинэ

Тархалт, дасан зохицол

- Хүйтэн сэрүүн бүсэд тэсвэртэй
- Тарчиг хөрсөнд ч урга чадвартай

Үржүүлгийн онцлог

- Үрээр үржүүлнэ
- Соёололт хурдан
- Суулгацын амьдрах чадвар өндөр

Хэрэглээ, үнэ цэн

- Ойжуулалт
- Хот суурингийн ногоон байгууламж
- Байгаль хамгаалал

Хамгааллын шаардлага

- Хууль бусаар мод бэлтгэхийг хязгаарлах
- Шүүсийг нь авах гээд гэмтээхгүй байх
- Нөхөн тарилтыг тогтмолжуулах

BIRCH TREES-A VITAL RESOURCE FOR FOREST REGENERATION

Birch Species in Mongolia:

• White Birch (*Betula platyphylla*)

- o Most common species
- o Grows in taiga forest regions

• Swing Birch

- o Rare
- o Valued for decorative purposes

• Shrubby Birch

- o Grows in moist, lowland areas
- o Helps protect soil

• Dwarf Birch

- o Found in high mountain regions
- o Cold-resistant

CHARACTERISTICS OF BIRCH TREES

- Height: Grows up to 15-25 meters
- Form: Straight trunk with narrow branching
- Bark: White, thin, and peeling
- Leaves: Ovate with serrated edges; green in summer, turning yellow in autumn

Lifespan

- Average: 80-120 years
- Maximum: 140-150 years

Ecological Importance

- Produces substances that protect against insects and diseases
- Stabilizes soil and prevents erosion
- Maintains moisture balance
- Supports forest regeneration
- Enhances biodiversity

Distribution and Adaptation

- Resilient in cold temperate regions
- Able to grow in poor or shallow soils

Reproduction

- Propagates by seeds
- Fast germination
- Seedlings have high survival rates

Uses and Value

- Afforestation and reforestation projects
- Urban green spaces and landscaping
- Environmental protection

Conservation Requirements

- Prevent illegal logging
- Harvest sap without damaging trees
- Maintain regular replanting and restoration



**БАЯРСАЙХАНЫ
ОРХОНБАЯР**

Монгол Улсын арслан
Төрсөн огноо: 1998.07.01
Төрсөн нутаг: Сэлэнгэ аймаг, Цагааннуур сум
Бөхийн замнал: 2014 оноос
Дэвжээ: “Таван хан”
Харьяалал: “Алдар” спорт хороо



**ДЭВЖЭЭН ДЭЭР
ТӨРСӨН ДАЙЧИН**

Хангайн салхи, хөдөө нутгийн тэсвэр хатуужил түүнийг багаас нь төлөвшүүлсэн. 2014 оноос үндэсний бөхийн бэлтгэлд шамдаж, ердөө тавхан жилийн дараа улсын наадамд цойлон гарч ирсэн нь шинэ үеийн бөхчүүдийн өнгийг тодорхойлсон мөч байв.

2019 онд анх удаа Төрийн наадамд хүч үзэж, тав даван Улсын начин цол хүртсэн бол 2022 онд ес давж Улсын арслан цолонд хүрсэн нь түүний үндэсний бөхийн замналын оргил алхам болсон. Залуу нас, уран мэхтэй барилдаан, сэтгэлзүйн бэлтгэл гурав нь түүнийг үзэгчдийн хайртай бөх болгожээ.

АМЖИЛТЫН ТОВЧООН

- 2019 он -Үндэсний их баяр наадамд 5 давж Улсын начин цол хүртэв.
- 2020 он -Үндэсний их баяр наадамд дахин шөвгөрч, начин цолоо батлав.
- 2022 он -Үндэсний их баяр наадамд 9 давж Улсын арслан цол хүртэв.
- 2022 он -Ерөнхийлөгчийн цом хүртэв.
- 2023 он – Үндэсний их баяр наадмаар 5 давж, шөвгөрсөн.
- 2024 он -Үндэсний их баяр наадамд 8 давж, үзүүрлэсэн.
- 2025 он
 - Ерөнхийлөгчийн нэрэмжит цомын барилдаанд түрүүлэв.
 - Цагаан сарын барилдаанд 5 давж шөвгөрсөн.
 - Олон улсын хүч чадлын реалити тэмцээн Physical: Asia-д Монголын багийг ахлан амжилттай оролцож, багаараа хоёрдугаар байрт оров.

БАРИЛДААНЫ ӨНГӨ ТӨРХ

Түүнийг дэвжээнд гарахад тайван харц, тооцоотой хөдөлгөөн ажиглагддаг. Суулт, барьц, харцу мэхний мэдрэмж сайтай. Хүчийг зөв хуваарилж, төгсгөлийг шийдэмгий хийдгээрээ ялгарна. “Арслан” цол бол шагнал бус харцуцлага гэж тэр үздэг. Ард түмний итгэлийг даах барилдаан л жинхэнэ ялалт хэмээн ярьдаг нь түүний даруу зангийн илэрхийлэл.

БЛИЦ

Өөрийгөө нэг үгээр илэрхийлбэл?

– Тууштай

Хамгийн үнэтэй мөч?

– Арслан болсон өдөр

Дэвжээн дээрх зарчим?

– Айхгүй, ухрахгүй

Зорилго?

– Цолоо ахиулах

Амжилтын түлхүүр?

– Тогтмол бэлтгэл

Б.ОРХОНБАЯР: ХӨДӨЛМӨРЛӨСӨН ХҮНД Л АЗ ИРДЭГ

ORKHONBAYAR BAYARSAIKHAN

State Lion: Ulisiin Arslan. (a title of national wrestling)

Date of birth: July 1, 1998

Place of birth: Tsagaanuur district, Selenge province

Wrestling career: Since 2014

Club: "Tavan Khan"

Affiliation: "Aldar" Sports Committee

A WARRIOR BORN ON THE ARENA

The winds of the Khangai region and the resilience of rural life shaped him from an early age. He committed himself to training in Mongolian national wrestling in 2014, and within just five years, he emerged prominently at the National Naadam festival, marking a defining moment for a new generation of wrestlers.

In 2019, he first competed in the Mongol Naadam and, with five consecutive victories, earned the title of Ulisiin hartsaga. In 2022, he advanced to nine wins and attained the rank of Ulisiin arslan, a decisive peak in his career. His youth, refined technique, and psychological readiness have made him a wrestler to watch.

CAREER HIGHLIGHTS

* 2019 – Won five rounds at the Mongol Naadam and earned the title of Ulisiin khartsaga.

* 2020 – Reached the later rounds again at the Mongol Naadam, confirming his mongolian wrestling Nachin title.

* 2022 – Won nine rounds at the Mongol Naadam and was awarded mongolian wrestling Arslan title.

* 2023 – Won five rounds at the Mongol Naadam and advanced to the later stages.

* 2024 – Won eight rounds at the Mongol Naadam and finished as runner up.

* 2025

-Won the President's Cup Wrestling Tournament.

-Advanced to the later rounds with five wins at the Lunar New Year wrestling tournament.

-Represented Mongolia as team captain in the international strength reality competition Physical: Asia.

STYLE AND PRESENCE ON THE ARENA

When he steps onto the arena, a calm gaze and measured movements are immediately noticeable. He shows a strong sense of stance, grip, and responsive technique. He stands out for distributing his strength effectively and executing his finishes with decisiveness.

He regards the title of Ulisiin Arslan not as a reward, but as a responsibility. He often says that true victory lies in wrestling in a way that upholds the trust of the people, a reflection of his humility.

BLITZ

-If you were to describe yourself in one word?

- Persistent

Most valuable moment?

-The day awarded with title of "Ulisiin Arslan"

-Principle on the arena?

-No fear, no retreat

-Goal?

-To advance my title

-Key to success?

- Consistent training



B. ORKHONBAYAR: FORTUNE FAVORS THOSE WHO PUT IN THE WORK

Монгол үндэсний бөхийн дэвжээн дээр хүч, тэсвэр, ухаан, ёс жаягийг хослуулан барилддаг залуусын нэг бол Баярсайханы Орхонбаяр. Түүний амьдрал, хүсэл мөрөөдөл, бөхөд дурласан түүх нь хөдөлмөр, тууштай зангийн бодит жишээ юм.

ХӨДӨӨ ӨНГӨРҮҮЛСЭН ХҮҮХЭД НАС

Баярсайханы Орхонбаяр Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд төрж, бага насаа өнгөрүүлжээ. Аав нь цагдаагийн хэсгийн төлөөлөгч байсан тул багаасаа сум сумаар нүүдэллэн амьдарч, амьдралын олон өнгийг эрт мэдэрсэн байна.

Түүний аав Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын уугуул. Харин ээж нь Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумынх.

Зуны амралтаараа өвөө, эмээгийн дээ очиж мал ахуйд нь тусалж өссөн нь түүний хувьд хамгийн дурсамжтай, аз жаргалтай мөчүүдийн нэг.

“Хүн бүрийн бага нас аз жаргалтай байдаг. Харин миний хувьд хөдөө, өвөө эмээтэйгээ өнгөрүүлсэн тэр мөчүүд онцгой сайхан санагддаг” хэмээн тэр дурслаа.

Among the young wrestlers who step onto the arena of Mongolian national wrestling, blending strength, endurance, intelligence, and respect for tradition, is Orkhonbayar Bayarsaikhan. The path he has taken, the dreams he holds, and the way he came to love wrestling stand as a clear reflection of hard work and determination.

GROWING UP IN THE COUNTRYSIDE

Orkhonbayar Bayarsaikhan was born in Tsagaanuur soum of Selenge province and spent his early years. Because his father served as a police officer, their family moved from one soum to another, allowing him to encounter different sides of life from a young age.

His father traces his roots to Nariinteel soum of Uvurkhangai province, while his mother is from Tosontsengel soum of Khuvsgul province.

He spent his summer breaks with his grandparents, helping them tend their livestock. Those days remain among his most cherished memories. As he recalls, “Childhood is a happy time for everyone. For me, though, the days spent in the countryside with my grandparents feel especially meaningful.”

B.Orkhonbayar: Fortune Favors Those Who Put in the Work

МӨРӨӨДӨЛ БА СОНГОЛТ

Багадаа аавыгаа дуурайн цагдаа болно гэж мөрөөддөг байсан тэрбээр ахлах ангид ороод амьдралынхаа замыг өөрчлөх шийдвэр гаргажээ.

“12-р ангидаа бөхөд дуртай байсан болохоор дуртай зүйлээ сонгосон” гэж тэр нэгэн ярилцлагадаа дурдсан байдаг.

Анх 13-14 насандаа бөхөөр хичээллэж эхэлсэн бөгөөд тухайн үед Монголын тамирчдын амжилт, ялангуяа олимпын ялалт түүнийг ихэд урамшуулсан байна. Сумынхаа биеийн тамирын багшийн чөлөөт бөхийн сургалтад орсноор спортын замнал нь эхэлжээ.

DREAMS AND DECISIONS

As a child, he imagined following in his father's footsteps and becoming a police officer. By his final year of secondary school, however, he chose a different direction.

“In the twelfth grade, I realized how much I liked wrestling, so I decided to pursue it,” he said in an interview.

He first took up wrestling at the age of thirteen or fourteen. At the time, the achievements of Mongolian athletes, particularly their Olympic successes, left a strong impression on him. His journey in sport began when he joined the freestyle wrestling training by his soum's physical education teacher.

АНХНЫ ЯЛАГДАЛ-ХАМГИЙН ТОМ СУРГАМЖ

Түүний бөхийн замнал хөгжилтэй, сургамжтай дурсамжаар дүүрэн. Тэрбээр ангийнхаа найзтай хамт сургалтад зургуулаа хичээллэж эхэлжээ. Бэлтгэл дээр анх хооронд нь барилдуулахад чөлөөт бөхийн туршлагатай охинтой таарч, хэд хэдэн удаа шидүүлсэн гэдэг. Тэрбээр энэ тухай “Яагаад унаад байгаагаа ч ойлгохгүй гайхаж байсан. Тэр охин их мэхтэй байсан” хэмээн инээмсэглэн дурссан юм.

ЗОРИЛГО ШАТ АХИСААР

Б.Орхонбаярын зорилго алхам алхмаар ахисан нь тууштай зангийнх нь илрэл байв. Эхлээд сумандаа түрүүлэх, дараа нь аймгийн аварга болох, аймгийн цол авах, улмаар улсын цол хүртэх энэ бүхэн түүний зорилгын шатлал байсан юм. Тиймээс л “Хөдөлмөрлөсөн хүнд аз ирдэг” гэсэн итгэл түүний амьдралын зарчим болжээ. Түүний амжилтын ард гэр бүлийн дэмжлэг том байр суурь эзэлдэг. “Аав, ээж маань анх барилдана гэсэн хойш бүх талаар дэмжсэн” хэмээн тэр онцолсон. Мөн удамд нь сум орон нутагтаа барилддаг хүмүүс байсан бөгөөд ээжийнх нь талд сумын заан цолтой хүн бий.

Өөрийгөө хурд сайтай бөх гэж үнэлдэг ч хэт яарч барилддаг сул талтай гэдгээ нуусангүй. “Барилдааныхаа дараа их юм бодож, ухаардаг” хэмээн тэр хэлсэн нь өөрийгөө байнга хөгжүүлэх эрмэлзлийг нь харуулна.

НААДАМ-БАХАРХЛЫН ОРГИЛ МӨЧ

Үндэсний бөхийн хамгийн үнэ цэнтэй мөч бол яах аргагүй наадам. Жилийн турш хийсэн бэлтгэлийн үр дүнг шалгадаг энэ үе түүний хувьд онцгой. Наадмын өглөө цэнгэлдэх рүү орж явахад төрдөг мэдрэмжийг тэр “Монгол хүн болсноороо бахархах агшин” хэмээн тодорхойлжээ. Засуулд цолоо дуудуулах тэр мөчид цаг хугацаа зогссон мэт санагдаж, ургын дууны шуранхай шиг удаан, уянгалаг сонсогддог аж.

ИРЭЭДҮЙН ЗОРИЛГО

Түүний зорилго зөвхөн бөхөөр хязгаарлагдахгүй. Цаашид суралцах, өөр чиглэлээр хөгжих, дэлхийгээр аялж олон орны соёл, амьдралыг танин мэдэх хүсэлтэй. Гэхдээ хамгийн түрүүнд тэр өөрийн спортын зорилгодоо хүрэхийг чухалчилна.

Монгол үндэсний бөх бол зөвхөн спорт төдийгүй өв соёл, ёс жаяг, түүхийн амьд илэрхийлэл. Энэ бүхнийг өөртөө шингээж, тээж яваа залуусын нэг бол Баярсайханы Орхонбаяр.

Түүний хэлсэнчлэн “Ямар ч зүйлд хөдөлмөрлөсөн хүнд л аз ирдэг.” Энэ үг түүний амьдралын замнал төдийгүй олон залууст урам зориг өгөх үнэн билээ.

A FIRST LOSS, A LASTING LESSON

His experience in wrestling is filled with moments that are both memorable and instructive. He was one of six children who initially joined the training, attending alongside a classmate. In his first bout, he faced a girl who already had experience in freestyle wrestling and was thrown repeatedly. Speaking about it, he said with a smile, “I could not even understand why I kept falling. She had a lot of techniques.”

STEADY PROGRESS TOWARD HIS GOALS

Orkhonbayar’s ambitions have advanced step by step, reflecting his persistence. First came the goal of becoming a provincial champion, then winning at the district level, earning a province title, and ultimately achieving a national title. The belief that effort brings fortune has become central to how he approaches life.

Family support has played a significant role in his progress. “From the moment I said I would take up wrestling, my parents have supported me in every way,” he noted. Wrestling is also present in his family background, with individuals who have competed at the local level, including a district elephant title holder on his mother’s side.

He considers speed to be one of his strengths, though he admits that he can sometimes rush during matches. “After each bout, I spend a lot of time thinking and reflecting,” he said, revealing his constant effort to improve.

NAADAM, A MOMENT OF PRIDE

The most meaningful occasion in Mongolian national wrestling is Naadam. It is the time when a year’s worth of training is put to the test, making it especially significant for him. He describes the feeling of walking into the stadium on the morning of Naadam as “a moment of pride in being Mongolian.” When his title is called by the zasuul (each wrestler has encourage, he calls the title) time seems to slow, and the sound stretches out, long and melodic, like the drawn notes of a traditional long-song.

LOOKING AHEAD

His aspirations extend beyond wrestling. He hopes to continue his education, grow in other areas, and travel to experience the cultures and ways of life in different countries. For now, however, his main focus remains on reaching his goals in sport.

Mongolian national wrestling is more than a sport. It carries heritage, tradition, and history within it. Orkhonbayar Bayarsaikhan is one of the young men who carries that legacy forward.

As he puts it, “Fortune comes to those who put in the work.” This idea not only reflects his own journey but also serves as encouragement for many young people.



We are conveniently located 55km west of Ulaanbaatar city and offer a wide range of riding options at our stable. From 25-minute tryouts to 5-day wilderness treks, combining these with our traditional Mongolian cultural program and resort stay makes it an unmissable adventure for any traveler in Mongolia.

www. horsemongolia.com
email: info@horsemongolia.com
facebook: Mongol Nomadic Tourist Camp
tel: +976-99883027. 99898422. 88324411. 99118573



"МОНГОЛЫН ЗАЛУУ ХҮН АМ БОЛ ИРЭЭДҮЙН ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР ЮМ"

THE DRIVING FORCE OF MONGOLIA'S FUTURE DEVELOPMENT IS ITS YOUTH

Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
Залуучууд, спортын
бодлогын зөвлөх
Даваанямын
Даваадоржтой
ярилцлаа.

Interview
with Davaadorj
Davaanyam, the
Youth Development
Advisor to the
President of
Mongolia



-Монгол Улс залуучуудын орон. Хүн амын бүтцэд залуучуудын эзлэх хувь хэд байна вэ. Ойрын ирээдүйд энэ бүтэц хэрхэн өөрчлөгдөх вэ. Үүнийг дагаад нийгэм, эдийн засаг, соёлын орчинд болон хөдөлмөрийн зах зээлд бий болох өөрчлөлт юу вэ?

-Монгол Улс нийт хүн амын ойролцоогоор 35 хувийг 15–35 насны залуучууд эзэлж байна. Харин 0–35 насны өргөн хүрээгээр авч үзвэл энэ үеийнхэн нийт хүн амын 64 орчим хувийг бүрдүүлж байна. Энэ тоо баримт нь Монгол Улсын хүн амын бүтэц залуу, эрч хүчтэй байгааг тодорхой харуулж, ирээдүйгээ өөрсдөө бүтээх асар том нөөц, боломж бий гэдгийг илэрхийлж байна.

Энэ залуу бүтэц бидэнд юу өгч байна вэ? Нэг талаас ажиллах хүчний нөөц ихтэй, шинэ санаа, инновацийг дэлгэрүүлэх бэлэн үе давамгайлж байгаа нь улсын хөгжил хурдацтай, дэвшилттэй хөгжих боломжийг өгч чадна.

-Mongolia is a country of youth. What share of the population is made up of young people? How is this structure likely to change in the near future? What changes will follow in the social, economic, and cultural environment, as well as in the labour market?

-Mongolia is a country of youth. At present, young people aged 15 to 35 make up about 35 percent of the total population. When viewed more broadly, those aged 0 to 35 account for roughly 64 percent. These figures clearly show that Mongolia has a young and energetic population structure and point to considerable resources and opportunities for shaping its own future.

What does this youthful structure offer? On the one hand, a large labour force and a generation ready to spread new ideas and innovation create favourable conditions for rapid and progressive development.

Нөгөө талаас залуу үеийн идэвхтэй оролцоо нь нийгмийн бүх салбарт шинэчлэл, өөрчлөлтийг түргэсгэх боломжийг нээж өгч байна.

Ойрын 10-20 жилд хүн амын бүтэц тодорхой хэмжээнд өөрчлөгдөнө. Төрөлтийн түвшин тогтворжиж, дундаж наслалт нэмэгдэхийн хэрээр залуучуудын эзлэх хувь бага зэрэг буурах боловч (2040 он гэхэд ойролцоогоор 29 хувьд хүрэх төлөвтэй) Монгол Улс залуу хэв шинжээ хадгалсан, харьцангуй тэнцвэртэй бүтэцтэй улс хэвээр байна. Энэ өөрчлөлт нь бидэнд илүү тогтвортой, урт хугацаанд хөгжих суурийг бүрдүүлнэ. Хамгийн чухал нь энэ нь сорилтоос илүү шинэ боломжуудыг авчирна. Энэ нь хүн амын “демографик цонх” (ажиллах насны хүн ам давамгайлсан үе) ашиглах боломж нээгдэж, хөгжлийн хурдыг нэмэгдүүлэхэд тусална.

Хэрэв бид залуу үеийн боловсрол, ур чадвар, нийгмийн идэвхжилд чиглэсэн бодлогоо амжилттай хэрэгжүүлбэл Монгол Улс мэдлэгт суурилсан, чадвартай иргэд давамгайлсан нийгэм рүү шилжинэ. Залуучуудын тоо их байх тусам боловсролын системийг илүү үр ашигтай, орчин үеийн болгох, шинэ үеийн удирдагчдыг бэлтгэхэд том давуу тал болно. Ингэснээр нийгмийн тэгш байдал нэмэгдэж, ирээдүйн сорилтуудад илүү бэлэн, идэвхтэй иргэд бий болно.

Эдийн засгийн хувьд залуу ажиллах хүч ихтэй энэ үед хэрэв бид залуучуудад зөв хөрөнгө оруулалт хийж чадвал (боловсрол, мэргэжлийн сургалт, эрүүл мэнд, ажлын байр бүрдүүлэлт) манай улс өндөр бүтээмжтэй, инновацид суурилсан, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай эдийн засагтай орон болж чадна. Хөдөлмөрийн зах зээлд залуучуудын оролцоо нэмэгдэж, технологи, үйлчилгээ, тогтвортой хөгжил, бүтээлч аж үйлдвэр зэрэг шинэ салбарууд хөгжих боломжтой. Гэхдээ энэ нь зөвхөн тоо хэмжээ биш, чанартай ур чадвар, ажлын байрны таарамжтай байдлыг шаардана. Ингэж чадвал эдийн засгийн өсөлт хурдасч, ажилгүйдэл буурч, бүтээмж нэмэгдэнэ. Соёлын орчинд ч энэ залуу бүтэц том нөлөө үзүүлнэ. Залуучууд давамгайлсан нийгэмд уламжлалт соёл, өв уламжлалыг шинэчлэлтэй хослуулсан, динамик, бүтээлч соёлын орчин бий болно. Залуу үеийн шинэ санаачилгаар Монголын соёл, урлаг, өвөрмөц үнэт зүйлс дэлхийн түвшинд илүү хүчтэй нөлөөлөх боломж нээгдэнэ. Энэ нь зөвхөн соёлын баялаг биш, нийгмийн нэгдэл, ирээдүйн үнэ цэнийг бүрдүүлэх чухал хүчин зүйл болно. Тиймээс Монгол Улсын хувьд өнөөгийн залуу бүтэц бол зүгээр нэг статистик үзүүлэлт биш, харин хөгжлийн стратегийн хамгийн том нөөц юм. Бид энэ боломжийг бүрэн ашиглаж чадвал залуучуудаа боловсрол, ур чадвар, ажлын байраар хангаж, тэднийг нийгэм, эдийн засаг, соёлын бүх үйл явцад идэвхтэй оролцуулбал ойрын арван жилүүдэд хүний хөгжил, эдийн засгийн өсөлт, соёлын нөлөөллөөрөө бүс нутагтаа тэргүүлэх боломж бүрэн бий. Энэ бол зөвхөн залуучуудын боломж биш, Монгол Улсын ирээдүйн хөгжлийн түлхүүр юм.

-Дээрх өөрчлөлтийг угтуулсан бодлогын болон хандлагын өөрчлөлт шаардлагатай гэж үзвэл гол философи, концепц ямар байх вэ?

-Юуны өмнө гол философийг “хүн төвтэй хөгжил”-өөс “чадвар төвтэй хөгжил” рүү шилжүүлэх гэж харж байна. Өөрөөр хэлбэл, хүн амын тоо, залуу үе нь өөрөө давуу тал биш, харин тухайн хүний мэдлэг, ур чадвар, бүтээмж нь бодит давуу тал болдог үе шат руу орж байна. Энэ үед бид бодлогоор, сэтгэлгээний түвшиний өөрчлөлт хийх шаардлагатай байна. Үүнийг тод жишээ бол “Ерөнхийлөгчийн илгээлт 2100” хөтөлбөр юм. Монгол

On the other hand, the active participation of young people creates opportunities to accelerate renewal and change across all areas of society.

Over the next 10 to 20 years, the population structure will change to some extent. As the birth rate stabilizes and life expectancy increases, the share of young people will decline slightly, expected to reach about 29 percent by 2040, while Mongolia will retain its youthful character with a relatively balanced structure. This change will provide a more stable foundation for long-term development. Most importantly, it will bring new opportunities rather than challenges, including the chance to make use of the demographic window, a period when the working-age population is predominant, helping to increase the pace of development.

If policies aimed at improving education, skills, and social participation among young people are implemented effectively, Mongolia will move towards a knowledge-based society where capable citizens predominate. A large youth population offers a strong advantage in making the education system more efficient and modern and in preparing a new generation of leaders. This will lead to greater social equality and a population that is better prepared and more active in meeting future challenges.

From an economic perspective, during this period of a large young workforce, if the right investments are made in young people, including education, vocational training, health, and job creation, Mongolia can become an economy marked by high productivity, innovation, and competitiveness in the global market. Youth participation in the labour market will increase, and new sectors such as technology, services, sustainable development, and creative industries can grow. At the same time, this requires not only numbers but also strong skills and a proper match between workers and jobs. If achieved, economic growth will accelerate, unemployment will fall, and productivity will increase.

This youthful structure will also have a strong impact on the cultural environment. In a society where young people are predominant, a dynamic and creative cultural setting will emerge, bringing together tradition and heritage with renewal. Through the initiatives of the younger generation, Mongolian culture, art, and distinctive values will gain a stronger presence at the global level. This will serve not only as cultural wealth but also as an important factor in strengthening social unity and shaping future values.

For Mongolia, this youthful structure is not simply a statistical figure but the most important resource for development strategy. If this opportunity is fully realized by providing young people with education, skills, and employment and by ensuring their active participation in all social, economic, and cultural processes, there is a clear possibility that in the coming decades Mongolia will take a leading place in its region in terms of human development, economic growth, and cultural influence. This is not only an opportunity for young people but also the key to Mongolia's future development.

-If policy and attitudinal adjustments are required in anticipation of the above changes, what should be the core philosophy and concept?

-First, the central philosophy should shift from human-centered development to capability-centered development. In other words, population size and a large youth cohort no longer constitute an advantage in themselves; rather, the real advantage lies in the knowledge, skills, and productivity of each individual. This is the stage now being entered. Accordingly, changes are required both in policy and at the level of mindset.

Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилсан, урт хугацаанд хүний хөгжлийг дэмжих зорилготой үндэсний хэмжээний боловсролын хөтөлбөр юм. Тус тэтгэлэгт хөтөлбөр бол сум, хороо бүрийн шилдэг хүүхдийг шалгаруулж, бэлтгэл хөтөлбөрт хамруулан гадаадын шилдэг их дээд сургуульд сурах болзлыг хангахад нь бэлтгэж, улмаар суралцуулж, төгсөөд ирэхэд нь орон нутгийнхаа хөгжлийг түүчээлэхэд томилон ажиллуулах зорилготой цогц хөтөлбөр юм. Мөн Илгээлтийн эзэд суралцаж буй улс орныхоо хэл соёл, давуу тал, тэргүүн туршлагаас суралцан ирж орон нутагтаа түгээн дэлгэрүүлж, нутагшуулан, цаашид ч орон нутгаа суралцсан улстайгаа холбох дипломат харилцааны нэгэн гүүр болох учиртай. Тус хөтөлбөрийн хүрээнд 1052 тэтгэлгийн эзэд хичээл зүтгэл, сурлага хөдөлмөрийнхөө үр дүнгээр анхны даваагаа амжилттай давж, АНУ, Их Британи, Герман, Франц, Австри, Чех, Канад, Польш, Австрали, Орос, Хятад, Япон, Солонгос, Унгар, Литва, Турк, Энэтхэг, Вьетнам, Лаос, Куба, Казахстан зэрэг 21 улсын их дээд сургуулиудад элсэж, эрдэм номдоо шамдан суралцаж байна. “Ерөнхийлөгчийн илгээлт 2100” хөтөлбөрөөр бэлтгэгдсэн залуучууд Монгол Улсын хөгжилд чанарын үсрэлт авчрах стратегийн нөлөөтэй гэж харж байна. Тэдний авч ирэх хамгийн том өөрчлөлт нь зөвхөн мэдлэг биш, харин ажиллах арга барил, хандлага, бүтээмжийн шинэ стандарт байх болно гэж үзэж байна.

Эдийн засгийн хувьд эдгээр залуус өндөр нэмүү өртөг шингэсэн салбаруудыг хөгжүүлэхэд түлхэц өгнө. Тухайлбал технологи, инновац, стартап, санхүү, ногоон хөгжил зэрэг чиглэлд шинэ санаа, шинэ бизнес загваруудыг нутагшуулах боломжийг бодитоор бий болгоно. Ингэснээр Монгол Улс зөвхөн түүхий эдэд түшиглэсэн эдийн засгаас мэдлэгт суурилсан эдийн засаг руу шилжих суурь бэхжинэ.

Төрийн бодлогын түвшинд ч нөлөө нь тодорхой харагдана. Залуу үеэс төрийн албанд орж ирснээр шийдвэр гаргалт илүү нотолгоонд суурилсан, ил тод, урт хугацааны стратегитэй болох боломж нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, бодлого боловсруулах чанар өөрөө шинэ шатанд гарна.

Нийгмийн хувьд эдгээр залуус нь зөвхөн

A clear example of this is the “President’s Scholar-2100” Scholarship Program. Initiated by the President of Mongolia, Khurelsukh Ukhnaa, it is a national education program designed to support human development over the long term. The program is aimed at preparing a new generation of young people with world-class education who are capable of creating value in their own country, forming the foundation of Mongolia’s future development.

In addition, scholarship recipients are expected to learn from

the language, culture, strengths, and advanced practices of the countries in which they study, return to disseminate and localize this knowledge in their home regions, and serve as a bridge for diplomatic engagement by connecting their localities with the countries where they studied. Within the framework of the “President’s Scholar-2100” program, 1,052 recipients have successfully passed the initial stage through their effort and academic performance and have enrolled in universities across 21 countries, including the United States, the United Kingdom, Germany, France, Austria, the Czech Republic, Canada, Poland, Australia, Russia, China, Japan, the Republic of Korea, Hungary, Lithuania, Turkey, India, Vietnam, Laos, Cuba, and Kazakhstan, where they are diligently pursuing their studies.

The “President’s Scholar-2100” program is not merely a scholarship for study but a major development program and the most significant investment in national and local development. It is expected that the young people trained through this program will exert a strategic impact by bringing about a qualitative leap in Mongolia’s development.

From an economic perspective, they will stimulate the development of high value-added sectors. In particular, they will create real opportunities to introduce new ideas and business models in areas such as technology, innovation, startups, finance, and green development.

In this way, the foundation will be

strengthened for Mongolia to move from a resource-based economy towards a knowledge-based economy.

Their influence will also be evident at the level of public policy. As members of the younger generation enter public service, decision-making is likely to become more evidence-based, transparent, and oriented towards long-term strategy. In other words, the quality of policy formulation itself will advance to a new level.

Socially, these young people will not only be professionals

Монгол Улсын хувьд өнөөгийн залуу бүтэц бол зүгээр нэг статистик үзүүлэлт биш, харин хөгжлийн стратегийн хамгийн том нөөц юм. Бид энэ боломжийг бүрэн ашиглаж чадвал залуучуудаа боловсрол, ур чадвар, ажлын байраар хангаж, тэднийг нийгэм, эдийн засаг, соёлын бүх үйл явцад идэвхтэй оролцуулбал ойрын арван жилүүдэд хүний хөгжил, эдийн засгийн өсөлт, соёлын нөлөөллөөрөө бүс нутагтаа тэргүүлэх боломж бүрэн бий.

For Mongolia, this youthful structure is not simply a statistical figure but the most important resource for development strategy. If this opportunity is fully realized by providing young people with education, skills, and employment and by ensuring their active participation in all social, economic, and cultural processes, there is a clear possibility that in the coming decades Mongolia will take a leading place in its region in terms of human development, economic growth, and cultural influence.



мэргэжилтэн биш, харин өөрчлөлтийн манлайлагчид байна. Тэд ёс зүй, хариуцлага, мерит зарчим, хамтын ажиллагааны соёлыг түгээн дэлгэрүүлж, залуу үеийн үнэт зүйлийг эерэг чиглэлд өөрчлөх нөлөө үзүүлнэ.

Хөдөлмөрийн зах зээлд тэд өндөр ур чадвар, олон улсын түвшний өрсөлдөх чадвараараа дотоодын бүтээмжийг өсгөж, байгууллагуудын чанарын босгыг дээшлүүлнэ. Ингэснээр Монголд ажиллах хүчин шинэ үед хүрч чадна. Эцэст нь хэлэхэд, “Ерөнхийлөгчийн илгээлт 2100” хөтөлбөрөөр бэлтгэгдсэн залуучууд бол Монгол Улсын ирээдүйн хөгжлийн хурдасгуур хүчин юм.

-Ерөнхийлөгчийн дэргэд “залуучуудын асуудал” хариуцсан зөвлөхийн орон тоо бий болсон нь санаандгүй бус зайлшгүй хэрэгцээ шаардлага байх. Цаашид “залуучууд”-ын бодлогыг дараа дараагийн Ерөнхийлөгч нар онцгойлон анхаарах, энэ уламжлалыг хадгалаасай гэж хүсэж байгаа байх. Хэрэв тийм бол үндэслэлүүдээ тоочно уу.

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд залуучуудын асуудал хариуцсан зөвлөхийн орон тоо шинээр бий болсон нь огт санамсаргүй шийдэл биш, харин улс орны өнөөгийн бодит байдал, ирээдүйн хөгжлийн гүнзгий шаардлагаас үүдэлтэй чухал алхам юм. Юуны түрүүнд Монгол Улс залуу хүн амтай орон хэвээр байгаа ч энэ давуу талыг жинхэнэ хөгжлийн нөөц болгон хувиргах цаг болжээ. Залуучуудын санаачлага, шинэ сэтгэлгээ улсын хөгжлийг эрчимтэй, хурдан өөрчлөгдөхөд чухал ач холбогдолтой болж чадна. Гэхдээ энэ боломжийг ашиглахын тулд залуучуудын асуудлыг төрийн бодлогын захад биш, гол төвд нь оруулах шаардлагатай. Ерөнхийлөгчийн дэргэд уг асуудлаар

but also leaders of change. They will promote ethical conduct, responsibility, merit-based principles, and a culture of cooperation, shaping the values of the younger generation in a positive direction.

In the labour market, their high-level skills and international competitiveness will raise domestic productivity and elevate organizational standards. This will enable Mongolia's workforce to reach a new stage of development. In conclusion, the young people prepared through the “President’s Scholar-2100” program constitute a driving force for Mongolia’s future development. If their knowledge and capabilities are supported through sound policy and if conditions are created for them to work productively in their own country, there is strong reason to believe that Mongolia will advance to a new stage of development in the coming decades.

-The establishment of a position for an advisor on youth affairs under the President was not incidental but arose from clear necessity. It is reasonable to expect that future Presidents will continue to prioritize youth policy and preserve this practice. If so, could you outline the key reasons?

The creation of a presidential advisor responsible for youth affairs is not a chance decision but a considered step shaped by the country’s present circumstances and the long-term demands of its development.

First, Mongolia remains a country with a young population, yet the moment has arrived to turn this advantage into a genuine source of development. The initiative and fresh thinking of young people can play a decisive role in accelerating change. However, for this potential to be realized, youth issues must be brought to the center of public policy rather than left at its margins. Having an advisor at the presidential level ensures that the voice of young people reaches the highest level of state authority directly and that policy becomes more future-oriented and grounded in long-term priorities.

зөвлөх байх нь залуу үеийн дуу хоолойг шууд төрийн өндөр түвшинд хүргэж, бодлогыг илүү ирээдүй рүү чиглэсэн, урт хугацааны болгох боломжийг олгоно. Хоёрдугаарт, бид одоо “хүн төвтэй хөгжил”-өөс “чадвар төвтэй хөгжил” рүү шилжих шатандаа явж байна. Залуучуудын тоо олон байгаа нь өөрөө давуу тал биш, харин тэдний мэдлэг, ур чадвар, бүтээмж, инновацийн сэтгэлгээ жинхэнэ үнэ цэн болж байгаа үе юм. Энэ шилжилтийг амжилттай хийхийн тулд боловсрол, мэргэжлийн сургалт, гадаадад суралцсан залуусыг эх орондоо татах, орон нутгийн хөгжлийг тэдний гараар бий болгох зэрэг асуудлуудыг нэгдсэн байдлаар удирдах механизм хэрэгтэй.

Гуравдугаарт, залуучуудын асуудал боловсрол, эрүүл мэнд, ажилгүйдэл, орон сууц, соёл, нийгмийн оролцоо гэх мэт олон салбарыг хамардаг. Эдгээрийг тус тусад нь шийдвэрлэх биш, улсын хөгжлийн ерөнхий стратегид нэгтгэн авч үзэх шаардлагатай. Ерөнхийлөгчийн зөвлөх байх нь эдгээр асуудлыг нэгдмэл бодлого болгон хувиргаж, салбар хоорондын уялдааг сайжруулна. Ингэснээр төрийн шийдвэрүүд илүү уялдаатай, залуу үеийн бодит хэрэгцээнд нийцсэн байх болно.

Дөрөвдүгээрт, бодлогын тогтвортой байдал чухал. Ерөнхийлөгч солигдох үед ч залуучуудтай холбоотой стратегийн чиглэл тасралтгүй үргэлжлэх ёстой. Зөвлөх байснаар энэ уламжлалыг бий болгож, улс төрийн өөрчлөлтөөс үл хамааран чухал асуудлуудыг төрийн өндөр түвшинд байнгын анхааралд байлгана. Энэ нь Монгол Улсын хөгжлийг үе дамжсан, тогтвортой болгох нэгэн чухал баталгаа болно.

Тавдугаарт, бодит ажил үүнийг аль хэдийн нотолж байна. Анх ажлаа авсан даруйдаа www.esan.mn цахим номын санг байгуулж, 1-12-р ангийн сурах бичгүүд, төрийн шагналт бүтээлүүд, “Монголын нууц товчоо”-ны дэлгэрэнгүй тайлбарыг үнэ төлбөргүй байршуулсан нь цаг үеэ олсон, олон талын ач холбогдолтой алхам болсон гэж бодож байна. Ялангуяа гадаадад амьдарч буй монгол хүүхдүүд эх хэл, соёлоо алдалгүй, технологийн тусламжтайгаар суралцах боломж олгосон нь залуу үеийг эх оронтойгоо холбох, боловсролын тэгш байдлыг нэмэгдүүлэх бодлогын тод жишээ болсон.

Эцэст нь хэлэхэд, Ерөнхийлөгчийн дэргэд залуучуудын асуудал хариуцсан зөвлөх байх нь залуучуудыг “асрах” биш, тэднийг улс орны хөгжлийн гол түлхүүр, ирээдүйн манлайлагчид гэж харах шинэ сэтгэлгээний илэрхийлэл юм. Энэ уламжлалыг дараа дараагийн Ерөнхийлөгч нар хадгалж, бэхжүүлбэл Монгол Улс чадвар төвтэй хөгжлийн замаар илүү итгэлтэй, хурдан урагшилж, залуу үеийнхээ эрч хүчийг жинхэнэ утгаар нь ашиглах боломжтой болно. Энэ бол зөвхөн бүтэц нэмэх асуудал биш. Энэ бол Монгол Улсын ирээдүйг өөрсдөө бүтээх чадвартай шинэ үеийг бэлтгэх стратегийн шийдэл юм.

“Монгол залуу хүн гэж ийм байх ёстой” гэж боддог, үндэсний онцлог бүхий тодорхойлолт, төсөөлөл Танд байдаг уу. Түүнийг бүтээхийн тулд өнөөдөр та юу хийхийг зорьж байна вэ. Мөн тэрхүү зорилгоосоо юуг нь амжуулж, хийж чадсан бэ?

-Миний хувьд “Монгол залуу хүн” гэдэг ойлголт бол зөвхөн тодотгол биш, харин үнэт зүйл, хандлага, хариуцлагын илэрхийлэл гэж хардаг. Бид Чингис хааны үеэс эхтэй их түүхтэй ард түмэн. Тэрбээр зөвхөн эзэнт гүрэн байгуулаад зогсохгүй, харин өөр өөр соёл, угсаатныг нэгтгэж, хууль дүрэм, худалдаа, мэдлэгийн солилцоог дэмжсэн аугаа удирдагч байсан билээ. Миний төсөөллөөр

Second, the country is now in a phase of transition from human-centered development to capability-centered development. The size of the youth population is no longer an advantage in itself; rather, their knowledge, skills, productivity, and innovative thinking have become the true source of value. To manage this transition effectively, a coordinated mechanism is required to address education, vocational training, the return of students educated abroad, and the role of young people in advancing local development.

Third, youth issues span multiple sectors, including education, health, unemployment, housing, culture, and social participation. These cannot be addressed in isolation but must be integrated within the overall development strategy of the state. The existence of a presidential advisor makes it possible to bring these issues into a unified policy framework and to strengthen coordination across sectors. As a result, public decisions become more coherent and more closely aligned with the real needs of young people.

Fourth, policy continuity is essential. Even as Presidents change, strategic directions related to youth must continue without interruption. The presence of an advisor helps to establish this continuity and ensures that key issues remain under consistent attention at the highest level of government, regardless of political change. This serves as an important guarantee of sustained and intergenerational development.

Fifth, practical measures already demonstrate the value of this approach. Shortly after assuming office, the establishment of the digital library www.esan.mn, with free access to textbooks for grades 1 to 12, state prize-winning works, and a detailed commentary on the “Secret History of the Mongols,” represented a timely and meaningful initiative. In particular, it has provided Mongolian children living abroad with the opportunity to study through technology without losing their language and cultural connection, thereby strengthening ties with their homeland and promoting greater equality in access to education.

In conclusion, the presence of an advisor on youth affairs under the President reflects a shift in perspective that sees young people not as a group to be supported passively but as the central drivers of national development and the future leaders of the country. If this practice is maintained and strengthened by successive Presidents, Mongolia will be better positioned to advance with confidence along a path of capability-centered development and to make full use of the energy and potential of its younger generation.

This is not merely a matter of adding an institutional position. It is a strategic decision aimed at preparing a new generation capable of shaping the country's future through its own capacity.

-Do you have a clear, nationally distinctive definition or vision of what a Mongolian young person should be like? What are you aiming to do today to shape that ideal? What have you already managed to accomplish toward that goal?

-For me, the idea of a Mongolian young person is not merely a description but an expression of values, attitude, and responsibility. Above all, a Mongolian should cherish the homeland, possess a deep understanding of history and culture, and be able to connect these with modern development. We are a people with a great history that traces back to Chinggis Khaan. He was not only the founder of an empire, but also a leader who united diverse cultures and peoples and supported law, trade, and the exchange of knowledge. In my view, a Mongolian young person should embody both tradition and renewal, combining



Монгол залуу хүн гэдэг нь уламжлал ба шинэчлэлийг хослуулсан, үндэсний ухамсар дэлхийн сэтгэлгээтэй хүн байх нь бидний зорих дүр төрх гэж ойлгож байна. Дэлхийд Монгол залуучууд урлаг, спортын олон төрлөөр манлайлж чадаж байна. Жишээлбэл, сагсан бөмбөг, чөлөөт бөх, бокс зэрэгт олон улсын тавцанд амжилттай оролцож, үндэсний нэрийг өргөж байгаа нь бахархалтай. Энэ манлайллын түүчээ улам хүчээ авна гэдэгт итгэлтэй байгаа. Залуучууд дүү нар маань эх орноороо бахархаж, хайрлаж байгаасай гэж “Монгол төрийн далбаа” төслийг санаачилсан. Улаанбаатар цэцэрлэгт хүрээлэнд 60 метрийн өндөртэй, 16x8 хэмжээтэй Төрийн далбаа байнга мандаж байгааг харахад сэтгэлд үнэхээр сайхан байдаг. Энэ далбаа Монголын тэнгэрт намиран намирах бүрдээ залуу үеийнхэндээ үндэсний бахархлын бэлгэдэл болж, эх оронч сэтгэлгээг төрүүлэх болно гэдэгт би итгэдэг. Монгол хүн гэдэг бол өв соёл, түүхээрээ бахархаж, түүнийгээ орчин үеийн шинжлэх ухаан, технологи, дэлхийн өрсөлдөөнд амжилттай ашиглаж чаддаг, хариуцлагатай иргэн байх ёстой.

Энэ төсөөллийг бодит байдал болгохын тулд өнөөдөр би залуучуудтай уулзаж, ярилцаж, түүх соёлоо судлах, спортоор хичээллэх, шинэ мэдлэг эзэмшихийг уриалж, практик төслүүдийг хэрэгжүүлэхийг зорьж байна. Өнгөрсөн хугацаанд “Монгол төрийн далбаа” төслийг амжилттай хэрэгжүүлж, хуулийн өөрчлөлтийг батлуулж, Улаанбаатар цэцэрлэгт хүрээлэнд Монгол Улсын далбааг байнга мандуулах болсон нь миний зорилгын нэг том хэсгийг биелүүлсэн чухал алхам болсон. Энэ бүхэн цаашдаа улам өргөжин, монгол залуу үеийнхний үндэсний ухамсар, дэлхийн сэтгэлгээг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт би итгэлтэй байна.

Энэ бол миний хувьд зөвхөн нэг эхлэл юм. Цаашид ч монгол хүний үнэт чанарыг улам тодотгож, үндэснийхээ зан чанар, ёс суртахууныг орчин үеийн хөгжилтэй уялдуулан хөгжүүлж, Монголынхоо ирээдүйг илүү тод, илүү хүчтэйгээр бүтээхэд хувь нэмрээ оруулахыг хичээх болно.

a strong national consciousness with a global outlook. Today, Mongolian youth are already demonstrating leadership in various fields such as the arts and sport. For example, in basketball, wrestling, and boxing, they compete successfully on the international stage and elevate the national name. I am confident that this leadership will continue to strengthen. With the aim that younger generations feel pride in and love for their country, I initiated the “Mongolian State Flag” project. In accordance with this decree, the State Flag is now ceremonially displayed and permanently hoisted at National Park. Seeing the 60 meter flagpole with a 16x8 meter State Flag flying continuously in the park brings a deep sense of pride. Each time it waves in the Mongolian sky, I believe it serves as a symbol of national pride for the younger generation and inspires a sense of patriotism.

A Mongolian person should take pride in heritage and history while also being able to apply them effectively within modern science, technology, and global competition, and act as a responsible citizen.

To turn this vision into reality, I am working to engage with young people, hold discussions, and encourage them to study history and culture, take part in sports, and acquire new knowledge, while also implementing practical projects. Over this period, successfully carrying out the “Mongolian State Flag” project, securing the adoption of legal amendments, and ensuring the permanent display of the national flag in the National Park have marked an important step in achieving this goal.

This is only the beginning. Going forward, I will continue striving to further define the core qualities of a Mongolian person, to develop national character and ethical values in harmony with modern progress, and to contribute to building a stronger and more clearly defined future for Mongolia.

LUXURY


5-STAR

COMFORT

WHERE COMFORT MEETS CONSCIOUS LIVING

Recycling, reducing, and rethinking
hospitality

Each Best Western branded hotel is independently owned and operated.




Best Western Premier Tuushin Hotel

Prime Minister Amar's street, Ulaanbaatar 14200, Mongolia
P: +976 (11) 323162

VISIT OUR WEBSITE
FOR MORE

tuushinhotel.com





FROM EXTINCTION TO THE PATH OF RECOVERY

Г.ДАШДУЛАМ

ХУСТАЙ: Тахийн хамт эх нутагтаа эргэн ирсэн итгэл

Хустайн нуруунд очиход байгаль өөрөө ярьж байгаа мэт санагдана. Хусан ойн чимээ, хээрийн салхи, алсад сүрэглэн бэлчсэн тахь энэ бүхэн зүгээр нэг байгалийн дүр зураг биш. Энэ бол зүгээр нэг тусгай хамгаалалттай газар биш. Монгол Улс байгаль хамгааллыг үгээр бус, үйлдлээрээ хийж чаддагийг харуулсан газар. Энд тахь эргэн ирсэн. Тахийн хамт итгэл, хариуцлага, урт хугацааны ухаалаг бодлого нутагшсан юм.

G.DASHDULAM

KHUSTAI: The trust of the przewalski horse returning to its native land

Standing on the Khustai Mountains, one feels as if nature itself is speaking. The rustle of birch forests, the steppe wind, and herds of Przewalski horses grazing in the distance are not merely a landscape. This is not just a specially protected area; it is a place that demonstrates that Mongolia can protect nature not only in words, but through action. Here, the Przewalski horse has returned. Along with it, trust, responsibility, and long-term wisdom have taken root.



ТАХИЙН ХАМТ ИТГЭЛ, ХАРИУЦЛАГА УХААЛАГ БОДЛОГО НУТАГШСАН ХУСТАЙ

KHUSTAI: WHERE SHARED TRUST, RESPONSIBILITY, AND LONG-TERM WISDOM HAVE TAKEN ROOT

ТАХИЙН УДАМТ МОНГОЛ АДУУ...

Монголчууд эртнээс дуу хуур, үлгэр, домогтоо тахь хэмээх хөхтөн амьтныг мөнхөлсөн байдаг. Чухам тахь гэдэг үгийг ч зүгээр нэг өгөөгүй гэлтэй. Тахих шүтэх гэдэг утгаараа ч оноож өгсөн нэр болов уу?

Тахь бол олон зуун жилийн турш монголчуудын домог, аман зохиолд амьдарсаар ирсэн амьтан. Гэхдээ хэзээ ч гаршуулж байгаагүй, хүн төрөлхтөнд бууж өгөөгүй цорын ганц адуу. Генетикийн хувьд тахь 66 хромосомтой бол гэрийн адуу 64 хромосомтой. Нэг өвгөөс гаралтай ч 200-300 мянган жилийн өмнө салсан гэдгийг судалгаагаар нотолсон. Тахь нь гаднах төрхөөрөө монгол адуутай ойролцоо боловч хул шар өнгө, богино тачир сүүл, байнга босоо дэл, цагаан ам нь түүнийг ялгаруулна.

THE MONGOLIAN LINEAGE OF THE PRZEWAWSKI HORSE...

For centuries, Mongolians have immortalized the Przewalski horse in songs, tales, and legends. The very word takhi was not given lightly. Perhaps it was bestowed with a sense of reverence and worship.

The Przewalski horse has lived for centuries in Mongolian legends and folk literature. Yet it is the only horse that has never been domesticated and has never yielded to humankind. Genetically, the Przewalski horse has 66 chromosomes, while the domestic horse has 64. Although they share a common ancestor, research suggests that they diverged either two to three thousand years ago, or two hundred to three hundred thousand years ago. In appearance, the Przewalski horse resembles the Mongolian horse, but its dun-yellow coat, short stiff tail, permanently upright mane, and white muzzle clearly set it apart.

МӨХЛИЙН ИРМЭГЭЭС ЭРГЭН ИРСЭН НЬ

Оросын судлаач, аялагч Михайл Пржевальский XIX зуун 1800-аад оны сүүлээр нутгийн монгол анчнаас бэлэг болгон тахийн арьс, гавлын яс авч, эрдэм шинжилгээний судалгаанд хүргэснээр дэлхийд тахийг шинжлэх ухааны түвшинд анх таньсан гэдэг. Тэр үеэс эхлэн Пржевальскийн адуу хэмээн нэрлэгдсэн тахь Европын язгууртнуудын сонирхлыг татаж, Монголын талаас олноор нь барин зоопарк руу зөөжээ. 1898 оноос XX зууны эх хүртэл 88 тахийг Европ руу авч явснаас 55 нь амьд үлдэн ердөө 12 нь л үр удмаа өгсөн. Одоо дэлхий дээр байгаа 3000 хүрэхгүй тахь бол тэдний үр удам юм. Харамсалтай нь Монголд 1968 онд хамгийн сүүлийн тахь Говь-Алтай аймгийн Бугат суманд үзэгдэсэнээс хойш дахин харагдаагүй. Олон судалгааны баг явсан ч тахийг олоогүй, 1970 оны эхээр тахийг байгальдаа устсан гэж дэлхий дээр зарласан байдаг.

СУДАЛГААНД СУУРИЛСАН СЭРГЭЛТ

Голландын Тахь хамгаалах сан Нидерланд, Баруун Германд 1970–1980-аад онд таван нөөц газарт удмын нарийн судалгаанд тулгуурлан тахийг үржүүлэн хамгаалж эхэлсэн нь эргэлтийн цэг байв. Судлаачид тахийг байгальд нь буцаан нутагшуулахгүй бол зоопаркт бүрмөсөн устгах аюултайг хүлээн зөвшөөрсөн юм. Нутагшуулах бүсийг сонгох үед Төв Азийн, тэр дундаа Монголын нутаг тахийн жинхэнэ эх орон гэдэг дээр санал нэгдсэн. Монголын тал хамгийн их сонирхлыг илэрхийлж, тухайн үеийн нэрээрээ Монголын Байгаль орчныг хамгаалах холбоо Голландын тахь хамгаалах сантай холбоо тогтоон гэрээ хэлцлээ байгуулаад тахь нутагшуулах үйл ажиллагааг эхэлсэн. Монголд тахь нутагшуулах хэдэн газрыг тодорхойлсны нэг нь Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянхангай сумын нутаг Хустайн нуруу юм.

1992 оны зургаадугаар сарын 5. Дэлхийн байгаль хамгаалах өдөр. Монгол Улс 30 гаруй жилийн дараа дахин тахьтай болсон түүхэн өдөр байв. Нидерландын Вант улс, Украйнаас авчирсан анхны 15 тахь Хустайн нуруунд нутагшсан нь “байгальдаа устсан” гэх ангиллыг өөрчилж болохыг бодитоор харуулах эхлэл болсон юм.

2000 он хүртэл хоёр жилд тутамд таван удаагийн тээвэрлэлтээр нийт 84 тахийг нутагшуулж, Хустайн нуруу 1993 онд байгалийн нөөц газар, 1998 онд байгалийн цогцолборт газрын статустай болсон.

ДЭЛХИЙД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН АМЖИЛТ

Монгол Улс тахь нутагшуулснаар Дэлхийн байгаль хамгаалах холбооны ангиллаар 2003-2006 оны хооронд тахийн ховордлын зэргийг хоёр удаа бууруулсан. Богино хугацаанд ийнхүү ангилал бууруулсан жишээ дэлхийд байхгүй. Монголчууд байгалиа хамгаалдаг, тэр тусмаа байгальдаа устсан том хөхтөн амьтныг сэргээн нутагшуулж чаддаг гэдгээ дэлхийд үлгэр жишээ болох хэмжээнд харуулж байгаа.

“Хустайн цогцолборт газар” төвийн захирал Ц.Дашпүрэв “Нэгэнт оройтоогүй л бол бүх зүйл боломжтой гэдгийг бид бодитоор харуулж байна” гэв.

Өнөөдөр Хустайд 325 тахь бий. Энэ нь дэлхий дээрх хамгийн олон тахьтай нутаг болгож байгаа бөгөөд тахь нутагшсанаар Хустайн цогцолборт газар зөвхөн нэг амьтны нутаг биш болжээ.

From extinction to the path of recovery

In the late nineteenth century, Russian explorer and researcher Nikolay Mikhailovich Przhevalsky received the skin and skull of a Przewalski horse as a gift from a local Mongolian hunter and introduced them into scientific study. This moment marked the first scientific recognition of the species. Soon after, the horse became known as Przewalski's horse and drew the attention of European aristocracy. Large numbers were captured from the Mongolian steppe and transported to zoos. Between 1898 and the early twentieth century, 88 Przewalski horses were taken to Europe. Of these, 55 survived, and only 12 produced offspring. The fewer than 3,000 Przewalski horses living in the world today all descend from them. In Mongolia, the last confirmed sighting of a Przewalski horse occurred in 1968 in Bugat soum of Gobi-Altai Province. After that, it was never seen again. Despite numerous research expeditions, none were found, and in the early 1970s the species was officially declared extinct in the wild.

A restoration grounded in research

A turning point came in the 1970s and 1980s, when the Foundation for the Preservation and Protection of the Przewalski Horse began breeding and protecting the species in five reserves in the Netherlands and West Germany, guided by detailed genetic research. Scientists recognized that without reintroduction into the wild, the Przewalski horse faced the risk of disappearing entirely within zoos. When selecting a site for reintroduction, consensus was reached that Central Asia, particularly Mongolia, was the true homeland of the Przewalski horse. Mongolia expressed the strongest interest, and the organization then known as the Mongolian Association for Environmental Protection established cooperation agreements with the Dutch foundation and began the reintroduction process. Among the sites identified was the Khustai Mountains, located within the territories of Altanbulag, Argalant, and Bayankhangai soums of Tuv Province.

June 5, 1992, World Environment Day, became a historic moment. After more than thirty years, Przewalski horses once again set foot on Mongolian soil. The first fifteen horses, brought from the Kingdom of the Netherlands and Ukraine, were released into the Khustai Mountains. It was a powerful demonstration that the label extinct in the wild could be reversed.

By the year 2000, through five transport operations conducted every two years, a total of 84 Przewalski horses had been reintroduced. The Khustai Mountains received nature reserve status in 1993 and national park status in 1998.

A success recognized worldwide

Through the reintroduction of the Przewalski horse, Mongolia succeeded in reducing the species' level of endangerment twice under the classification of the International Union for Conservation of Nature between 2003 and 2006. There is no other example in the world of such rapid progress.

Mongolia has demonstrated to the world that it is capable not only of protecting nature, but of restoring and reintroducing a large mammal that had become extinct in the wild—setting an international example.

Ts. Dashpurev says “We are showing in practice that if it is not too late, everything is possible.”

Today, Khustai is home to 325 Przewalski horses, making it the area with the largest population of the species in the world. With their return, Khustai National Park has become more than the habitat of a single species.



PHOTO BY UUGANBAYAR GANBOLD, MONGOLIA, 2020

ЭКОСИСТЕМИЙГ БҮХЛЭЭР НЬ ХАМГААЛАХ УХААН

“Хустайн цогцолборт газар” төвийн захирал Ц.Дашпүрэв байгаль хамгааллыг ганц амьтнаар хэмждэггүй гэж ярьсан юм. Түүний хэлснээр тахь бол төгсгөл бус, харин экосистемийг бүхлээр нь сэргээх эхлэл.

Ц.Дашпүрэв захирлын яриа нэг амьтны түүхээр эхэлдэг ч төгсгөлдөө бүхэл бүтэн экосистемийн тухай ойлголтод хүргэдэг. Түүний хэлснээр байгаль хамгаална гэдэг нэг зүйлийг аварснаар хэмжигдэхгүй, харин түүнийг дагасан ургамал, амьтан, орчны тэнцвэрийг хамтад нь авч үлдэх ухаан юм.

Төвийн бүсэд өмнө нь тогтмол байгаагүй цагаан зээр Хустайд үлдэж, тоо толгой нь 700 хүрч байв. Аргаль хонь улирлын зочин байгаа больж, өнөөдөр сүргийн тоо нь 150 орчим болж, монгол тарвага, халиун буга ч энд л өсөн тоо толгойгоо нэмсээр байна.

Тэд цагаан зээр, буга, аргаль, тарвага нутагшуулъя гэдэг зорилго тавиагүй боловч байгалийн зөнгөөрөө амьтад суурьшин ховор ургамлууд ургасан гээд тооцоолоогүй эерэг үр дүнгүүд олон бий. “Хустайн цогцолборт газар” төв нь ургамал болон тахийн мониторинг судалгааг сүүлийн 30 гаруй жил хийж байгаа. Хустай бол харьцангуй унаган төрхөөрөө байгааг ч онцолдог.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд Хустай 5000 гаруй тарвагыг бусад бүсэд сэлгэн нутагшуулсан нь байгаль хамгааллын бодит хөрөнгө оруулалт юм.

АМЖИЛТЫН СОРИЛ БА УХААЛАГ ШИЙДЭЛ

Амжилт шинэ сорилт дагуулдаг. Хустайн хусан ой доройтож эхэлсэн нь бугын тоо хэт олширсонтой холбоотой. Судлаачдын тооцоогоор 50 мянган га талбайд 400–500 буга зохистой бол өнөөдөр тэдгээрийн тоо 2000 давжээ.

Protecting the ecosystem as a whole

Ts. Dashpurev, Director of the Khustai National Park Center, believes conservation cannot be measured by the fate of a single species. In his view, the Przewalski horse is not the final goal, but the starting point for restoring an entire ecosystem.

Alongside the 325 Przewalski horses, Mongolian gazelles have settled permanently, with their numbers reaching 700. Argali sheep are no longer seasonal visitors, with herds of around 150. Marmots and red deer have also established themselves and continue to increase in number.

Although Director Dashpurev often begins with the story of one animal, his narrative ultimately leads to a broader understanding of the ecosystem as a whole. According to him, nature conservation cannot be measured by saving a single species, but by preserving the plants, animals, and environmental balance connected to it.

Mongolian gazelles, once rare in the central region, now remain in Khustai in stable numbers. Argali sheep have ceased to be seasonal visitors, while marmots and red deer continue to thrive.

There was no explicit goal to reintroduce gazelles, deer, argali, or marmots. Yet through natural processes, animals settled on their own, rare plants regenerated, and outcomes far exceeded initial expectations. For more than thirty years, the Khustai National Park Center has conducted continuous monitoring and research on vegetation and the Przewalski horse, emphasizing that Khustai has remained relatively close to its natural state.

In recent years, Khustai has also relocated more than 5,000 marmots to other regions, representing a tangible investment in national conservation efforts.

The challenges of success and wise solutions

Success inevitably brings new challenges. In Khustai, degradation of birch forests has been linked to an excessive increase in the deer population. Researchers estimate that 400 to 500 deer are appropriate for an area of 50,000 hectares, yet today the population exceeds 2,000.



Гэрэл зургийг Г.УУГАНБАЯР
Photo by Uuganbayar.G

Иймээс тус төв 20–30 га газарт хашин хамгаалалттайгаар ой сэргээхээр төлөвлөж байна. Энд “тарина” гэхээс илүү “сэргээнэ” гэж ярьдаг нь санамсаргүй биш байгальд хүчээр бус, ухаанаар хандаж буй илэрхийлэл юм.



In response, the center plans to restore forests across 20 to 30 hectares using fenced protection. The deliberate choice of the word restoration, rather than planting, reflects an approach that values wisdom over force in working with nature.



ӨӨРИЙГӨӨ САНХҮҮЖҮҮЛДЭГ ХАМГААЛАЛ

Хустайн байгалийн цогцолборт газар улсын төсөвт дарамт учруулдаггүй. Жилд 32 мянга орчим жуулчин хүлээн авч, аялал жуулчлалаас олсон орлогоо 100 хувь байгаль хамгаалал, судалгаа, хамгаалалтын ажилд зарцуулдаг.

Аялал жуулчлал, байгаль хамгаалал, судалгаа шинжилгээ, сургалт, орчны бүсээ хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 46 ажилтантай энэ тогтолцоо орчны бүс нутгийн иргэдийг ч орлоготой болгох бодлоготой уялдаж ажилладаг.

Энэ бол 1990-ээд оны хүнд үед алсыг харсан төлөвлөлтийн үр дүн. “Гаднын санхүүжилт хэзээ нэгэн цагт зогсоно” гэдгийг анхнаасаа ойлгосон учраас Хустайн байгалийн цогцолборт газар



өнөөдөр бие даасан, тогтвортой тогтолцоотой болж чаджээ.

Хустай бол тахийг буцааж авчирсан нутаг. Түүнээс илүүтэйгээр хүн байгальтайгаа зөв харьцвал алдаагаа засаж чаддаг гэдгийг дэлхийд сануулсан газар юм.

Байгаль хамгааллыг зөв төлөвлөж, шинжлэх ухаанд тулгуурлан эдийн засгийн бодит эх үүсвэртэй хослуулж чадвал устсан амьтныг ч эх нутагт нь буцаан нутагшуулж болдог гэдгийг Хустайн байгалийн цогцолборт газар харуулсаар байна.

Хустайн байгалийн цогцолборт газарт гэр бүл, найз нөхөдтэйгөө саатан тухлах агшин бүхэн тань байгаль эхийгээ тэтгэн, ан амьтдыг энэрэн хайрлах ариун үйлсэд үнэтэй хувь нэмэр, сэтгэлийн дулаан хөрөнгө оруулалт болон шингээж байдаг юм шүү.



SELF-FINANCING CONSERVATION

“External funding does not last forever. If a protected area cannot support itself, everything else eventually falls apart.”

Khustai National Park does not rely on the state budget. Each year, it welcomes around 32,000 visitors, and all tourism revenue is reinvested directly into conservation, research, and protection.

The park employs 46 staff across tourism, conservation, research, training, and buffer-zone development, while also supporting income opportunities for local communities in surrounding areas.

This approach is the result of far-sighted planning during the difficult years of the 1990s. From the outset,

it was understood that external funding would not last forever. As a result, Khustai National Park has developed into an independent and sustainable system.

Khustai is the land that brought back the Przewalski horse. More than that, it is a place that has reminded the world that when humans engage with nature responsibly, mistakes can be corrected.

Khustai National Park continues to prove that when conservation is carefully planned, rooted in science, and supported by real economic foundations, even a species once lost can find its way home again.

Every moment you spend relaxing at Hustai National Park with your family and friends becomes a meaningful contribution an investment of warmth and care toward nurturing Mother Nature and compassionately protecting wildlife.





Хөвсгөл аймаг, Рэнчинлхүмбэ сум, Жаргалант гол, 2019.01.20. Гэрэл зургийг Г.БАТСУХ
Jargalant river, Renchinlkhumbé soum, Khuvsgul province. Photo by Batsukh.G
51.1118° N 99.6841° E

МОНГОЛЫН ЦАГААН САР: ХОЙМОРТ ЗАЛАХУЙ



Гэрэл зургийг Н.Чадраабал
Photo by Chadraabal.N

ЦАГААН САР БА УЛАМЖЛАЛ ШИНЭЧЛЭЛ

Хахир өвлийн хүйтэн харьж, хаврын эхний нар мандмагц Монголын тал нутагт хамгийн эрхэм баяр Цагаан сар айлчлан ирнэ. Энэ бол зүгээр нэг шинэ жилийн баяр бус монголчуудын амьдралын философи, гэр бүлийн үнэ цэн, байгальтай зохицон орших ухааны илэрхийлэл юм.

Малчны хотонд төлийн дуу цангинахтай зэрэгцэн тохиодог Цагаан сар нь билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэнд тэмдэглэдэг шинэ эхлэл, цэвэр ариун, эв нэгдлийг бэлгэддэг баяр. “Цагаан” гэх нэр нь цэвэр ариун сэтгэл, сүү цагаан идээ, сайн сайхныг илтгэнэ. Энэ баяраар хүмүүс хуучин оны гомдол, муу бүхнээ ардаа үлдээн шинэ оноо тэгш сайхан угтахыг эрхэмлэдэг.

Монгол түмний ондоошил, омогшил, өв соёл, уламжлалаа тээсээр ирсэн Цагаан сарын баярыг хэдийнээс өргөн дэлгэр тэмдэглэх болсон тухай түүхийн хуудсыг хамтдаа сөхье.

Өдгөө бидний “Цагаан сар” хэмээн нэрлэдэг Монголчуудын он солигдохыг бэлгэдсэн төрт ёсны уламжлалт баярыг анх хүннүчүүд айраг цагаан идээ элбэг дэлгэр намрын улиралд тэмдэглэдэг байсан тухай эх сурвалжид дурдсан байдаг. Харин мянган жил дамнан уламжилж ирсэн Цагаан сарын баяр нь XIII зуунд буюу Их Эзэн Чингис хааны үед хаврын тэргүүн сард болж өөрчлөгдсөн нь өдгөө ч уламжлагдан ирсэн билээ. Хавар тэмдэглэхийн учрыг хахир өвлийг өнтэй давж, урин дулаантай золгож буй нүүдэлчин монголчуудын мал ахуйгаа эрхэмлэсэн зан үйлтэй холбон тайлбарлах нь ч бий.

MONGOLIA'S LUNAR NEW YEAR



TSAGAAN SAR: TRADITION AND RENEWAL

As the harsh grip of winter loosens and the first rays of spring sun rise over the Mongolian steppe, the nation's most revered celebration—Tsagaan Sar, the Mongolian Lunar New Year—arrives. Far more than a seasonal holiday, Tsagaan Sar embodies the Mongolian philosophy of life, the centrality of family, and a deeply rooted tradition of living in balance with nature. Celebrated on the first day of the first lunar month, Tsagaan Sar coincides with the arrival of spring and the season of new life, when the cries of newborn livestock echo through herders' camps. The festival symbolizes renewal, purity, and unity. The word “tsagaan,” meaning “white,” represents purity of spirit, the abundance of milk and dairy foods, and wishes for prosperity and goodwill. During this time, Mongolians consciously set aside the hardships and grievances of the past

year, welcoming the new one with harmony, respect, and hope. To understand how Tsagaan Sar became one of the most widely celebrated festivals of the Mongolian people, preserving their distinct identity, pride, cultural heritage, and traditions, we must turn to history. Sources suggest that the ceremonial New Year of early Mongols, today known as Tsagaan Sar, dates back to the era of Hunnu. At that time, it was celebrated in autumn, a season rich in fermented mare's milk and dairy products. Over the course of a millennium, however, the festival evolved. By the 13th century, during the reign of Chinggis Khaan, Tsagaan Sar was formally moved to the first month of spring, a tradition that continues to this day. The choice of spring is often linked to the pastoral way of life, symbolizing survival through the harsh winter and the hopeful renewal brought by warmer days and the promise of life returning to the land.



Төв аймаг. Баянхангай сум. Гэрэл зургийг Г.Базаррагчаа. МПА
Bayankhangai soum. Tuv province. Photo by Bazarragchaa G. MPA

ХОРЬСОН Ч ҮЛ ТАСАРСАН ЦАГААН САР

Зуун дамнан тэмдэглэсээр ирсэн Цагаан сарыг хэд хэдэн удаа хорьж, тэмдэглээгүй гэдэг. Тодруулбал, 1952 онд Цагаан сараар Маршал Х.Чойбалсан нас барсан тул тухайн жил Цагаан сар тэмдэглээгүй аж. Түүнчлэн социализмын үед бүрэн хориглож байсан зурвас цаг хугацаа бий. Тиймээс социализмын жилүүдэд Цагаан сарын шинийн нэгний өдрийг тааруулан намын хурал, сонгол зохион байгуулах зэргээр аль болох энэ баярыг тэмдэглүүлэхгүй байх арга хэмжээг авдаг байв. Гэвч уламжлалаа гээхгүй гэсэндээ өгтөс буурлууд малчны баяр хэмээн нууцаар тэмдэглэн битүүлж, үүд хаалгаа түгжин бууз, баншаа жигнэдэг, битүүлэг, цагаалга, идээ будаагаа орныхоо хөндийд нуудаг хэцүүхэн цаг үе байжээ. Намын өндөр, хариуцлагатай алба хашдаг байсан ч ёс заншлаа даган Цагаан сараа гэртээ нууцхан тэмдэглэдэг байсан тухай хожим нь тэд дурсан ярьсан юм. 1990 оны Ардчилсан хувьсгал ялсны дараа Цагаан сарыг дахин өргөн дэлгэр тэмдэглэх болов. Социализмын үеийн хорио, хяналт нуран унаснаар үндэсний ухамсар сэргэсний нэг тод илрэл нь монголчууд Цагаан сараа уламжлалт ёс жаягаар нь өргөн дэлгэр тэмдэглэж эхэлсэн явдал байв. Хамгийн сүүлд 2020 онд дэлхий нийтийг хамарсан коронавирусийн дэгдэлтийн улмаас хөл хорио тогтоосон тул монголчууд Цагаан сарыг зөвхөн гэр бүлийн хүрээнд цомхон тэмдэглэсэн. Ахмад настан ах, дүүсэрээ айлчлан золгож тэмдэглэсээр ирсэн Цагаан сар ийнхүү технологийн хурдацтай хөгжлийг даган орон даяар “Цахим золголт” хэлбэрт шилжсэн нь анх удаа байв.

ЦАГААН САР БА ТӨГСБУЯНТЫН ЗУРХАЙ

Төгс буянтын зурхайг Хөхнуурын Монголын түүхч, гүн ухаантан, шашны ухаан, анагаах ухаан, уран зохиол, одон оронч Ишбалжир Монгол орныхоо газрын хуваарьт тохируулан "Төгс буянт шинэ зурхай" хэмээх монгол одон орон зурхайг 1747 онд зохиож сургууль байгуулсан түүхтэй. Төгсбуянт зурхай бол сарны тооллын дагуу монгол орны цаг агаар уур амьсгал, газар зүйн байрлалд тохируулж бүтээсэн монгол зурхай юм. Тус зурхайн дагуу жил бүрийн Цагаан сарын баяр хэзээ болохыг товлож хэрэглэж ирсэн түүхтэй.

Юань гүрний үед Хубилай хааны зарлигаар Монголын болон түүний харьяанд байсан улс орнуудын тоо, одон орон, зурхайн ухааны олон мэргэд төрийн зурхайг магадлан шалгаж баталгаажуулан хэрэглэсээр ирснийг Шар зурхай гэж нэрийддэг. Эдүгээ Азийн ихэнх орнууд чухамхүү эл зурхайг хэрэглэн буй.

Монголчууд 200 орчим жил Манж Чин улсын харьяанд явахдаа тэрхүү уламжлалт Шар зурхайгаар Цагаан сарын баяр тэмдэглэдэг байсан. Харин 1911 онд тусгаар тогтнолоо сэргээж, VIII Богд Жавзандамба хутагт хааны зарлигаар Төгс буянтын зурхайг буцаан сэргээн хэрэглэх болжээ. Дорнын ард түмнээс бид Төгсбуянтын зурхайгаар ялгарч цагаан сараа тэмдэглэсээр ирсэн юм. Тэр ч утгаараа Монголын цагаан сар бол шинэ жилийн баяр төдийгүй Монгол Улсын тусгаар тогтнолын бэлгэдэлт баяр гэж үзэж болно.



“TSAGAAN SAR” UNBROKEN BY PROHIBITION

The Lunar New Year, celebrated for centuries, has on several occasions been banned or left unobserved. Most notably, in 1952 the festival was not celebrated because Marshal Khorloogiin Choibalsan passed away during the Lunar New Year period. In addition, there were periods during the socialist era when the celebration was completely prohibited. During

those years, authorities deliberately scheduled party meetings and official hearings on the first day of the Lunar New Year in an effort to suppress public observance of the holiday. Yet, determined not to abandon their traditions, elders quietly marked the occasion in secret, sealing their doors, steaming dumplings, and hiding ritual foods, dairy offerings, and ceremonial items beneath their beds. It was a difficult and cautious time. Even those who held high-ranking and responsible party positions later recalled how they secretly observed the Lunar New Year at home, faithfully following ancestral customs. Following the victory of the Democratic Revolution in 1990, the Lunar New Year once again began to be celebrated openly and on a grand scale. With the collapse of communist restrictions and controls, a revival of national consciousness became evident, reflected clearly in Mongolians' renewed commitment to celebrating Tsagaan Sar in accordance with traditional customs and rituals. Most recently, in 2020, due to lockdown measures imposed in response to the global coronavirus pandemic, Mongolians observed the Lunar New Year in a more modest manner, limited to the immediate family. A festival long defined by visiting elders and exchanging greetings with extended relatives underwent an unprecedented transformation: for the first time, it shifted nationwide to a form of “virtual greetings,” adapting to rapid technological advancement while maintaining its symbolic spirit.

“TSAGAAN SAR” AND THE TUGS BUYANT CALENDAR

The celebration of Tsagaan Sar in Mongolia is closely tied to the Tugs Buyant calendar, a traditional system of astronomy and astrology uniquely adapted to the country's geography and climate. In 1747, Ishbaljir, a distinguished Mongolian historian, philosopher, religious scholar, physician, literary figure, and astronomer from Khukh Nuur, compiled the Tugs Buyant New Year Calendar and established a scholarly school dedicated to its study. Rooted in a luni-solar framework, the calendar was carefully adapted to Mongolia's environmental conditions, aligning celestial movements with the rhythms of nomadic life. For generations, it served as the authoritative method for determining the annual date of Tsagaan Sar. During the Yuan Dynasty, by decree of Kubilai Khaan, leading experts in mathematics, astronomy, and calendrical science from Mongolia and its affiliated states examined, standardized, and adopted an official state calendar. This system later became known as the “Yellow Calendar,” which continues to be used today across much of Asia. During more than 200 years that Mongolians were under the rule of the Manchu Qing Empire, Mongolians observed Tsagaan Sar according to the Yellow Calendar. However, following the restoration of national independence in 1911 marked a turning point. By decree of the Eighth Bogd Javzan damba Khutagt, Mongolia reinstated the use of the Tugs Buyant calendar, reaffirming Mongolia's own calendrical tradition. This distinction continues to set Mongolia apart from other Asian nations. By celebrating Tsagaan Sar according to the Tugs Buyant calendar, Mongolians affirm more than the arrival of a new year, they uphold a living symbol of national identity, historical continuity, and sovereignty. In this sense, Tsagaan Sar stands not only as a New Year's celebration, but also as a quiet yet enduring expression of Mongolia's independence.



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, төрийн ёслол хүндэтгэлийн өргөө, Улаанбаатар хот, Монгол Улс
 Ukhurelsukh.U, the President of Mongolia, State Ceremonial Ger, Ulaanbaatar, Mongolia

УЛАМЖЛАЛ, СОЁЛЫГ АМЬД БАЙЛГАХ ХҮЧ

Цагаан сар нь өнө эртнээс монголчуудын төрт ёсны уламжлал, төрөл садны энх мэнд, бэлэгдэл хүндэтгэлийн баяр байсаар ирсэн гэж хэлж болно. Тиймээс Цагаан сарын шинийн нэгнийг монголчууд үндэсний дээл хувцсаараа гоён хангай дэлхийдээ идээ будааны дээжээ өргөн тэр жилийн өнгөө тольдон зүг чигээ гарган утгадаг. Ураг төрлөөрөө хамгийн ахмад хүндээ хүндэтгэл үзүүлэн хуран чуулж, хуучин оноо хэлэлцэн шинэ ондоо сайн сайхан бүхнээр дүүрэн байхыг ерөөн идээ будаагаар элбэг дэлбэг ширээ засан ирсэн зочдоо дайлан хувь хүртээдэг уламжлал өдгөө ч хадгалагдсаар ирсэн юм.

Уламжлалаа хадгалан шинэчлэлтэй хослуулах нь Монголын соёл уламжлагдаж, хөгжиж буй шинж билээ. Цагаан сарын зан үйл бүр соёлын гүн утгатай. Ахмадуудтайгаа золгон ерөөл авах нь хүний ёс, байгальтай зохицон орших ухааныг дамжуулдаг амьд сургааль билээ. Цагаан сарын баярын ширээнд зассан ууц, тавгийн идээ, ааруул, бууз бүхэн нүүдэлчдийн олон зууны турш бүрэлдсэн амьдралын хэв маягийг өгүүлнэ.

Мэдээж цаг хугацааны эрхээр малчин түмний баяр хотожсон нийслэлчүүдэд өвлөгдөхдөө эдэлж хэрэглэх зүйлс, тавгийн идээ хувсан өөрчлөгдсөөр ирсэн. Өнөө цагийн Цагаан сар уламжлалаа хадгалахдаа байгальд ээлтэй шинэчлэлийг шингээсээр байгаа юм. Нүсэр ширээнээс татгалзан цомхон тансаг ширээ засах, нутгийн гаралтай бүтээгдэхүүн хэрэглэх, дахин ашиглах сав, баглаа боодол сонгох нь нүүдэлчдийн хэмнэлттэй философитой нийцдэг.

Бид уламжлалаа эвдэн элдэвлэж гээлгүй хадгалан хойч үедээ өвлүүлсээр байгааг жил жилийн цагаан сараар харж болно.

Хориоджилийн өмнө л цагаан сараар үндэсний дээлээрээ гоёх нь зөвхөн өвгөд хөгшид төдийгээр хязгаарлагдах шахуу байсан ч өнөөдөр хүүхэд, залуус өргөн дэлгэр үндэсний дээл хувцсаараа гоён өдөр тутамдаа ч хэрэглэх болжээ.

Түүнчлэн хот суурин газрын айлууд орон зай, цаг хугацаанд тохируулан ёслолоо илүү цомхон тэмдэглэх болсон. Энэ нь Цагаан сарыг цаг үеийн хэмнэлд нийцүүлэн утга учрыг нь алдалгүй хадгалах шинэ хандлага юм.

THE POWER THAT KEEPS TRADITION AND CULTURE ALIVE

Since ancient times, Tsagaan Sar has stood at the heart of Mongolia's state tradition, a celebration grounded in kinship, collective well-being, and ritualized respect. On the first day of the Lunar New Year, Mongolians wear their traditional costume “deel”, offer the first servings of food to the land and the heavens, and contemplate the fortunes of the year ahead in pursuit of harmony in all directions. Families gather to honor their elders, exchange blessings, reflect on the passing year, and welcome the new one with shared hopes for health, prosperity, and peace. Tables are laid generously with traditional foods, and guests are received with open-handed hospitality—a tradition that continues unbroken to this day. The ability to preserve tradition while embracing renewal is a defining characteristic of Mongolian culture as a living, evolving heritage. Every ritual associated with Tsagaan Sar carries profound cultural meaning. The act of greeting elders and receiving their blessings is a living lesson in ethical conduct and coexistence with nature, passed down through generations. The ceremonial feast features uuts (the steamed sheep's back), tavgiiin idee (stacked ceremonial pastries), aaruul (dried curds), and buuz (steamed dumplings), tells the story of a nomadic way of life shaped over centuries. Naturally, over the course of time, as the herders' festival was passed on to the increasingly urban population of the capital, the items used and the foods placed on the ceremonial table have gradually evolved. Today's Lunar New Year continues to uphold tradition while incorporating environmentally friendly innovations. Choosing refined yet modest table settings instead of overly lavish displays, using locally sourced products, and opting for reusable containers and sustainable packaging all align with the nomadic philosophy of frugality and balance with nature. Each year's Lunar New Year demonstrates how we continue to preserve our traditions without distorting or diminishing them, passing them on intact to future generations. Just two decades ago, wearing traditional national attire during the Lunar New Year was largely limited to elders, yet today children and young people alike proudly wear traditional Mongolian clothing, not only during the festival but increasingly in their everyday lives. Likewise, urban households have adapted their celebrations to fit limited space and time, observing the rituals in a more compact manner. This reflects a modern approach to celebrating the Lunar New Year—one that keeps pace with contemporary life while preserving its essence and meaning.



TOP DONJ
MONGOLIAN CASHMERE

EVSEG
Mongolian Premium Cashmere

NIRUN
MONGOLIAN CASHMERE



ALFRED ROWLAND
LONDON

DISCOVER THE WARMTH OF MONGOLIA

| OEM/ODM is available


SWEATER CARDIGAN HOODIE PANTS DRESS SKIRT COAT & BLAZER HAT SCARF & SHAWL GLOVES SOCKS



E-mail: export@cashmereholding.com
Tel: (+976) 11343619

БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд хатагтай Шэнь Минжуань “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг дэмжин ажиллана

AMBASSADOR EXTRAORDINARY AND PLENIPOTENTIARY OF THE PEOPLE'S
REPUBLIC OF CHINA TO MONGOLIA, SHEN MINJUAN TO COOPERATE WITH THE
“BILLION TREES NATIONAL MOVEMENT”



Зүүн гар талаас: Б.Булган, З.Мөнхбат, Шэнь Минжуань, Г.Энхтайван нар
From left: Bulgan.B, Munkhbat.Z, Shen Minjuan and Enkhtaivan.G

БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд хатагтай Шэнь Минжуань 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр “Тэрбум мод хөдөлгөөн” ТББ-ын төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд хамтран ажиллах боломж, чиглэлүүдийн талаар санал солилцож дараах хоёр чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцлоо.

Нэг. Хятад Улс сүүлийн хагас зуун жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулж, цөлжилттэй тэмцэх зорилгоор үе шаттайгаар мод тарьж, ургуулсаар ирсэн арвин туршлагатай. Энэ хүрээнд Хятадын ойн салбарын ололт амжилттай танилцах, туршлага судлах богино хугацааны сургалт зохион байгуулах,

Хоёр. БНХАУ-аас Монгол Улсад болон бүс нутгийн хүрээнд байгаль орчны орчны салбарт оруулсан хувь нэмэр, санал санаачилга болон цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл хөтөлбөрийн талаархи мэдээллийг олон нийтэд хүргэх чиглэлүүдээр талууд хамтран ажиллана.

On March 25, 2026, Ms. Shen Minjuan, Ambassador of China to Mongolia, received representatives of the “Billion Trees Movement” NGO and exchanged views on potential areas of cooperation within the framework of the “Billion Trees National Movement.” The two sides agreed to collaborate in the following two areas:

First, over the past half century, China has accumulated extensive experience in planting and growing trees in stages to mitigate the impacts of climate change and combat desertification. In this context, short-term training programs will be organized to study and learn from the achievements and experience of China’s forestry sector.

Second, the two sides will cooperate in disseminating information to the public about China’s contributions and initiatives in the environmental sector in Mongolia and the region, as well as planned future projects and programs.





Хөвсгөл аймаг, Улаан-Уул сум, Хорьдол сарьдаг уул, Гэрэл зургийг Н.Мөнхбаатар
Khuvsgul province, Ulaan-Uul soum, Khoridol saridag Mountains. Photo by Munkhbaatar.N





Хөвсгөл аймаг. Улаан-Уул сум. Хорьдол сарьдаг уул. Гэрэл зургийг Н.Мөнхбаатар
Khuvsgul province, Ulaan-Uul soum. Khoridol saridag Mountains. Photo by Munkhbaatar.N

A photograph of a forest path. The path is made of dirt and fallen leaves, winding through a dense forest of tall, thin trees. Sunlight filters through the canopy, creating dappled light on the path and the surrounding greenery. The overall atmosphere is peaceful and natural.

*Бүхний гэр орон
гайхамшигт ой*

The Wonderful
FOREST
Home for All



Ногоон ертөнцийн нууц, амьтдын аялгуу, амьдралын далд симфони

НОГООН ХӨШИГ НЭЭГДЭХҮЙ

Өглөөний манан дунд ой амьсгалж байдаг. Нарны анхны туяа моддын оройгоор шүүрэн орж, навчсын завсраар алтран цацрах тэр агшинд байгаль өөрийн тайзыг нээдэг. Энэ бол шувуудын жиргээ, салхины шивнээ, хөвдийн зөөлөн гишгэлтээр эхэлдэг амьдралын симфони.

Монгол орны хойд нутгийн ногоон хаяа нь дэлхийн өргөн уудам Тайга хэмээх их бүсийн нэгэн хэсэг. Эндхийн ой бол зүгээр нэг моддын цуваа биш амьсгалж, харилцаж, өөрийгөө нөхөн сэргээж байдаг амьд ертөнц. Мод бүр тэнгэр өөд тэмүүлэх мөрөөдөлтэй, үндэс бүр газрын гүн рүү шингэсэн түүхтэй.

Цэнхэр гарагийн гуравны нэгийг ой эзэлдэг. Дэлхийд үнэлэгдэх үнэлэмжээрээ монгол орны ой бусад оронтой харьцуулшгүй. Хан Хэнтийн нурууны ойн сан гэхэд л анхдагч ойн хэв шинж, онгон төрхөө харьцангуй сайн хадгалсан хэмээн дэлхийд үнэлэгддэг. Ой бидний амьдралын салшгүй нэг хэсэг хэвээр. Ахуй амьдрал, ажил мэргэжил, ашиг орлого гээд хүн төрөлхтнийг ойгүйгээр төсөөлөхийн аргагүй.

Ой шиг том гэр орон, хоол тэжээлийн асар их нөөц цэнхэр гарагт өөр хаана ч үгүй.

ОЙН ХААНТ УЛС БА ДҮРҮҮД

Ой бол хаант улс. Монгол орны гайхамшигт ойн хөшгийг хамтдаа нээе. Түүний эзэн хаан нь хүчирхэг баавгай, зальт үнэг, нам гүмийн эзэн шар шувуу. Өвсөн тэжээлтэн буга, согоо нь моддын завсраар намуухан алхаж, амьдралын үргэлжлэлийг бэлгэднэ. Харин чоно бол айдас биш тэнцвэрийн сахиул.

Ойгоос эгшиглэдэг уран хөг аялгуу, чамин тансаг үнэр, өнгө будгийн төгс хослол нь сая сая жилийн хувьсгалын явцад төгс төгөлдөр болсон байгаль эхийн бүтээл юм.

Хэрэв нэг махчин алга болбол өвсөн тэжээлтний тоо хэт өсөж, ойг доройтуулна. Харин өвсөн тэжээлтэн үгүй болбол махчин амьтад оршин тогтнож чадахгүй. Энэ бол байгалийн бичигдээгүй хууль. Хэн нэгэн ялж, нөгөө нь ялагддаггүй харин бүгд хамтдаа оршдог. Ойн амьдрал, ойн боо ертөнц бүхэлдээ бие биесээ хамааралтай байдаг. Төрөл бүрийн модод, шувуу, хэрэм, мэрэгчид, үй түмэн шавьжны гэр орон нь, хатаж унасан мод хүртэл зарим амьтдын хоргодох газар, хоол тэжээл нь болно. Угтаа амьтай бүхний амьдралын төлөөх тэмцэл, экосистемийн бат бөх гинжин хэлхээг бид ойгоос л тольдон харж болно.

Secrets of the Green World, the Melody of Animals, the Hidden Symphony of Life

WHEN THE GREEN CURTAIN OPENS

In the morning mist, the forest breathes. When the first rays of sunlight slip through the treetops and scatter like gold through the leaves, nature opens its stage. It is a symphony of life that begins with birdsong, the whisper of the wind, and the gentle step upon soft moss.

The green northern region of Mongolia forms part of the vast global zone known as the Taiga. The forests here are not simply rows of trees, but a living world that breathes, communicates, and renews itself. Each tree holds a dream reaching toward the sky, and every root carries a story buried deep within the earth.

Forests cover one third of the blue planet. In value and significance, the forests of Mongolia are unlike those of many other countries. The forest resources of the Khan Khentii mountain range are internationally recognized for preserving the natural character and relatively untouched condition of primary forests. Forests remain an inseparable part of human life. Daily living, occupations, and livelihoods make it impossible to imagine humanity without forests.

Nowhere else on the blue planet exists a home as vast as the forest or such an immense reserve of food resources.

THE KINGDOM OF THE FOREST AND ITS INHABITANTS

The forest is a kingdom. Let us open the magnificent curtain of Mongolia's forests. Its rulers are the powerful bear, the clever fox, and the owl that governs the silence. Herbivores such as deer and roe deer move quietly between the trees, symbolizing the continuation of life. The wolf is not a symbol of fear but the guardian of balance.

The melodies that echo through the forest, the rich natural scents, and the harmony of colors are creations of nature shaped over millions of years of evolution.

If one predator disappears, the number of herbivores increases excessively and the forest weakens. If herbivores disappear, predators cannot survive. This is an unwritten rule of nature. No one wins and no one loses; all simply coexist. The life of the forest and its biological world are entirely interdependent. Many kinds of trees, birds, squirrels, rodents, and countless insects live there. Even a fallen, dry tree becomes shelter and food for certain animals. In truth, the struggle for survival among living beings and the strong chain of the ecosystem can be clearly seen in the forest.

МОДДЫН НУУЦ ЯРИА

Швед улсаас 2008 онд олдсон нэгэн гацуурын ёзоор 9550 жилийн настай байсан бөгөөд эргэн тойрныхоо мододтой генийн ижил шинж тэмдэгтэй болох нь тогтоогджээ. Модод дуугүй мэт боловч тэд ярилцдаг. Үндсээрээ холбогдон мөөгний торлог сүлжээгээр дамжуулан шим тэжээл, дохио мэдээлэл солилцоно. Судлаачид энэ сүлжээг “ойн интернэт” хэмээн нэрлэдэг. Байгалийн ухаалаг систем биднээс хэдэн мянган жилээр түүрүүлжээ.

Монгол орны ой дэлхийн усны гурван том ай савын хагалбарыг даган ургасан байдаг. Гол, мөрний усны нөөцийг зохицуулан хамгаалах, цэвэршүүлэх, хөрсийг элэгдлээс хамгаалах, уур, амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээхэд чухал нөлөөтэй.

Монгол орны ойн зонхилох мод болох *Larix sibirica* буюу Сибирийн

шинэс нь намар шаргалтан алтарч, өвөл нүцгэрч, хавар дахин нахиалдаг тэсвэр тэвчээрийн бэлгэдэл гэлтэй. Тэр хүйтнийг сөрж, цаг хугацаатай тэмцэн зогсохдоо “амьдрал үргэлжилсээр” гэж хэлж байдаг мэт.

Мод нь нүүрстөрөгчийг шингээн хүчилтөрөгч ялгаруулахаас гадна байгалийн үзэмж, экосистем, хөдөө аж ахуй, байшин барилгын материал болдог гээд олон чухал үйлчилгээ үзүүлдгийг нь бид алхам тутамдаа мэдэрдэг билээ. Өнөөдрийн байдлаар дэлхий дээр 100 мянган төрлийн мод бүртгэгдээд байгаа нь нийт амьд ургамлын 25 хувийг эзэлж байна.

Навч унаж, ялзмаг болж, хөрсийг тэтгэнэ. Хөрс бичил биетнээр амилж, шинэ үр соёолно. Үхэл хүртэл энд амьдралын нэг хэлбэр.

ЖИЖИГХЭН АТЛАА ЧУХАЛ ЕРТӨНЦ

Ойн хамгийн их хөдөлмөрч оршин суугчид бол нүдэнд үл анзаарагдах бичил амьтад. Шавж тоос хүртээж, мөөг задрал явуулж, тоншуул хуучин модыг цэвэрлэнэ. Бүх зүйл хэрэгтэй.

Нэг зөгий алга болбол олон цэцэг үр жимсээ өгөхгүй. Нэг мөөг устахад хөрсний эргэлт саарна. Байгаль “илүүц” хэмээх ойлголтыг мэддэггүй. Учир нь ой мод нь хуурай газрын бүх амьтан,

ургамлын 80 хувийн амьдрах орчин нь болдог.

Шим мандлын салшгүй хэсэг болохын хувьд ой нь хөрсний усны тэнцвэрийг барьж, хөрсийг хамгаалж, элсний нүүдлийг хязгаарлаж, цэвдгийг тогтоон барьснаар дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулдаг. Дэлхий дахинаа одоо 330 сая га талбай бүхий ой цасан нурангиас үүдэлтэй эрсдэлээс хамгаалж, далайн хүчтэй давлагааг тогтоон элсний нүүдлийг тогтворжуулан цөлжилтийг удаашруулж байгаа билээ.

ОЙН СҮРЧИГ

Тансаг анхилам сүрчгийн гол орцод царс, агар, зандан мод гээд ойн модноос гарган авсан үнэртэн заавал ордгийг та мэдэх үү. Түүгээр ч зогсохгүй ойн үнэрийг таашаан зогсох нь уушги тэлэн сэтгэл санаа өргөх, тайвшруулах гээд эрүүл мэндэд ч эергээр нөлөөлдөг. Цаашлаад технологийн дэвшил, шинжлэх ухааны судалгаанд тулгуурлан дэлхий дахинаа гэр ахуй, хүмүүсийн хэрэглээнд зориулан ойн үнэртэй төрөл бүрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргаж байна.

Судлаачдын тогтоосноор ойд 25 мянгаас дээш төрлийн үнэр ялгардаг бөгөөд эдгээр нь хоорондоо нэгдэн урвалд орж, сая саяар тоологддог.

Ойн амьтан ургамал, модод гээд амьтай бүхнээс гарах үнэр бүхэн өөр өөрийн зорилго, бас үүрэгтэй. Энэ мэтчилэн тоочвол гайхамшигт ойн зөвхөн үнэрийн ач холбогдол л гэхэд асар их.

THE SECRET CONVERSATION OF TREES

In 2008, the root system of a spruce discovered in Sweden was found to be 9,550 years old and to share identical genetic traits with nearby trees. Trees may seem silent, but they communicate. Through their roots and through networks formed by fungi, they exchange nutrients and signals. Researchers call this system the forest internet. Nature created this intelligent system thousands of years before humans did.

The forests of Mongolia grow along the divides of the three major river basins of the world. They play an important role in protecting and regulating water resources of rivers, purifying water, protecting soil from erosion, moderating the climate, and absorbing greenhouse gases.

The dominant tree of Mongolia's forests, *Larix sibirica* or the Siberian larch, shines golden in autumn, stands bare in winter, and sprouts again in spring, as if symbolizing endurance and resilience. Standing against the cold and the passage of time, it seems to say that life continues.

Trees absorb carbon and release oxygen. At the same time, they provide natural beauty, support ecosystems and agriculture, and supply materials for construction. Today, more than 100,000 species of trees have been recorded worldwide, representing 25 percent of all living plant species.

Leaves fall and become humus that nourishes the soil. The soil comes alive with microorganisms, and new seeds begin to grow. Even death here becomes another form of life.

A SMALL YET SIGNIFICANT WORLD

The most industrious residents of the forest are the tiny organisms that escape the human eye. Insects pollinate, fungi carry out decomposition, and woodpeckers clean old trees. Everything has a role. Everything is necessary.

If one bee disappears, many flowers will not bear fruit. If one species of fungus disappears, the cycle of the soil slows down. Nature does not recognize the idea of something being unnecessary. Forests provide habitat for 80 percent of all terrestrial animals and plants.

As an essential part of the biosphere, forests maintain soil water balance, protect the soil, limit the movement of sand, preserve permafrost, and help slow global warming and climate change. Around the world, forests covering 330 million hectares protect against avalanches, reduce the force of strong ocean waves, stabilize moving sand, and slow desertification.

THE ESSENCE OF THE FOREST

Did you know that many luxurious perfumes contain scents taken from forest trees, such as oak, agarwood, and sandalwood, as key ingredients? In addition, simply standing among the natural scents of the forest can expand the lungs, improve mood, calm the mind, and benefit health. Advances in technology and scientific research have also made it possible to produce many forest scented products for use in homes and everyday life.

Researchers have found that forests release more than 25,000 different scents, and these combine and react with one another to create millions of variations. Every scent released by forest animals, plants, and trees has its own purpose and role. Even the significance of forest fragrance alone is immense.





ОЙ ДЭЛХИЙН УУШГИ, ХҮНИЙ ТОЛЬ

Хэрлэн, Онон, Туул, Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон гол мөрнүүд хэдэн зуун мянган жил тасралтгүй урссаар ирсний эх үүсвэр нь ой мод юм. Ой бол дэлхийн амьсгал. Модод нүүрсхүчлийн хийг шингээж, хүчилтөрөгч бэлэглэнэ. Гол мөрөн ойгоос эх авч, амьдралын судсыг тэтгэнэ. Хэрэв ой шатвал зөвхөн мод биш дурсамж, амьдрал, ирээдүй шатна.

Гэвч байгаль хүний дайсан биш. Харин хүний толь. Бид хэрхэн хандана, тийм л хариуг авна. Нэг мод огтлох амархан.

Харин ургуулахад арван жил, бүр зуун жил ч шаардагдаж мэднэ.

ХҮН ЗОЧИН УУ, ЭЗЭН ҮҮ?

Бид ойд очихдоо "аялагч" гэж боддог. Гэвч үнэндээ бид бол зочин. Ой биднээс өмнө байсан, биднээс хойш ч байсаар байхыг хүснэ. Харин тэрхүү хүслийг биелүүлэх эсэх нь биднээс шалтгаална.

Монголчууд уул ус, ой модоо тахин шүтэж, байгальтайгаа зохицон амьдрах ухааныг үеэс үед өвлүүлж ирсэн. Тэр ухаан бол өнөөдрийн тогтвортой хөгжлийн философи юм. Өдрөөс өдөрт ойн экосистем алдагдаж, зарим нь

ялагч болж, зарим нь ялагдагч болсоор байна. Магадгүй хамгийн том ялагдагч нь бид өөрсдөө байж ч болзошгүй.

Дэлхий дээр 300 сая хүн ойд болон ойн орчинд амьдарч байна. Үүнээс 60 сая хүний амьдрал бүхэлдээ ойгоос хамааралтай гэсэн тоо баримт байдаг. Тиймээс бид ойн хувьд чухам хэн байх, үр хойчдоо үлдээж байгаа өв юу болох талаар та нэг эргэцүүлээд бодоод үзээрэй.

ТӨГСГӨЛ БИШ ҮРГЭЛЖЛЭЛ

"Бүхний гэр орон гайхамшигт ой" гэдэг нь зүгээр нэг гарчиг, зөвхөн амьтдад зориулсан уриа биш. Харин хүн төрөлхтний оршин тогтнох үндэс суурь юм. Ойг хамгаалах нь зөвхөн моддыг хамгаалах биш тэрхүү моддын сүүдэрт амьсгалдаг бүх амьд организмын ирээдүйг хамгаалах явдал юм. Ой бол амьтдын гэр, шувуудын үүр, голын эх, хүний амьсгал, дэлхийн ирээдүй.

Монгол орны ой унаган байгалийнх тул байгалийн аясаар нөхөн сэргээгдэх чадвар нь сайн буюу нэг га-д 3000 орчим зулзаган мод бүртгэгджээ. Манай орны ойн нэг хүнд ногдох талбай дэлхийн дунджаас долоо дахин, Европын дунджаас бүр 20 дахин их байдаг. Тиймээс ойгоо хайрлах гэдэг нь зүгээр нэг мод суулгаад орхих биш гэдгийг хүн бүхэн хариуцлагатайгаар ухамсарлаж, үр хүүхдэдээ ач тусыг нь сайтар ойлгуулах хэрэгтэй. Суулгасан модоо арчилж, тордон хамгаалж, ургуулна гэдэг их хөдөлмөр сэтгэл шаардсан ажил. Тиймээс нэг удаа мод тариад орхих биш, суулгасан модоо газрын гүнтэй холбогдож, шим тэжээл тэсэж ургах хүртэл нь хэдэн жил тасралтгүй усан тордох ёстойг ойлгох нь чухал.

Монгол оронд сүүлийн таван жилд 100-200 мянган га газрын ой устан ойн хомсдолын 90 хувь нь хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гэсэн харамсалтай тоо баримт бий.


Нэг мод бол нэг түүх. Нэг ой бол нэг ертөнц. Тэр ертөнцийг хамгаална гэдэг нь бид өөрсдийнхөө амьдралыг хамгаалж буй хэрэг.

Ойд алхах бүрдээ чимээгүйхэн сонс. Салхи юу хэлж байна? Навчис юу шивнэж байна? Тэнд амьдралын хариулт бий. Тэнд бидний маргааш бий.

THE FOREST AS THE EARTH'S LUNGS AND HUMANITY'S MIRROR

Major rivers such as the Kherlen, Onon, Tuul, Orkhon, and Selenge have flowed for hundreds of thousands of years, and their sources lie in forests. The forest is the breath of the earth. Trees absorb carbon dioxide and give oxygen. Rivers begin in forests and sustain the flow of life. If forests burn, not only trees burn but memories, life, and the future burn with them.

Nature is not the enemy of humanity. It is the mirror of humanity. The way we treat it determines the response we receive. Cutting down a tree is easy, but growing one may take ten years or even a hundred years.



ARE HUMANS GUESTS OR OWNERS?

When we enter a forest, we often think of ourselves as travelers. In reality, we are guests. The forest existed long before us and hopes to continue existing long after us. Whether that hope becomes reality depends on us.

Mongolians have long worshipped mountains, rivers, and forests and have passed down the wisdom of living in harmony with nature from generation to generation. That wisdom is the philosophy of sustainable development today. Day by day, forest ecosystems are being damaged, and in this process some appear to win while others lose. In the end the greatest loss may be our own.

Three hundred million people in the world live in forests and forest environments. Of these, sixty million people depend entirely on forests for their survival. Therefore, we must carefully consider who we truly are in relation to the forest because it will become the legacy we leave to future generations.

NOT AN ENDING BUT A CONTINUATION

The Wonderful Home of All Forests is not merely a title nor only a slogan for animals. It is the foundation of the survival of humanity. Protecting forests does not mean protecting trees alone. It means protecting the future of every living organism that breathes beneath their shade. The forest is the home of animals, the nest of birds, the source of rivers, the breath of humans, and the future of the earth.

Because Mongolia's forests are largely natural, they have a strong ability to regenerate on their own, with about 3000 young trees recorded per hectare. The amount of forest area per person in Mongolia is seven times higher than the global average and twenty times higher than the European average. For this reason, caring for forests means more

than simply planting a tree and leaving it behind. Everyone must understand this responsibility and pass that understanding on to their children. Caring for planted trees and helping them grow requires effort and dedication. Trees must be watered and tended for several years until its roots take hold deep in the soil and it grows strong.

During the last five years, Mongolia has lost forests covering 100,000 to 200,000 hectares, with 90 percent of deforestation being caused by human activity.

One tree is one story. One forest is one world. Protecting that world means protecting our own lives.

Whenever you walk in a forest, listen quietly. What is the wind saying? What are the leaves whispering? There lies the answer of life. There lies our tomorrow.

*Мажигийн ТУНГАЛАГИЙН
"Гайхамшигт ой" номоос ашиглав.*

*Source: book "The Wonderful Forest" by
Tungalag Majig*



Монгол бахархал-2025:

ЭВ НЭГДЭЛ, АМЖИЛТ, ШИНЭЧЛЭЛ

2025 он Монгол Улсын хувьд сорилт, шинэчлэл, эв нэгдэл, бахархлаар дүүрэн жил байлаа. Дэлхий дахины өөрчлөлт, уур амьсгалын сорилт, эдийн засгийн савлагаан дунд монгол хүн оюун ухаан, ур чадвар, зориг тэвчээр, нэгдмэл хүчээрээ ялгарч чадсан юм. Энэ жил Монгол Улс олон улсын тавцанд шинэ амжилт, итгэл найдвар, түүхэн үзүүлэлтүүдээр дүүрэн байв.

The year 2025 was one of challenge, change, unity, and pride for Mongolia. In the midst of global shifts, climate pressures, and economic uncertainty, the Mongolian people stood out through their intelligence, skill, courage, and resilience, united as one. It was a year marked by new accomplishments, renewed confidence, and historic milestones on the international stage.

И.МИШЭЭЛ “SILK WAY STAR”-ИЙН ГРАН ПРИ ШАГНАЛЫГ ХҮРТЭВ

J.MISHEEL WINS THE GRAND PRIX AT “SILK WAY STAR”

Казахстаны нийслэл Астанад 2025 онд зохиогдсон “Silk Way Star” шоуны анхны улирлын Гран При шагналыг дуучин И.Мишээл хүртсэн билээ. Тус шоу нь Азийн анхны олон улсын дууны тэмцээн болж, Азербайжан, Армени, Гүрж, Малайз, Казахстан, Хятад, Киргизстан, Монгол, Тажикистан, Туркменистан, Узбекистан, Өмнөд Солонгос зэрэг 12 улсын дуучид өрсөлдсөн юм.

Тэрбээр ялагчийн шагналаа гардан аваад “Би ялагчийнхаа сэтгэгдлийг монгол эх хэлээрээ хэлмээр байна. Та нартаа маш их баярлалаа. Энэ бол зөвхөн миний дуу хоолой байгаагүй, энэ бол Монгол үндэстний дуу хоолой байсан юм шүү. Монгол үндэстэн бид өөрсдийнхөө бодогоос илүү маш их хүчтэй гэдгийг ойлгоорой” хэмээн баярын сэтгэгдлээ хуваалцсан.

“Silk Way Star” шоуны ялагч И.Мишээлийг хөгжмийн салбарт гаргасан амжилт болон улс орнуудын найрамдалт харилцааг бэхжүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмрийг нь үнэлэн Казахстан улсын Ерөнхийлөгч К.Токаевын зарлигаар “Найрамдлын II зэргийн одон”, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн зарлигаар төрийн дээд “Алтан гадас” одонгоор тус тус шагнасан юм.

Түүний амжилт нь Монголын соёлын түүчээ, өв уламжлалын бэлгэдэл боллоо.



In 2025, singer J. Misheel won the Grand Prix at the first season of “Silk Way Star,” held in Astana, the capital of Kazakhstan. The competition brought together performers from twelve countries, including Azerbaijan, Armenia, Georgia, Malaysia, Kazakhstan, China, Kyrgyzstan, Mongolia, Tajikistan, Turkmenistan, Uzbekistan, and South Korea, making it Asia’s first international singing contest of its kind.

After receiving the award, she said, “I would like to share my thoughts in my mother tongue, Mongolian. Thank you very much. This was not just my voice, it was the voice of the Mongolian nation. We are stronger than we often believe.”

In recognition of her artistic achievements and her role in strengthening ties between countries, she was awarded the Order of “Dostyk” (Friendship) of the II degree, by the President of Kazakhstan, Kassym-Jomart Tokayev, and the Order of the Polar Star, one of Mongolia’s highest state honors, by President Khurelsukh Ukhnaa.

Her success stands as a symbol of Mongolia’s cultural identity and heritage.

Mongol Pride 2025:

UNITY, ACHIEVEMENT, RENEWAL

“PHYSICAL ASIA 2025”: МОНГОЛЫН БАГИЙГ ДЭЛХИЙ ДАХИН ОНЦЛОВ

БНСУ-ын MBC Нэтфликс хамтран 2025 онд "Physical 100" шоу Азийн найман орны баг тамирчдын дунд анх удаа зохион байгуулж, Монгол Улсын баг дэлхийд шинэ өнгө төрхийг үзүүлсэн. Улсын арслан Б.Орхонбаяр ахлагчтай баг Өмнөд Солонгосын багтай финалд тунаж үлдэж, дэд байрт шалгарсан нь Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл байв. Энэ шоу Монголын багийн хүч чадал, тэсвэр тэвчээр, эв нэгдлийг дэлхийд таниулж, Монгол Улсыг шинэ өнгөөс харуулсан юм.



Нэтфликсийн "Physical Asia" шоу дэлхийн 46 орны үзэгчдийг байлдан дагуулж, монголчуудын тэсвэр тэвчээр, өвөрмөц авьяас чадварыг дэлхий дахинд таниулсан бахдам амжилт байв. Уг нэвтрүүлгийн дараа бусад орны зарим тамирчин Монголд ирж, ахуй соёл, спортоор танилцсан юм. Мөн Netflix-ийн уран бүтээлчид Австрали, Өмнөд Солонгос болон Монголын баг тамирчдын хамтарсан "Physical: Welcome to Mongolia" цувралыг бэлтгэн үзэгчдийн хүртээл болгосон. Мөн Монголын спортын салбарын шилдгүүдийг тодруулдаг "Бөртэ чоно-2025" наадмын "Оны онцлох амжилт" номинацийн эзэнээр "Physical asia team" шалгарсан юм.

"Physical Asia" шоу цацагдах цаг мөчид монголчууд цэнхэр дэлгэцийнхээ өмнө нэгэн зэрэг тухлан, тэднээр огшиж баярлаж, нэг үндэстэн гэх сэтгэлээрээ эвлэлдэн нэгдэж чадсан нь бахархалтай билээ.

“THE MONGOLZ” БАГ ЦАХИМ СПОРТЫН ТҮҮХЭНД НЭРЭЭ МӨНХӨЛЛӨӨ

2025 онд "The Mongolz" баг дэлхийн чансааг тэргүүлж, Монголыг цахим спортын шинэ хүчирхэг тоглогч орон гэдгийг харууллаа. Тэд Саудын Арабд зохиогдсон "Esports World Cup 2025"-ийн дэлхийн цомын тэмцээнд түрүүлж, дэлхийд Монголын цахим спортын түүхийг шинэчлэн бичлээ. Тэд Монгол төдийгүй Азийн баг шигшээ тэмцээнд 15 жилийн дараа анхны түрүүг авчирсан амжилтыг дэлхийд зарлаж, дэлхийн чансаагаар эхний 10-т багтсан цорын ганц Ази баг болж, олон улсын томоохон тэмцээнүүдэд шөвгөрсөн юм. Тэд Азийн Counter Strike-ийн түүхэн дэх шилдэг баг болж, HLTV болон Valve-ийн чансаагаар дэлхийд нэгдүгээрт бичигдсэн нь Монголын цахим спортын түүхэнд онцлох амжилт болж үлдлээ.

Тэдний бахдам амжилтууд монголчуудыг нэгтгэж, цахим спортын талаарх ташаа ойлголтыг өөрчилсөн төдийгүй гэр бүл, найз нөхдөөрөө хамтдаа тоглолт үзэн догдох соёлыг бий болгосон юм. Тэд залуусын мөрөөдлийг бодит болгож чадсан.

Зуны турш залуус төв талбай, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн зэрэг газарт цуглан "The Mongolz" багийн тоглолтыг үүр цайтал үзэж дэмжсэн нь 2025 оны онцлох дүр зураг байв.



“PHYSICAL ASIA 2025”: MONGOLIA IN THE GLOBAL SPOTLIGHT

In 2025, the show "Physical 100," produced by MBC in cooperation with Netflix, was held for the first time as a competition among teams from eight Asian countries. The Mongolian team brought a fresh and striking presence to the stage. Led by State Lion B. Orkhonbayar, they reached the final round against South Korea and finished in second place, reflecting the unity of the Mongol people. The program showcased their strength, endurance, and teamwork, offering the world a new way of seeing Mongolia.

The Netflix series "Physical Asia" drew viewers from 46 countries and became a proud moment in sharing the determination and talent of Mongolians with a global audience.

After the show, athletes from several countries traveled to Mongolia to experience its culture, daily life, and sporting traditions. Netflix producers also released a follow up series, "Physical: Welcome to Mongolia," featuring athletes from Australia, South Korea, and Mongolia.

The "Physical Asia team" was later recognized with the "Outstanding Achievement of the Year" award at the "Borte Chono 2025" ceremony, which honors excellence in Mongolian sports.

At the moment "Physical Asia" aired, Mongolians all settled in front of their screens, thrilled and rejoicing with the contestants, united by the feeling of being one nation a truly proud moment

“THE MONGOLZ” MAKE E-SPORT HISTORY

In 2025, "The Mongolz" rose to the top of the global rankings, showing that Mongolia has become a serious force in esports. Their victory at the "Esports World Cup 2025" in Saudi Arabia marked a turning point, placing Mongolian esports firmly on the world map. They secured the first major international title for an Asian team in fifteen years, broke into the global top ten, and reached the later stages of major tournaments.

They went on to become the most successful team in the history of Asian Counter Strike, ranking first in the world according to both HLTV and Valve, an achievement that stands out in Mongolia's esports history.

Their success brought people together, challenged outdated views of esports, and created a shared culture of watching matches with friends and family. For many young people, they turned ambition into something real.

Throughout the summer, crowds gathered in central squares and parks, staying up late into the night to watch and support "The Mongolz." It became one of the defining images of the year.

ХОЛИМОГ ТУЛААНЫ ШИНЭ АВАРГА Б.ЭНХ-ОРГИЛ

"Шандас MMA" дэвжээний тамирчин Б.Энх-Оргил 11 жилийн дараа "ONE Championship"-ийн "One Fight Night-38" тэмцээнд ялалт байгуулж, аваргын бүсийг эх орондоо авчирсан нь Монголын холимог тулааны спортын түүхэн амжилт болсон юм. Тэрбээр өөрөөсөө 10 насаар дүү Бразилийн Фабриког ялж, дэлхийн шилдэг тулаанчдын нэг болсон нь монголчуудын тэсвэр хатуужлыг дэлхий дахинд харуулсан үзүүлэлт байв. Түүний энэ амжилт мөн л ирээдүйн тулааны спортын тамирчдад итгэл найдвар бэлэглэж, эх орноо дэлхий дахинаа сурталчлан таниулсан бахархам үйл явдал болов.

Б.Энх-Оргил нь энэхүү гаргасан амжилтаараа холимог тулааны спортын төрлөөс төрөн гарч буй хоёр дахь Гавьяат тамирчин болсон. Түүний багш Ж.Нарантунгалаг холимог тулааны анхны Гавьяат тамирчин болж байсан юм. Мөн тэрээр "Physical Asia" шоу нэвтрүүлэгт амжилттай оролцож, монгол хүний хүч чадал, тэсвэр, тэвчээр хатуужил, уран ухааныг олон улсад сурталчлан таниулсан билээ.



B. ENKH-ORGIL: A NEW CHAMPION IN MIXED MARTIAL ARTS

B. Enkh-Orgil of the Shandas MMA club claimed victory at ONE Championship's "One Fight Night 38" after an eleven year journey, bringing the championship belt home and marking a milestone for Mongolian mixed martial arts. He defeated Brazil's Fabricio Andrade, who was ten years younger, establishing himself among the top fighters in the world and demonstrating the toughness and determination of Mongolian athletes.

His success has given encouragement to future fighters and served as a proud moment in promoting Mongolia on the international stage.

With this achievement, he became the second athlete from mixed martial arts to receive the title of Honored Athlete of Mongolia, following his coach J. Narantungalag, the first to earn that distinction. He also took part in "Physical Asia," where he represented the strength, resilience, and character of the Mongolian people to a wide audience.

МОНГОЛЫН 3x3 ЭМЭГТЭЙ САГСАН БӨМБӨГИЙН ШИГШЭЭ БАГИЙН ТҮҮХЭН МӨНГӨН МЕДАЛЬ

2025 оны зургаадугаар сард болсон 3x3 сагсан бөмбөгийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсын эмэгтэй шигшээ баг гайхамшигт амжилт үзүүлж, мөнгөн медаль хүртсэн нь үндэсний спортын түүхэнд шинэ хуудсыг нээлээ. Дэлхийн шилдэг багуудтай эн тэнцүү өрсөлдөн, шат дараалан ялалт байгуулсаар финалд шалгарсан нь Монголын 3x3 сагсан бөмбөгийн хөгжил дэлхийн түвшинд хүрснийг батлан харууллаа.

Тэмцээний туршид манай багийн тамирчид хурд, ур чадвар, багийн нягт уялдаа холбоогоороо онцгойрон, өрсөлдөгчдөө хүнд байдалд оруулж байв. Тэдний хичээл зүтгэл, тууштай байдал нь зөвхөн медаль хүртэхээс гадна Монголын эмэгтэй тамирчдын чадамжийг дэлхийд таниулсан онцгой үйл явдал байв.

Энэхүү түүхэн амжилтыг үнэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шигшээ багийн тамирчид "Гавьяат тамирчин" цолыг хүртсэн нь багийн спортын салбартаа анхдагчид нь болсон юм.



HISTORIC SILVER MEDAL FOR MONGOLIA'S WOMEN'S 3X3 BASKETBALL NATIONAL TEAM

At the FIBA 3x3 World Cup held in June 2025, Mongolia's women's national 3x3 team delivered an outstanding performance, claiming the silver medal and marking a new milestone in the country's sporting history. Competing head to head with the world's strongest teams and advancing through each stage with consecutive wins to reach the final clearly demonstrated that Mongolia's 3x3 basketball has reached the global level.

Over the course of the tournament, the team distinguished itself through speed, technical ability, and strong on-court coordination, repeatedly placing their opponents in difficult positions. Their dedication and determination extended beyond winning a medal, marking a defining moment that brought international recognition to the strength of Mongolian women athletes.

In acknowledgment of this achievement, the athletes were awarded the title of "Honored Athlete of Mongolia" by decree of the President of Mongolia, making them the first to receive this distinction in team sports.

ДЭЛХИЙН ДУУРИЙН УРЛАГИЙН ТОД ОД Э.АМАРТУВШИН

Дэлхийн нэр хүндтэй дуурийн театруудад гол дүрийг бүтээж, Монголын нэрийг сонгодог урлагийн оргилд хүргэсэн дуурийн дуучин Э.Амартүвшин бол үндэсний бахархлын тод илэрхийлэл юм. Тэрбээр 2022 оны дэлхийн дуурийн шилдэг 11 дуучны нэгээр тодорч, 2024 онд дэлхийн агуу баритон "Этторэ Бастианини" нэрэмжит "Трофое ди Бронзо" шагнал, 2025 онд Итали улсад зохион байгуулсан "Opera Star Awards"-аас "Шилдэг баритон" шагнал хүртсэн түүхэн амжилтаараа монгол хүний дуу хоолой, ур чадварыг дэлхийд таниулсаар байна.

Дуурийн урлагийн "Оскар"-ын эзэн Э.Амартүвшин СУИС-ийг дуурийн дуучин мэргэжлээр Гавьяат багш Д.Ерөөгийн удирдлаган дор төгсөн 2009-2016 онд Дуурь бүжгийн эрдмийн таертг гоцлол дуучнаар ажиллаж, одоо Бүгд Найрамдах Итали улсад амьдран уран бүтээлээ туурвиж байна.

Э. Амартүвшин Итали, Франц, Их Британи, Испани, Герман, ОХУ, БНХАУ зэрэг дэлхийн нэр хүндтэй тайзнаа уригдан тоглож, монгол хүний хүчирхэг дуу хоолой царааг цуурайтуулсаар байгаа билээ.

Э.Амартүвшин нь 25 насандаа Монгол Улсын Гавьяат жүжигчин, 36 насандаа Монгол Улсын Ардын жүжигчин цол хүртэж, 2025 онд Бүгд Найрамдах Итали Улсын Ерөнхийлөгчийн зарилгаар "Оддын одон"-гоор шагнуулж, Одонгийн офицер цол хүртэн дэлхийн шилдгүүдийг манлайлсаар байгаа нь яах аргагүй түүхэн амжилт юм.



A LEADING VOICE IN WORLD OPERA E. AMARTUVSHIN

Opera singer E. Amartuvshin has taken leading roles on some of the world's most respected stages, bringing Mongolia's name to the forefront of classical music. Named one of the world's top eleven opera singers in 2022, he went on to receive the Trofeo di Bronzo, dedicated to the great baritone Ettore Bastianini, in 2024, and the Best Opera Baritone award at the Opera Star-International Opera Awards 2025 in Italy. Through these achievements, he continues to share Mongolian artistry with international audiences.

He graduated from the Mongolian State University of Arts and Culture under the guidance of Honored Teacher D. Eroo, worked as a soloist at the Mongolian State Academic Theatre of Opera and Ballet from 2009 to 2016, and now continues his work in Italy. He has performed in Italy, France, the United Kingdom, Spain, Germany, Russia, and China, earning recognition for the strength and quality of his voice. He received the title of Honored Artist of Mongolia at 25 and People's Artist at 36. In 2025, he was awarded the Order of the Star by decree of the President of Italy and granted the rank of Officer, confirming his place among the leading figures in opera today.

In 2025, Mongolia achieved notable success across many fields and once again made its presence known around the world. These accomplishments reflect the unity, determination, and ability of the Mongol people, while also strengthening confidence in the future. They stand as a sign of the creativity and solidarity of a new generation and mark a year of real progress in Mongolia's international relations, culture, arts, and sports.



2025 онд Монгол Улс олон салбарт гайхамшигт амжилт гаргаж, дэлхийд өөрсдийгөө дахин таниулсан жил боллоо. Түүхэн ололт, соёлын амжилтууд нь монголчуудын эв нэгдэл, зориг, хичээл зүтгэл, ур чадварын илэрхийлэл болсноор зогсохгүй, ирээдүйдээ итгэх итгэлийг төрүүлсэн билээ. Монголын бахархал болсон эдгээр амжилтууд нь шинэ үеийнхний бүтээлч чадвар, эв нэгдлийг бэлгэдэж, Монгол Улсын гадаад харилцаа, соёл урлаг, спортын салбарт томоохон ололт болсныг харуулсан түүхэн жил байв.

In 2025, Mongolia achieved notable success across many fields and once again made its presence known around the world. These accomplishments reflect the unity, determination, and ability of the Mongol people, while also strengthening confidence in the future. They stand as a sign of the creativity and solidarity of a new generation and mark a year of real progress in Mongolia's international relations, culture, arts, and sports.

Шинэ Зеландын Засгийн газар 2018-2028 онд, 10 жилийн хугацаанд “Нэг тэрбум мод” тарьж ойн салбарын эдийн засгийн өсөлтийг дэмжих, Маори иргэдийн газар нутаг, нөөц баялгийн ашиглалтыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх, хөрс болон усны чанарыг хамгаалж сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх, биологийн олон янз байдлыг нэмэгдүүлэх зэрэг зорилгоор жил бүр 100 сая мод тарихын тулд “Нэг тэрбум модны сан” байгуулжээ.

Энэхүү сан нь буцалтгүй тусламж, түншлэлд суурилсан хамтын санхүүжилт гэсэн үндсэн хоёр хэлбэрээр санхүүжилт олгодог.

1. Буцалтгүй тусламжийн санхүүжилт нь их талбайг хамарсан ойн нөхөн сэргээлтийн төслүүдэд түлхүү олгогддог.

2. Төр болон бусад талууд хамтран хөрөнгө оруулж мод тарих, ойжуулалтыг дэмжих Түншлэлд суурилсан хамтын санхүүжилтээр “зөв модыг зөв газарт, зөв зорилгоор” тарих зарчмыг дэмжих төслүүдийг санхүүжүүлдэг. Эдийн засгийн үр өгөөж авчрах төслүүдэд хөрөнгө оруулахыг зорьдог. Мөн мод тарьж ургуулахад шаардагдах дараах салбаруудыг санхүүжүүлдэг.

- o судалгаа,
- o инновац,
- o хөдөлмөр эрхлэлт
- o мэдээлэл болон зөвлөгөө зэрэг багтана.

Мөн дээрх хэлбэрийн санхүүжилт хосолсон хэлбэрээр төслүүдийг санхүүжүүлэх тохиолдол ч байдаг.



“Нэг тэрбум мод”-ны дэд хөтөлбөрүүд

- Crown Forestry Joint Ventures хөтөлбөр нь ой мод тарьж ургуулах олон талт ажлын нэг нь хувийн эзэмшлийн газарт арилжааны зориулалттай ойжуулалт хийхийг дэмжих зорилготой.

- Hill Country Erosion хөтөлбөр нь хөрсний элэгдэлд өртөмтгий бүс нутгийг хамгаалах

- Afforestation Grant Scheme нь ойгүй газарт ой тарих хөтөлбөр

Санхүүжилт авах нөхцлүүд

1. Тухайн газрыг та өмчилдөг эсвэл мод тарих зориулалт бүхий газар байх

2. Бусад ижил төстэй хөтөлбөрт давхар хамрагдаагүй байх

3. Тухайн газарт сүүлийн 5 жилийн хугацаанд ой байгаагүй байх. Тарьж буй мод нь тухайн орчинд нас бие гүйцэх үедээ 5 метрээс дээш өндөрт хүрэх боломжтой байх (жимс, самрын зориулалттай мод энэ схемд хамаарахгүй)

4. Модны нягтрал нь ихэнх тохиолдолд нэг га талбайд дор хаяж 750 ширхэг суулгац тарьсан байх, мөн тарьснаас хойш 2–12 сарын дараа энэ тооны мод амьд, хэвийн ургалттай байх

5. Ойжуулалтын төсөл нь нас бие гүйцэх үедээ дунджаар 30 метрээс доошгүй титмийн өргөнтэй ой бүрдүүлэх боломжтой байх

Санхүүжилтийн хэмжээ:

- Уугуул мод тарихад нэг га талбайд 4,000 ам.доллар
- Ойн нөхөн сэргээлтэд нэг га талбайд 1,000 ам.доллар.
- Манука/Канука мод тарихад нэг га талбайд 1,800 ам.доллар
- Харь зүйлийн мод тарихад нэг гектарт 1,500 ам.доллар.

Өргөдөл хүлээн авах хугацаа

“Нэг тэрбум мод” сангийн хүрээнд жилийн турш хүссэн үедээ өргөдөл гаргах боломжтой бөгөөд өргөдлийг хоёр сарын дотор шийдвэрлэх зорилт тавин ажиллаж байна.

Төлбөрийг үе шаттайгаар олгоно.

Гэрээний хугацаа 10 жил байх бөгөөд санхүүжилтийг тодорхой үе шатуудад хуваан олгоно. Харьцангуй энгийн төслүүдийн хувьд санхүүжилтийг хоёр үе шаттай олгоно. Үүнд:

- Төслийг эхлүүлэхээр гэрээ
- байгуулсны дараа 30% урьдчилгаа олгоно
- Үлдсэн төлбөрийг мод тарьж, талбайг амжилттай байгуулсны дараа олгоно
- Хүлэмжийн хийн ялгарлын худалдааны систем (ETS)-д хамрагдах боломж

Тарьсан модоо хүлэмжийн хийн ялгарлын худалдааны системд бүртгүүлснээр санхүүжилт авах боломжийг бүрдүүлсэн явдал юм. Үүний тулд 1989 оноос хойш үүссэн ой гэсэн тодорхойлолтод нийцсэн байх ёстой.

Эх сурвалж: <https://www.nzffa.org.nz/farm-forestry-model/tree-grower-articles/may-2019/one-billion-trees---our-forest-future/>

ШИНЭ ЗӨ



Биелэлт

2025 оны 11 сарын байдлаар:

800,969,000 ш мод тарьж ургуулжээ.

НЭГ ТЭРБУМ МОД ТАРИХ ХӨТӨЛБӨР

NEW ZEALAND'S One Billion Trees Programme

The Government of New Zealand launched the “One Billion Trees” programme for the period 2018–2028. The goal is to plant one billion trees over 10 years by planting approximately 100 million trees annually. This initiative aims to support economic growth in the forestry

sector, increase opportunities for Māori communities to utilize their land and resources, protect and improve soil and water quality, meet climate change commitments and enhance biodiversity. To implement this, the government established the One Billion Trees Fund.

Funding Mechanisms

The fund provides financial support through two main mechanisms:

1. Grant Funding is primarily allocated to large-scale forest restoration projects. It focuses on environmental benefits such as ecosystem recovery and sustainability.
2. Partnership (Co-investment) funding based on collaboration between the government and other stakeholders supports projects that follow the principle of “the right tree in the right place for the right purpose”. Targets projects that generate economic returns.

In addition, this funding also supports related sectors such as:

- Research
- Innovation
- Employment
- Information and advisory services

services

In some cases, projects may be financed through a combination of both grant funding and co-investment partnership funding mechanisms.

Sub-programmes of the One Billion Trees Initiative

1. Crown Forestry Joint Ventures Programme

- Supports forestry development through partnerships
- Encourages commercial afforestation on privately owned land

2. Hill Country Erosion Programme

- Aims to protect erosion-prone land
- Focuses on improving land stability and reducing soil degradation

3. Afforestation Grant Scheme

- Provides funding to plant forests on previously non-forested land
- Eligibility Criteria for Funding

To qualify for funding, the following conditions must be met:

1. The applicant must own the land or have land designated for tree planting
2. The project must not be receiving funding from other similar programmes
3. The land must not have been forested in the past 5 years, suitable for trees that can grow to at least 5 meters in height at maturity, fruit and nut trees are not eligible under this scheme.
4. Tree density must be at least 750 seedlings per hectare planted, within 2–12 months, these trees must remain alive and show healthy growth.
5. The project must be capable of developing into a forest with an average canopy cover of at least 30% at maturity.

Funding Amounts

Funding is provided per hectare depending on the type of tree planting:

- Native tree planting: USD 4,000 per hectare
- Reforestation: USD 1,000 per hectare
- Manuka/Kanuka planting: USD 1,800 per hectare
- Exotic (non-native) species planting: USD 1,500 per hectare

Application Timeline

Under the One Billion Trees Fund, applications can be submitted at any time throughout the year. The programme aims to process applications within two months

Payment Structure

Funding is provided in stages over the contract period, which typically lasts 10 years.

For relatively simple projects, payments are made in two stages:

1. 30% advance payment is provided after signing the contract
2. The remaining payment is made after successful planting and establishment of the forest

Emissions Trading Scheme (ETS) Eligibility

Participants may also benefit from registering their forests in Emissions Trading Scheme (ETS). This allows them to earn additional income through carbon credits. The forest must meet the definition of post-1989 forest land.




Implementation

A total of **800,969,000** trees have been planted as of November 2025.

Source: <https://www.nzffa.org.nz/farm-forestry-model/tree-grower-articles/may-2019/one-billion-trees---our-forest-future/>

Н.ОЮУНБАТЫН НОГООН



“Хэрвээ манай үйлдвэр байгаагүй бол энэ их уул, овоо шиг яс хогийн цэгт овоорч, эсвэл байгальд хаягдах байсан гэхээр зүрх шимширэхгүй байхын аргагүй.” Эдгээр үгсийг малын түүхий эд болох ясаар органик бордоо үйлдвэрлэдэг “Протеин” үйлдвэрийн үүсгэн байгуулагч Н.Оюунбат цахим хуудсандаа бичжээ. Түүний хувьд энэ бол зүгээр нэг бизнесийн тухай бус, эх орон, байгаль дэлхий, ирээдүй хойч үеийн өмнө хүлээсэн харуцлагын илэрхийлэл юм.

10 жилийн өмнө түүнтэй уулзсан бол Италийн “United Colors of Benetton” брэндийг Монгол Улсад албан ёсны эрхтэйгээр оруулж ирсэн амжилттай бизнес эрхлэгчийнх нь хувиар ярьж суух байлаа. Харин өнөөдөр тэр үндэсний үйлдвэрлэл, байгаль хамгаалал, ногоон хөгжлийн төлөө өөрийн хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж байгаа билээ.

“If our factory did not exist, these vast piles of bones would have been stacked like mountains at landfills or discarded into nature, and it is impossible not to feel a deep ache when thinking about it.” These words were shared on social media by N. Oyunbat, founder of the “Protein” factory, which produces organic fertilizer from livestock raw materials such as bones. For her, this work is not simply about business, but a reflection of the responsibility she feels toward her homeland, the natural environment, and future generations.

If one had met her ten years ago, she would have been known as a successful entrepreneur who officially brought the Italian brand United Colors of Benetton to Mongolia. Today, however, she is devoting her energy and effort to national manufacturing, environmental protection, and green development.

ДЭЛХИЙН БРЭНДЭЭС ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ РҮҮ

Н.Оюунбат 2010 онд Монгол Улсад үүд хаалгаа нээсэн хамгийн анхны дэлхийн брэнд болох “Benetton”-ыг оруулж ирсэн нэгэн. Түүний хувьд энэ брэнд амьдралынх нь салшгүй хэсэг, үнэ цэнтэй, хайртай бизнес нь байсаар ирсэн ч “дандаа гаднаас худалдан авдаг бус, үйлдвэрлэгч орон болох ёстой” гэх итгэл үнэмшил нь түүнийг үйлдвэрлэлийн салбар луу хөтөлжээ.

Тэрбээр Украинд сургууль төгсөөд гутлын үйлдвэрт технологичоор ажиллаж эхэлсэн нь үйлдвэрлэл улс оронд ямар чухал болохыг залуу наснаасаа ойлгоход нөлөөлсөн гэдэг. Иймээс “Benetton”-оос гадна ямар үйлдвэрлэл эрхэлж, экспорт хийж, эх орондоо бодит хувь нэмэр оруулах вэ гэсэн асуултад хариу хайж эхэлжээ. Энэ эрэл хайгуул түүнийг хөдөө аж ахуйн салбар, тэр дундаа малын гаралтай түүхий эдийг бүрэн ашиглах боломж руу чиглүүлсэн байна.

МАЛЫН БАЯЛГИЙГ БҮРЭН АШИГЛАХ СТРАТЕГИЙН ШИЙДЭЛ

Монгол Улс 70 сая гаруй малтай, уул уурхайгаас гадна мал аж ахуйд түшиглэсэн эдийн засагтай орон. Гэвч малын гаралтай түүхий эдийн ихэнх хэсэг нь бүрэн ашиглагдалгүй хаягдал болж ирсэн нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг. Үүнийг өөрчлөх гарц нь яс болон малын түүхий эдийг боловсруулах стратегийн үйлдвэр гэж Н.Оюунбат үзжээ.

Ингээд 2017 оноос өөрийн бүх хуримтлалаа зориулж, Италийн тоног төхөөрөмж захиалан Хөгжлийн банкны зээлээр Эмээлтэд газар худалдан авч, үйлдвэрийн дэд бүтцийг байгуулж эхэлсэн байна. Олон жилийн хөдөлмөрийн үр дүнд 2019 оны эхээр “Протеин” үйлдвэрийн нээлт болж, тухайн үеийн Ерөнхий сайд, өнөөгийн Ерөнхийлөгч У.Хүрэлсүх оролцсон нь уг үйлдвэрийн ач холбогдлыг илтгэх үйл явдал байв.

FROM A GLOBAL BRAND TO NATIONAL MANUFACTURING

N. Oyunbat is the person who introduced Benetton, the first global brand to officially enter the Mongolian market, in 2010. Although the brand has remained an integral and cherished part of her life and business, her conviction that Mongolia should not rely solely on imports but should become a manufacturing nation ultimately led her into the production sector.

After graduating from university in Ukraine, she began her career as a technologist at a shoe factory. This experience helped her understand from an early age how essential manufacturing is to a country's development. She therefore began to seek answers to a central question: what kind of production could she pursue alongside Benetton, what could she manufacture and export, and how could she make a tangible contribution to her homeland. That search led her to the agricultural sector, and in particular to the idea of fully utilizing livestock derived raw materials.

A STRATEGIC DECISION TO FULLY UTILIZE LIVESTOCK RESOURCES

Mongolia is a country with more than 70 million head of livestock and an economy based on animal husbandry alongside mining. Yet for many years, a large portion of livestock raw materials has gone unused, turning into waste and causing harm to the environment. N. Oyunbat came to view the processing of bones and other livestock raw materials as a strategic solution to this problem.

Beginning in 2017, she invested all of her personal savings, ordered equipment from Italy, purchased land in Emeelt through a loan from the Development Bank, and began building the factory's infrastructure. After years of sustained effort, the “Protein” factory officially opened in early 2019. The opening ceremony was attended by the then Prime Minister and current President Khurelsukh Ukhnaa, underscoring the importance of the project.

ИРЭЭДҮЙН ШИЙДЭЛ

N.OYUNBAT'S GREEN FUTURE SOLUTION



ЯСНААС БОРДОО, ТОС, ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЖ ЭХЛЭВ

“Протейн” үйлдвэр хоногт 100 тонн түүхий эд боловсруулах хүчин чадалтай ч одоогоор 40 орчим хувийн ачаалалтай ажиллаж байна. Гэсэн хэдий ч зах зээл жилээс жилд тэлж, борлуулалт тогтвортой өсөж буй.

Яснаас зөвхөн органик бордоо үйлдвэрлээд зогсохгүй ясны тос ялган авч, Солонгос Улс руу экспортолдог. Энэхүү тосноос цаашлаад 80 гаруй төрлийн бодис гарган авах боломжтой нь малын гаралтай түүхий эдийн үнэт чанарыг тод харуулж байна.

ОРГАНИК БОРДООНЫ ДАВУУ ТАЛ БА НОГООН ИРЭЭДҮЙ

Монгол орны эрс тэс уур амьсгалд мод тарих, хөрсний үржил шимийг хамгаалахад органик бордооны ач холбогдол асар их. Н.Оюунбатын онцолсноор яснаас гарган авсан органик бордоо нь хөрсний бичил орчныг амилуулж, ус чийгийг хадгалах чадварыг эрс нэмэгдүүлдэг.

Нэг удаа дунджаар 300 грамм бордоо ашиглан усалснаар мод ургах нөхцөлийг 70-80 хувьд хүргэх боломжтой бөгөөд задрал нь Монголын нөхцөлд 24-36 сарын турш үргэлжилдэг байна. Энэ нь усалгааны зардал өндөртэй манай орны хувьд бодит шийдэл юм.

Нэг удаа дунджаар



300 грамм
БОРДОО
ашиглан
усалснаар мод
ургах нөхцөлийг



70-80
хувьд хүргэх
боломжтой
бөгөөд задрал
нь Монголын
нөхцөлд



24-36
сарын турш
үргэлжилдэг
байна.



PRODUCING FERTILIZER, OIL, AND EXPORT PRODUCTS FROM BONES

The “Protein” factory has the capacity to process 100 tons of raw materials per day, although it is currently operating at roughly 40 percent of that capacity. Even so, the market continues to expand year by year, and sales are growing steadily.

In addition to producing organic fertilizer from bones, the factory extracts bone oil, which is exported to the Republic of Korea. From this oil alone, it is possible to derive more than 80 different substances, clearly demonstrating the value and potential of livestock derived raw materials.

THE BENEFITS OF ORGANIC FERTILIZER AND A GREEN FUTURE

In Mongolia's harsh climate, organic fertilizer plays a critical role in tree planting and in preserving soil fertility. As N. Oyunbat emphasizes, organic fertilizer produced from bones revitalizes the soil's microenvironment and significantly improves its ability to retain moisture.

By applying an average of 300 grams of fertilizer per use, conditions for tree growth can be improved to 70 to 80 percent. Under conditions in Mongolia, the fertilizer continues to decompose over a period of 24 to 36 months. This makes it a practical solution for a country where irrigation costs are high.



“ТЭРБУМ МОД” БА КАРБОН КРЕДИТИЙН БОЛОМЖ

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг Н.Оюунбат цаг үеэ олсон, байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг чухал алхам гэж үздэг. Тус компанийн зүгээс Хархоринд хэрэгжиж буй мод тарих төсөлд зуун мянган мод тарих бордоо хандивласан нь үүний илэрхийлэл.

Цаашид карбон кредитийн тогтолцоог хөгжүүлж чадвал тарьсан мод бүр эдийн засгийн бодит өгөөжтэй болж, байгаль хамгаалал, бизнесийн ашиг сонирхол хоёрыг хослуулах боломж бүрдэх аж.

ЭХ ОРОН, ИРЭЭДҮЙ ХОЙЧИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ

“Газарт булагдаж, байгаль бохирдуулж байсан хаягдлыг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгож байгаа маань надад хамгийн том мотиваци болдог” хэмээн Н.Оюунбат өгүүлдэг. “Үйлдвэртээ орохоор миний нулимс цийлгэнэдэг. Өвөг дээдэс маань бидэнд үржил шимтэй хөрс, цэцэгт ногоон тал, цэнгэг гол мөрөн, онгон дагшин уул толгодоо өвлүүдэн үлдээсэн. Бид энэ баялгаа ухаж зарах биш, хайрлан хамгаалж, дараа дараагийн үр хойчдоо өвлүүлэн үлдээх үүрэг хүлээсэн хүмүүс. Тийм ч утгаараа энэ салбарт ажиллаж байгаагаараа бахархдаг” хэмээх түүний үгс нь энэ ажлыг зүгээр нэг бизнес бус, эх орондоо үлдээх үнэт өв гэж харж буйг илтгэнэ.

Үйлдвэрлэгч орон болох мөрөөдөл бол ганц хүний бус, монгол хүн бүрийн мөрөөдөл байх ёстой. “Протейн” үйлдвэрийн түүх үүний бодит жишээ юм.



THE ‘BILLION OF TREES’ MOVEMENT AND THE POTENTIAL OF CARBON CREDITS

N. Oyunbat views the “Billion of Trees” National Movement of Mongolia as a timely and meaningful response to environmental degradation and climate change. As a concrete expression of this support, the company donated fertilizer for the planting of one hundred thousand trees as part of a tree planting project underway in Kharkhorin.

Looking ahead, if a carbon credit system can be developed, each planted tree could generate real economic value, creating an opportunity to align environmental protection with business interests.

A RESPONSIBILITY TO THE HOMELAND AND FUTURE GENERATIONS

“Turning waste that once polluted the environment into a finished product is my greatest source of motivation,” N. Oyunbat says. “When I enter the factory, my eyes fill with tears. Our ancestors left us fertile soil, green and flowering steppe, clear rivers, and pristine mountains and hills. We are not meant to dig up and sell this wealth, but to protect it and pass it on to future generations. That is why I am proud to be working in this field.” Her words show that she sees this work not merely as a business, but as a valuable legacy to leave to her homeland.

The dream of becoming a manufacturing nation should not belong to one individual alone, but to every Mongolian. The story of the “Protein” factory stands as a clear and living example of this vision.



TOP DONJ
MONGOLIAN CASHMERE

EVSEG
Mongolian Premium Cashmere

NIRUN
MONGOLIAN CASHMERE



ALFRED ROWLAND
LONDON



FOR TOURIST

LARGEST CASHMERE FACTORY TOUR

FASHION SHOW
Every day free! 09:00-20:00

WOVEN SCARF
BUY 5 GET 1 FREE

GLOVES & SOCKS
BUY 4 GET 1 FREE

100% CASHMERE COAT
BUY A COAT + SCARF FOR FREE

Starting from \$150

FACTORY STORE FACTORY PRICE

MONGOLIAN LARGEST CASHMERE FACTORY

NOMADIC THEATER

Performance Schedule
Concert hall:
on the 2nd floor of Evseg cashmere



EVSEG FACTORY STORE
On the road to Zaisan hill, southwest to the Bogd khan's winter palace museum



CONTACT US
Tel: 11-342598, 9995-3027
E-mail: export@cashmereholding.com

ТЕХНОЛОГИЙН ЭСРЭГ ЗАРЛАСАН БАЙГАЛИЙН ДАЙНД БУУЖ ӨГӨХ ҮҮ?!

*-Байгалийн харилцан шүтэлцлийг хүмүүс бид
хүндэтгэн хүлээн зөвшөөрч, түүнд нийцэж
чадвал байгаль өөрийгөө анагаан эдгээх
увидастай билээ-*

WILL WE SURRENDER TO NATURE'S WAR ON TECHNOLOGY?!

*-If humans honor and respect nature's interdependence
and live in harmony with it, the natural world has the
wisdom to heal and restore itself. -*



З.БОРГИЛМАА

Дэлхий хэмээх цэнхэр гараг дээр оршин суугаа хүн төрөлхтөний ирээдүйг технологийн хөгжилгүйгээр төсөөлөх аргагүй болжээ. Гэвч ухрах замгүйгээр урагшиж буй энэхүү дэвшил байгалийн хүчин зүйлийн өмнө хааяа бууж өгдгийг бид анзаардаггүй. Технологийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлж буй Япон, Солонгос, Хятад зэрэг гүрнүүд хавартаа дэгддэг шар шороон шуурганы үеэр бичил нарийн электрон төхөөрөмжүүд рүү шургалж амждаг нарийн ширхэгт тоосонцрын аюулыг хэрхэхээ мэдэхгүй байгаа гэдэгт хэн маань итгэх вэ?!

Тогтвортой хөгжлийн бодлого гэдэг нь алс хэтдээ улам ч томорч мэдэх аливаа асуудал, аюулыг урьдчилан тооцоолж, үр урхгаас нь зайлсхийх арга замыг угтуулан хэрэгжүүлэхийг хэлдэг. Энэ ч утгаар БНХАУ технологийн хөгжлийн өмнө хөндөлсөх байгалийн хүчин зүйл болох шар шороон шуурганы хөнөөлөөс зайлсхийхийн тулд говь, хээрийн бүс зонхилох хойд нутгуудаа ойжуулах ажлыг эхлүүлсэн юм. Энэ бол газар зүйн байршлын хувьд Монголын говь, хээртэй хил залгаа бүс нутаг бөгөөд байгалийн экосистемд хил хязгаарын ялгаа үгүй билээ. Улс орнууд урт хугацааны бодлогын үр дүнд сул шороон хөрсийг тарималжуулах, ойжуулах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн ч өнөө шар шороон шуурганы чимээгүй хөнөөл төдийлөн буураагүйг үүнд өртөгч улс орнууд онцлон тэмдэглэх болов. Тэгвэл шар шороон шуурга Монголын говиос дэгдэж байна уу?!

Төв Азийн өндөрлөг, хуурай, эх газрын уур амьсгалтай Монгол орны говь, хээрийн бүсээс дэгдэх шар шороон шуурганд хил гааль нэвтрэх, хэдэн улс орон дамнах зөвшөөрөл гэх зүйлс огт хамаагүй. Энэ бол байгаль дэлхийтэйгээ ойлголцох хэлийг биднээс шаардаж буй үзэгдэл юм. Эх дэлхий, байгаль ертөнц бол бидний бүтээгч. Бид хөгжил дэвшлийн оргил руу хэчнээн гайхамшигтайгаар дүүлэн нисэвч түүний өмнө л бууж өгөх болно. Гагцхүү түүнтэй ойлголцон түүний жам ёсонд нийцэх ёстой. Үүнийг ногоон хөгжил хэмээн тодорхойлж буй.

Z.BORGILMAA

On our blue planet, it is almost impossible to imagine humanity's future without technological progress. Yet, we often overlook that even the most relentless advancements sometimes yield before the forces of nature. Consider this: countries like Japan, South Korea, and China lead the world in producing technology, but who would believe they truly know how to defend delicate electronics from the fine dust that infiltrates devices during springtime yellow dust storms?

Sustainable development is more than a policy; it is the ability to anticipate challenges that may grow over decades and to take steps to prevent or mitigate them before they become crises. In this spirit, China has begun afforestation across its northern deserts and steppes to limit the damage caused by yellow dust storms, a natural phenomenon that interferes with technological progress. Geographically, these regions border Mongolia's deserts and steppes, where nature does not recognize borders or political boundaries. Despite long-term efforts to stabilize loose soil and transform barren lands, experts note that the silent threat of yellow dust storms persists. This raises an important question: do these storms originate in Mongolia's Gobi Desert?!

In Mongolia's highlands, where the desert and steppe are shaped by a harsh continental climate, yellow dust storms disregard borders, customs, or permits as they sweep across countries, reminding us that the natural world demands communication on its own terms. Earth is our creator, and no matter how far we advance toward progress, we will ultimately yield to its power. The only way forward is to understand nature's ways and align ourselves with them, because technology alone cannot overcome the forces of the natural world. Any attempt to do so is futile.

Монголын их говь, хээрээс дэгдэж буй шар шороон шуурга тэнгэр баганадсан барилгуудын өндөртэй зэрэгцэн агаарт хуйларч, хэчнээн нарийн технологийн хөшиг хаалт босговч компьютер, электрон эд ангийн гүн рүү үл үзэгдэх байдлаар нэвтэрч дөнгөдгийг үнэхээр гайхширам. Үүнээс сэргийлэх арга бий гэж үү?

Анзаарвал шар шороон шуурга зөвхөн хаварт л дайлаар морддог. Агаарын чийгшил өндөр улиралд огт үзэгддэггүй. Нэг үгээр бол чийг маш чухал нөлөөтэй байх нь. Магадгүй шийдвэрлэх нөлөөтэй. Энэ чухам юу гэсэн үг гээч? Тийм ээ, шар шороон шуургыг хазаарлая гэвэл сүүлийн хэдэн арван жилд эрчимжсэн цөлжилт, хөрсний доройтолтой тэмцэх, үүний тулд мод тарих ёс суртахууны үүрэг монголчууд бидэнд ногдсоныг сануулах мэт. Яг ийм цаг үед Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх НҮБ-ын ногоон чулуун индрээс тэрбум мод тарих амлалтыг өгснөөр “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” өрнөсөн билээ.



Мод сул шороон хөрсийг барьж, агаарт хүчилтөрөгч өгөхөөс гадна түүний ногоон навч, шилмүүс агаарт чийг түгээж, чийгний нөлөөгөөр өөртөө агаар дахь тоосонцор, бохирдлыг шингээдэг. Нэг мод нас бие гүйцэж энэхүү зохицуулагчийн үүргээ гүйцэтгэх хүртэл 20-30 жил шаарддагддаг тул ердөө хоёроос гурван жилд бүрэн төлждөг хөрсний таримал ургамлаар үүнийг шийдэж болох арга замыг өмнөд хөршийнхөн маань бас туршиж амжсан. Гэвч модыг юугаар ч орлуулшгүй гэдгийг л нотолсон гэх.

Өөр бусад арга замыг эрэлхийлсэн ч эцэстээ хамгийн төгс хариулт бол мод тарьж ургуулах...

Гэхдээ мод тарьж ургуулахаас гадна Монголын говьд өөр нэг шийдэл бий.

НУУР БИЙ БОЛ МОД БУЙ

Монголын их говьд мяралзан цэлэлцэх, ёроолын чулууд нь өнгө өнгөөр гялталзах цэнгэг уст цэлгэр нуурууд байдаггүй боловч элсэн говь цөлдөө далай мэт ачлалтай хэдэн арван нуур байснаас өдгөө 26 нь хэдийнээ ширгэжээ. Хамгийн гайхалтай нь тэдгээр ширгэсэн 26 нуурыг багтааж буй 250 км радиус бүхий газар нутаг шар шороон шуурганы

It is astonishing to see how dust storms from Mongolia's vast deserts swirl through the air, rising to the height of multi-story glass buildings and penetrating deep into computers and electronics, entirely unseen. Can this be prevented?

Observing closely, one notices that yellow dust storms strike only in spring. They disappear when humidity rises, which suggests that moisture plays a crucial role. Perhaps it is even decisive. This offers a vital lesson: if we wish to restrain yellow dust storms, we must fight desertification and soil degradation, responsibilities that have been placed upon the Mongolian people. In response, the President of Mongolia Khurelsukh Ukhnaa pledged at the United Nations to plant one billion trees, which led to the launch of the “Billions Trees National Movement”.

Trees stabilize loose soil, release oxygen into the air, spread moisture through their foliage, and capture dust and pollutants. A single tree may require 20 to 30 years to fully mature and perform this regulating function, and although methods such as planting short-term crops have been tried elsewhere, they cannot replace the tree. Afforestation and reforestation remains the most effective solution. Yet beyond planting trees, Mongolia's deserts offer another approach.

WHERE THERE IS WATER, THERE ARE TREES

The great deserts of Mongolia have never hosted large, crystal-clear lakes, yet historically there were dozens of lakes scattered across the sands, which gave life and scale to the desert. Today, 26 of them have dried up, and experts have identified that these dried lakes lie at the center of yellow dust storm activity within a 250-kilometer radius. Restoring them could reduce the impact of yellow dust storms by 20 to 30 percent. The question is how to achieve this.



голомт болж байгааг Монголын мэргэжилтнүүд тооцоолжээ. Тэдгээр нууруудыг эргэн сэргээхэд шар шороон шуурганы хөнөөлийг 20-30 хувиар бууруулах боломжтойг ч тооцоолсон юм. Харин нууруудыг сэргээх боломж бий юу гэдэгт ч хариулт бэлдээд буй.

ТЭГВЭЛ ЯАЖ?

Өвлийн улиралд тэдгээр нуурууд руу аль болох их хэмжээний усыг өгнө гэсэн үг. Хавар газар гэхэд үеэр хайлж гэсээд халиа тошин үүсгэж, хөлийн аясаар наль шаль хийх хэмжээнд усыг говь руу татах боломж байгаа. Үүний нэг шийдэл нь Орхон-Онги, Хэрлэн-Тооно төслөөс гадна Туул голын усыг ашиглах юм. Энэ нь ямар нэг инженер техникийн шийдэл, барилга байгууламж босгох тухай биш юм. Байгалийн өөрийнх нь хуулийг үүнд ашиглах бололцоо бий.

Улаанбаатар хотынхныг ундаалдаг Туул голын усыг урагш говь рүү чиглүүлэх байгалийн инженерчлэл бараг бэлэн гэж хэлж болно. Нийслэлчүүдийн хоногийн усны хэрэглээ 350 мянган шоо метр орчим. Үүнийгээ Туул гол руу нийлүүлдэг. Түүний урсцын хурд секундэд 20 шоо метр. Улаанбаатар хот дундуур зүүнээс баруун тийш урсдаг Туул гол явсаар Төв аймгийн Алтанбулаг сумын нутгаар дайрч өнгөрмөгцөө Лүн сумын нутагт огцом урагшаа тохойроод хойш чиглэн урсдаг онцлогтой. Лүн сумын нутаг тохойрдог хэсэг байнга үерлэдэг. Яг энэхүү байгалийн онцлогийг ашиглан үерийг дагуулан урагш говийн бүс рүү урсгалыг татах боломж бий гэж мэргэжилтнүүд хэдийнэ тооцоолсон юм.

Говийн нууруудын гүн ердөө 20-50 см-ийн гүнтэй учир мөнөөх ширгэсэн нууруудыг услах нь тийм ч хэцүү зүйл биш аж. Нуур орчмын хөрсний онцлог нь ногоон ургамал ургахгүй ч сэргэсэн тохиолдолд мод ургуулахад бүрэн боломжтой.

Шар шороон шуурганы голомт болж буй говийн нууруудыг сэргээснээр дэгдэлт буурахын зэрэгцээ мод тарих нөхцөл бүрдэнэ. Нуур бий бол мод буй. Нэг үгээр бол ширгэсэн нууруудаа сэргээж, нууруудыг дагуулан мод тарих нь бидний зорьж буй Тэрбум мод үндэсний хөдөлгөөний үр дүнг улам бүр тодотгох үнэ цэн, бас сорилт. Мөн технологийн эрин үеийг сүрдүүлж буй шар шороон шуурга болон цөлжилт, хөрсний доройтлыг бууруулахад хүн төрөлхтний өмнө хүлээж буй үүрэг.

Говийн хөрсийг чийгээр тэтгэх өөр нэг арга харагдаж буй нь хөрс рүү цооног, худаг гаргаж гадаргын усыг нэвчээх. Гайхмаар сонсогдож байгаа биз? Газрын гүний усыг цооног, худгаар дээш татаж гаргадаг бол энэ нь эсрэгээрээ хөрс рүү ус өгөх арга. Говийн хөрсний нэг онцлог нь өнгөн давхаргынхаа дор ус үл нэвчүүлэх давхаргатай байдаг явдал. Чухамдаа ус үл нэвчүүлэх давхаргыг нэвтрэн хөрс рүү ус өгөх цооног, худгуудыг тодорхой цэгүүдэд байгуулвал тэнд мод ургуулах бололцоотой. Нэг модыг тарьж ургуулахад 70 литр ус хэрэгтэй ч түүнийг байгалийн аргаар илүү хялбараар шийдэж болно гэсэн үг. Усгүйгээр, наргүйгээр модыг төсөөлөх аргагүй, модгүйгээр усыг төсөөлөх ч боломжгүй. Гэхдээ байгалийн харилцан шүтэлцлийг хүмүүс бид хүндэтгэн хүлээн зөвшөөрч, түүнд нийцэж чадвал байгаль өөрийгөө анагаан эдгээх увидастай билээ.



Туул голын айсаг
The Tuul river basin

THEN HOW?

The solution begins with winter water. When snow melts in spring, streams naturally form, and it is possible to guide this water toward the desert. One possible solution, alongside the Orkhon-Ongi and Kherlen-Toono projects, is to utilize the water of the Tuul River.

This does not require large engineering projects or the construction of dams. Nature itself provides a solution. It can be said that the natural engineering to direct the waters of the Tuul River, which supplies Ulaanbaatar residents with drinking water, southward toward the desert is nearly ready. The daily water consumption of the capital is approximately 350,000 cubic meters, and this water is supplied to the Tuul River. The river flows through Ulaanbaatar from east to west, and after passing through Altanbulag district in Tuv Province, it bends sharply in Lun district, first flowing south and then turning back north in its course. The area around the bend in Lun district is prone to frequent flooding. Experts have already calculated that this natural feature could be used to carry water southward, into the desert, by taking advantage of the flood flow. The river's flow speed is about 20 cubic meters per second, further highlighting the scale of this potential.

Desert lakes are shallow, only 20 to 50 centimeters deep, so restoring the dried lakes is feasible. While the soil may initially resist plant growth, once revived it can support trees. By replenishing lakes, we reduce dust storms and create conditions suitable for afforestation. Where there is water, trees follow. Reviving lakes and planting trees along their edges enhances both the impact and the significance of the "Billions of Trees national movement". It is humanity's responsibility to address the threats of dust storms, desertification, and soil degradation, even as technology advances.

Another approach involves channeling surface water into the soil through wells and boreholes. Although wells are usually designed to extract water, they can also be used to deliver it into the ground. Desert soils often contain an impermeable layer beneath the surface, but by strategically placing boreholes, water can penetrate the soil and support tree growth. While each tree requires roughly 70 liters of water, natural methods can provide it efficiently. Trees cannot survive without water and sunlight, and water cannot achieve its potential without trees. If humans respect nature's interdependence and act in accordance with it, the earth retains the ability to heal and restore itself, creating a future in which technology and nature coexist in balance.

МОНГОЛ ЦЭРГИЙН ТҮҮХИЙГ ЗАЛГАМЖЛАГЧИД



Евроазийн түүхэнд хамгийн өргөн уудам нутаг дэвсгэрийг хамарсан эзэнт гүрнийг байгуулсан Чингис хаан болон түүний залгамжлагчдын байлдан дагууллыг монгол цэргийн оролцоогүйгээр төсөөлөхийн аргагүй билээ.

Төрт улсын түүхэнд тод мөрөө үлдээсээр ирсэн монгол цэргийн түүхийг өдгөө цагт залгамжлагчид нь Монгол Улсын Зэвсэгт хүчин, тэдний нэг хэсэг болох цэнхэр дуулгат энхийг сахиулагчид юм. Монголын орчин үеийн зэвсэгт хүчний үүслийг 1921 оны гуравдугаар сарын 18-нд жанжин Д.Сүхбаатарын удирдсан Ардын цэрэг Хиагтыг чөлөөлсөн түүхт өдрөөр тэмдэглэснээс хойш өдгөө зуу гаруй жилийн түүхийг бичээд байна. Энэ өдрийг “Монгол цэргийн өдөр” болгон жил бүр тэмдэглэдэг.

Монгол цэргийн өдрийн нэгэн тод өнгө бол дэлхийн халуун цэгүүдэд энх тайвныг сахин хамгаалж, “цэнхэр дуулга”-аараа Монголын нэрийг өндөрт өргөж яваа энхийг сахиулагчид билээ. Тэд бол зөвхөн зэвсэг барьсан цэрэг бус, хүмүүнлэгийн элч, эв нэгдлийн гүүр, олон улсын тавцан дахь эх орны нүүр царай, нэр хүндийн баталгаа юм.

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа 1948 оноос эхэлсэн бөгөөд 2002 оноос “Олон улсын энхийг сахиулагчийн өдөр”-ийг жил бүрийн тавдугаар сарын 29-нд тэмдэглэж ирсэн түүхтэй. Монголын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн 2002 оноос энхийг сахиулах цэргийн ажиллагаанданхны цэргийн ажиглагчдаа илгээснээр монгол цэрэг дэлхийн цэрэг болсон юм. Тэр үеэс хойш Монголын Зэвсэгт хүчин дэлхийн олон бүс нутагт тогтвортой байдлыг хангах үйлсэд бодит хувь нэмэр оруулж, “хариуцлагатай, чадварлаг, сахилга баттай” гэсэн үнэлгээг олон улсын тавцанд тогтоож чадсан. Сүүлийн 24 жилийн хугацаанд 24 мянга орчим монгол цэргүүд дэлхийн хамгийн халуун цэгүүдэд очиж энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж ажилласан.

It is impossible to speak of the conquests of Chinggis Khaan, who founded the longest enduring empire in world history, without acknowledging the Mongolian army. The legacy of the Mongolian military, which has left a clear and lasting imprint on the history of statehood, continues today through the Mongolian Armed Forces and their blue helmeted peacekeepers. The origins of the modern Armed Forces date back to March 18, 1921, when the People's Army under the command of Sukhbaatar Damdin liberated Khyagt. Since that defining moment, more than a century of history has unfolded. This date is now observed each year as Mongolian Soldiers' Day.

One of the most vivid aspects of Mongolian Soldiers' Day is the presence of peacekeepers who serve in some of the world's most volatile regions, upholding peace and bringing recognition to Mongolia through their blue helmets. They are not simply armed personnel, but representatives of compassion, links between nations, and a reflection of their country's standing and reputation on the international stage.

Peacekeeping operations under the United Nations began in 1948, and since 2002, the International Day of United Nations Peacekeepers has been marked annually on May 29. Mongolia joined these efforts in 2002 by deploying its first military observers, marking the moment its soldiers stepped onto the global stage. From that point onward, the Mongolian Armed Forces have contributed in practical ways to maintaining stability across various regions, earning a reputation for being responsible, capable, and disciplined. Over the past 24 years, around 24,000 Mongolian soldiers have served in peacekeeping missions in some of the most challenging environments.



SUCCESSORS OF MONGOLIAN MILITARY HISTORY



Монголын энхийг сахиулагчид Африк, Ойрх Дорнод, Азийн бүсийн мөргөлдөөнт болон эмзэг орнуудад, тухайлбал, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад хэрэгжсэн MONUSCO ажиллагаанд Монголын мотобуудлагын болон тусгайлан салбарууд чухал үүрэг гүйцэтгэж, зэвсэгт бүлэглэлүүдийн заналхийллээс энгийн иргэдийг хамгаалах, стратегийн чухал цэгүүдийг харуудан хамгаалах үүргийг амжилттай биелүүлсэн. Мөн Өмнөд Суданд UNMISS ажиллагаанд Монголын цэргийн багууд энхийг сахиулах суурин баазуудын хамгаалалтыг хариуцан ажиллаж, олон мянган дүрвэгсдийн аюулгүй байдлыг хангахад үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Түүнчлэн Сьерра-Леонед UNAMSIL, Афганистанд ISAF зэрэг олон улсын ажиллагаанд монгол цэргүүд мэргэжлийн ур чадвар, сахилга бат, хамтын ажиллагааны соёлоороо онцгойрч байв. Эдгээр ажиллагаанд оролцсон мянга мянган алба хаагчид зөвхөн цэргийн үүрэг гүйцэтгээд зогсохгүй орон нутгийн иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, сургууль, дэд бүтцийг сэргээх, хүмүүнлэгийн ачаа хүргэх зэрэг олон талт ажлыг хийж гүйцэтгэсэн нь Монголын энхийг сахиулагчдын нэр хүндийг улам бататгасан билээ.

Mongolian peacekeepers have carried out their duties in conflict affected and fragile countries across Africa, the Middle East, and Asia. Within the MONUSCO mission in the Democratic Republic of the Congo, Mongolian motorized infantry and specialized units have taken on key responsibilities, protecting civilians from armed groups and securing strategic locations with consistent success. It is also worth noting that Mongolia's first female Brigadier General G. Bolor currently serves as a Military Advisor at the Permanent Mission to the United Nations.

In South Sudan, under the UNMISS mission, Mongolian contingents have been responsible for safeguarding peacekeeping bases and have played an important role in ensuring the safety of thousands of displaced people. Mongolian troops have also taken part in missions such as UNAMSIL in Sierra Leone and ISAF in Afghanistan, where they have stood out for their professionalism, discipline, and cooperative approach. The thousands of personnel who have served in these operations have done more than fulfill military duties. They have provided basic medical care to local communities, helped restore schools and infrastructure, and delivered humanitarian assistance, all of which has strengthened the reputation of Mongolia's peacekeepers.



ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ТӨГӨЛ

Энхийг сахиулагч бүр Монгол Улсын нэрийн хуудас. Тэд гадаадын цэргүүдтэй мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэхдээ үндэсний өв соёл, ёс заншлаа хүндэтгэн сурталчилж, монгол хүний тэсвэр хатуужил, шударга зан, эв нэгдлийг харуулдаг. Олон улсын ажиллагаанд оролцож буй монгол дайчдын талаар “сахилга баттай, үүрэг гүйцэтгэл сайтай, итгэл даах хамтрагч” хэмээн үнэлдэг нь санамсаргүй хэрэг биш. Энхийг сахиулах ажиллагаанд оролцох нь цэргийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхээс гадна стратегийн сэтгэлгээ, олон улсын хамтын ажиллагааны туршлагыг баяжуулдаг. Энэ туршлага нь эх орондоо эргэн ирсний дараа Зэвсэгт хүчний шинэчлэл, сургалт бэлтгэлд шууд тусч, батлан хамгаалах салбарын чадавхыг бүхэлд нь ахиулах нөлөөтэй юм.

Түүнчлэн үндэсний хэмжээний бүтээн байгуулалтад түүчээлэн оролцож байгаагийн нэгэн илэрхийлэл нь Монгол Улсын Зэвсэгт хүчин “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2025 онд мод үржүүлгийн агро экологийн төвтэй болж, мод үржүүлгийн таван газар, зургаан эко ногоон хотхон байгуулан нийтдээ 3,636,691 мод тарьсан явдал юм.

Монгол Улсаас НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцсон 20 мянга гаруй энхийг сахиулагчдын нэрэмжит төгөл Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд бий. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш Монгол Улсад 2022 онд айлчлан ирэх үеэрээ мод суулгасан нь цэнхэр дуулгатнуудын маань олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оруулж ирсэн хувь нэмрийг сануулсан хэрэг байлаа. Энэхүү төгөлд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, НҮБ-ын найм дахь Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн нар мөн л өөрсдийн модыг суулгаж байлаа. Учир нь энхийг сахиулах ажиллагаа нь зөвхөн цэргийн бодлого бус, гадаад харилцаа, аюулгүй байдал, хүний эрх, тогтвортой хөгжлийн зорилтуудтай нягт уялдсан цогц бодлого билээ.

THE GROVE OF PEACEKEEPERS

Every peacekeeper represents Mongolia. While working alongside foreign forces, they uphold and share their national heritage and traditions, reflecting the resilience, honesty, and unity of the Mongol people. Their reputation as disciplined, dependable, and effective partners in international missions is well earned. Taking part in peacekeeping operations not only sharpens military skills, but also deepens strategic thinking and broadens experience in international cooperation. When these service members return home, what they have learned feeds directly into military reform and training, helping to strengthen the overall capacity of the defense sector.

Their contribution is also visible in national development efforts. As part of the “Billions of Trees” National Movement, the Mongolian Armed Forces established an agro ecological center for tree cultivation between 2021 and 2025, along with five tree nurseries and six eco green townships, and planted a total of 3,636,691 trees.

A grove dedicated to more than 20,000 Mongolian peacekeepers who have taken part in United Nations peace support operations has been created in the National Park. During his visit to Mongolia in 2022, António Guterres, Secretary General of the United Nations, planted a tree there, marking the contribution of Mongolian blue helmets to global peacekeeping efforts. The President of Mongolia, Khurelsukh Ukhnaa, and the eighth Secretary General of the United Nations, Ban Ki-moon, have also planted trees in this grove. This reflects the broader reality that peacekeeping is not only a matter of military policy, but part of a wider framework connected to foreign relations, security, human rights, and the goals of sustainable development.



YUHAN

ТҮЙМРИЙН УЛМААС СҮЙДСЭН ОЙГ СЭРГЭЭНЭ

*(Тэсвэртэй, нөхөн сэргэх чадвартай,
харцуулагатай ойжуулалт)*

БНСУ-ын Юхан групп
монгол орон даяар өрнөж
буй Тэрбум мод үндэсний
хөдөлгөөнийг дэмжиж
Төв аймгийн Батсүмбэр
сумын ой хээрийн түймрийн
улмаас доройтсон ойг нөхөн
сэргээхээр болжээ.

"In support of the 'Bil-
lion Trees' National
Movement, South Ko-
rea's Yuhan Corporation
is partnering to restore
fire-damaged forest ar-
eas in Batsumber soum
of Tuv province."

RESTORING THE FOREST DAMAGED BY FIRE

ЮХАН ГРУППЫН ТУХАЙ

Юхан корпораци нь 1926 оноос хойш эм, эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлчилгээний чиглэлээр олон жилийн турш үйл ажиллагаагаа явуулж буй Өмнөд Солонгос улсын томоохон үйлдвэрүүдийн нэг юм. Тус компаний охин компаниуд Монгол Улсад ойжуулалт, газрын доройтлыг бууруулах санаачилгууд болох Тужийн нарс төсөлд олон жилийн турш оролцоор ирсэн ба группийн хэрэгжүүлж буй төслүүд нь газрын доройтлыг бууруулах үндэсний зорилтуудыг дэмжихийн зэрэгцээ Монгол, Өмнөд Солонгосын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Энэ удаагийн бүс нутгуудад хэрэгжиж буй төсөл нь ойн нөхөн сэргээлт, доройтсон газрын нөхөн сэргээлтэд чиглэж байна. Тэд төрийн байгууллага, эрдэмтэн судлаачид, ойн нөхөрлөл, орон нутгийн иргэдтэй хамтран мод тарих, түймэрт өртсөн ойг сэргээх, илүү тогтвортой экосистем бий болгох ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

ABOUT THE YUHAN GROUP

Yuhan Corporation is one of South Korea's leading pharmaceutical and healthcare companies, with a legacy dating back to 1926. Over the decades, the company has built a strong reputation in the development and production of pharmaceuticals and health-related products. Its subsidiaries have maintained a long-standing presence in Mongolia, actively contributing to reforestation and land restoration initiatives known as Tujiin nars. Through these efforts, the group supports Mongolia's national environmental priorities while also reinforcing bilateral cooperation between Mongolia and the Republic of Korea.

The current phase of activities, particularly in regions, focuses on forest rehabilitation and the recovery of degraded landscapes. These initiatives will be implemented in close collaboration with government institutions, academic researchers, forest user groups, and local communities. Planned interventions include large-scale tree planting, the restoration of fire-affected forest ecosystems, and the establishment of more resilient and sustainable ecological systems.



ЮХАН 4РЭ ТӨСӨЛ

(Тэсвэртэй, нөхөн сэргээх чадвартай, харууцлагатай ойжуулалт)

Уг төслийн зорилго нь Төв аймгийн Батсүмбэр сум дөрөвдүгээр баг Удлэг багийн нутаг дэвсгэрт хамаарах доройтсон ойн хэмжээг бууруулах, цаашид доройтохоос сэргийлэхэд чиглэсэн, шинжлэх ухаанд суурилсан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан ойн нөхөн сэргээлтийн загварыг бий болгоход оршино.

Таван жилийн хугацаатай үргэлжлэх энэхүү төсөл нь жил бүр 36,000 гаруй мод тарьж, ойролцоогоор 75 га талбай бүхий ойг нөхөн сэргээх юм. Төсөлд тухайн сумын иргэд, ойн нөхөрлөлүүдэд тогтвортой ойн менежментийн ач холбогдол, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагааны үүрэг, ач холбогдлыг таниулах, ойн доройтол, нөхөн сэргээлт түүнийг хамгаалахтай холбоотой сургалт мэдээллийг тухай бүр өгч ажиллахаар болсон байна.

Юхан 4РЭ төслийн эхний бэлтгэл шатны ажлууд 2026 оноос эхлэхээр төлөвлөгдсөн ба газар сонгох, модны төрөл, тарилтын техникийг сонгох ажлыг МУИС-ийн багш, судлаачид хийхээр болжээ.

YUHAN 4RE PROJECT

(Resilient, Restorative, Responsible Reforestation)

The YUHAN 4RE Project aims to develop a science-based model for forest restoration grounded in public-private partnership (PPP). It is designed to reduce existing forest degradation while preventing further ecological decline within the 4th bag (Udleg bag) of Batsumber soum, Tuv province.

Over a five-year implementation period, the project will plant more than 36,000 trees annually and restore approximately 75 hectares of degraded forest land. In parallel, it will deliver continuous training and awareness programs for local residents and forest user groups, highlighting the importance of sustainable forest management and their role in mitigating climate change. These capacity-building efforts will also address key topics such as forest degradation, restoration techniques, and long-term forest protection.

The preparatory phase of the YUHAN 4RE Project is scheduled to begin in 2026. Critical preparatory work—including site selection, species identification, and the development of appropriate planting techniques—will be carried out by faculty members and researchers from National University of Mongolia.

Төв аймаг, Батсүмбэр сум

- 1926 онд байгуулагдсан. Нийт 4 багтай.
- Нийт 2082 өрхтэй.
- Төв аймгийн 2 дахь том сум
- 7081 хүн амтай
- Улаанбаатар хотоос 79 км
- Сөгнөгөрийн гол, Мандалын арын ус гэх мэт байгалийн үзэсгэлэн бүрдсэн нутаг
- Батсүмбэр сумын ой нь ихэвчлэн байгалийн жамаар сэргэн ургасан ойгоос бүрддэг. Сибирийн хуш, хус, улиас, нарс, гацуур зэрэг модод энэ бүс нутагт тархан ургасан байдаг. Харин гол мөрөн, горхины дагуу улиас болон бургас зонхилон ургана.



Batsumber soum, Tuv province

- Established in 1926 with 4 units /bag/
- 2 nd largest soum in Tuv province with 2082 households
- With total of 7981 population
- 79 km from Capital city Ulaanbaatar
- Sugnugur river and other mineral springs with abundant water resources
- The forests of Batsumber soum are predominantly naturally regenerated forests. Siberian pine and spruce are scattered throughout the area. Along riverbanks and streams, poplar and willow species are commonly found.


МОНДНЫ ТӨРӨЛ

Батсүмбэр сумын ой гарал үүслийн хувьд өөрөө аясаараа сэргэн ургасан байгалийн ой бөгөөд ойн хэлбэр нь ихэвчлэн энгийн ой байх ба заримдаа хөгшин моддын доогуур залуу модод ташинга үүсгэж ургаснаас нийлмэл ой үүссэн байна. Ойн бүрэлдэхүүнд шинэс, хусан ой зонхилох бөгөөд хуш, хус, улиангар, нарс, гацуур зэрэг мод тархан ургах ба гол горхины дагуу улиас, бургас ургана.

Байгалийн ой моддын төрлийн эзлэх хувийг авч үзвэл:

Байгалийн ойд модны төрлийн эзлэх талбай (га)

Forest Area by Tree Species in Natural Forests (ha)



Батсүмбэр сумын нийт ойн сангийн:

- 57.4 хувийг шинэс мод,
- 10.6 хувийг хуш мод,
- 23.3 хувийг хус мод,
- 6.8 хувийг нарс мод тус тус эзэлж байна.

Within the forest resources of Batsumber soum:


- larch forests at 57.4 percent,
- Siberian pine at 10.6 percent,
- birch forests at 23.3 percent,
- Pine forests at 6.8 percent.

From the perspective of forest origin, the forests of Batsumber soum are predominantly naturally regenerated forests. The forest structure is generally characterized as simple stands; however, in some areas, mixed forests have developed where young trees regenerate beneath mature stands, forming a layered forest structure. The forest composition is dominated by larch and birch forests. In addition, species such as Siberian pine (cedar), birch, aspen, pine, and spruce are scattered throughout the area. Along riverbanks and streams, poplar and willow species are commonly found.

In terms of species composition within the natural forest, the proportional distribution of tree species is as follows:

- Siberian larch (*Larix sibirica*) – 54,794 hectares
- Siberian pine (*Pinus sibirica*) – 10,125 hectares
- Scots pine (*Pinus sylvestris* L.) – 6,524 hectares
- Siberian spruce (*Picea obovata*) – 71 hectares
- Asian white birch (*Betula platyphylla*) 22,220 hectares
- Laurel-leaf poplar (*Populus laurifolia*) – 252 hectares
- Aspen (*Populus tremula*) – 730 hectares
- Willow (*Salix* spp.) – 629 hectares

The distribution of forest area by tree species in natural forests is illustrated in the graph above





Доктор Б.ЭНХТУЯА

Тэрбум мод хөдөлгөөн ТББ-ын Эрдмийн зөвлөлийн гишүүн

Ph.D B. ENKHTUYA

A member of Experts&scientists advisors council, Billion trees Movement NGO

Газар зүйн байрлал, уур амьсгалын онцлогоос шалтгаалан нийт нутгийн 90 гаруй хувийг хуурай, хагас хуурай, хуурайвтар нутаг гэж ангилна. Манай орны хувьд цөлжилтөөс гадна уул уурхайн тодорхой бус бодлого экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, экосистемүүдийг нөхөн сэргээх зүйлшгүй шаардлага тулгарч байна. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээрээ байгаль орчны тэнцвэрт байдал, уур амьсгалын өөрчлөлтөд анхаарал хандуулах болжээ. Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн өрнөж буй нь дэлхийн улс орнуудтай мөр зэрэгцэн алхах үндэс болж байна.

Европын орнуудад өргөнөөр хэрэглэгдэж үр дүн нь батлагдсан микоризын биотехнологи бол дээд ургамлын үндэс болон хөрсний микромөөгний хооронд үүсдэг харилцан ашигтай хам амьдралын хэлбэр юм. Ургамал нь мөөгөнд органик бодисыг өгч, түүний нарийн утаслагаар дамжуулан хөрснөөс өөрийн үндсэнд хүрч авах боломжгүй эрдэс давс, ус болон бусад тэжээлийн бодисуудыг авч ургалт нь сайжирдаг. Үүнээс гадна энэхүү хам амьдрал нь биогехимийн эргэлтийн нягтрал, хөрсний тогтвортой бүтэц агрегацид чухал нөлөө үзүүлж хөрсний элэгдлийг багасгадаг болох нь олон орны эрдэмтдийн судалгаагаар нэгэнт нотлогдоод байна.

Жишээ нь: Энхтуяа Б. 2009, Энхтуяа Б. ба Vosatka M. 2005, Энхтуяа Б. et al. 2005 and 2003.

Микоризын биотехнологийг Монгол орны нөхцөлд туршин хэрэглэж эхлэх нь ойжуулалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж, ургамалжуулах ажлыг түргэсгэх чухал нөлөөтэй юм. Чех улсын хувьд бэлтгэгдэн гарч байгаа бортоготой суулгац нь, тухайн суулгацын амьдрах чадварыг дээшлүүлэх зорилгоор заавал микориз агуулсан байх стандартыг мөрдөн ажилладаг байна.

МОДНЫ ТАРЬЦ, СУУЛГАЦЫН УРГАЛТЫГ САЙЖРУУЛАХ БИОТЕХНОЛОГИ

BIOTECHNOLOGY TO ENHANCE THE GROWTH OF TREE SEEDLINGS AND SAPLINGS



2.



1.


2. Нөхөн сэргээлтийн хэрийн судалгааны үр дүнг графикаар харуулсан байдал. Үзүүлсэн утга бүр нь 5-н давтамжтай. Ижил үсгээр тэмдэглэгдсэн баганууд нь мэдэгдэхүйц ялгаатай биш ($P > 0.05$).

2. Graphical presentation of the results from the field study conducted at the restoration site. Each value represents five replicates. Bars marked with the same letter are not significantly different ($P > 0.05$).



3.

3. Модны ургалтад үзүүлэх микоризын нөлөөг лабораторийн туршилтаар судлан баталгаажуулсан байдал.



1. Нөхөн сэргээлтийн талбайд тарьсан нэг настай хүс (*Betula pubescens*)-ны суулгац. a – микоризын хам амьдралгүй, b – хам амьдралтай (Terra Vital-G бэлдмэл - Симбиом).

One-year-old seedlings of birch (*Betula pubescens*) planted in a restoration site. a – without mycorrhizal symbiosis; b – with mycorrhizal symbiosis (Terra Vital-G preparation – SymbioM).

3. Laboratory experiment confirming the effect of mycorrhiza on tree growth.

Due to its geographic location and climatic characteristics, more than 90 percent of Mongolia's territory is classified as arid, semi arid, or dry sub humid. In addition to desertification, inconsistent mining policies have disrupted ecological balance, creating an urgent need for ecosystem restoration.

In recent years, global attention has increasingly focused on environmental sustainability and climate change. In this context, the national “Billion Trees” movement initiated by President U. Khurelsukh represents an important step for Mongolia to align with global environmental initiatives.

Mycorrhizal biotechnology, widely applied and scientifically validated in European countries, refers to a mutually beneficial symbiotic relationship between the roots of higher plants and soil fungi. Plants supply the fungi with organic compounds, while the fungal hyphae enable plants to absorb mineral salts, water, and other nutrients from the soil that would otherwise be inaccessible to their roots, thereby enhancing plant growth and vitality. Moreover, this symbiotic association plays a significant role in biogeochemical cycling and contributes to the formation of stable soil aggregates, which helps reduce soil erosion. These benefits have been well documented in numerous scientific studies (e.g., Enkhtuya B., 2009; Enkhtuya B. and Vosatka M., 2005; Enkhtuya B. et al., 2005; 2003).

The introduction and application of mycorrhizal biotechnology under Mongolian conditions has considerable potential to improve the effectiveness of afforestation and ecological restoration activities, while accelerating vegetation establishment. In the Czech Republic, for example, container-grown seedlings are produced in accordance with standards that require the presence of mycorrhiza in order to enhance seedling survival and establishment rates.

Enkhtuya Batkhuu: (2009) “Influence of mycorrhizal symbiosis on plant growth in stress conditions and its potential using and importance on plant” review magazine of the faculty of Dendrology and Forest Tree, CULS Prague.

Batkhuu Enkhtuya and Miroslav Vosatka: (2005) Arbuscular mycorrhizal symbioses between grass and trees

using for re-cultivation and role of its ERMycelium on their interaction and soil aggregation. *Symbiosis* 38: 261-277.

Batkhuu Enkhtuya, Michael Pöschl and Miroslav Vosatka:

(2005) Native grass facilitates mycorrhizal colonisation of three tree species in two anthropogenic substrates. *Water, Air and Soil Pollution* 166: 217-236.

Enkhtuya Batkhuu, Ulfur Oskarsson, John C. Dodd, Miroslav Vosatka:

(2003) “Inoculation of grass and tree seedlings used for reclaiming eroded areas in Iceland with mycorrhizal fungi”. *Folia Geobotanica* 38: 209-222.



Хэнтий аймаг, Хэрлэн гол Гэрэл зургийг Н.Мөнхбаатар 2025он
River Kherlen, Khentii Province Photo by Munkhbaatar.N 2025



“ШИМ ЕРТӨНЦӨД МОД ТАРИВАЛ САВ ЕРТӨНЦӨД БУЯН ХУРААНА”



Мод тарьж ургуулах соёл, зан заншлыг төлөвшүүлэх аяныг эхлүүлнэ

Санаачлагч:

-Монголын Бурханы Шашинтны Гандантэгчэнлин хийд
-“Тэрбум мод хөдөлгөөн” ТББ

Үндэслэл: Өнөө үеийн хүн төрөлхтний өмнө тулгарч буй хамгийн том сорилтуудын нэг болох “уур амьсгалын өөрчлөлт”-ийг даван туулахад Монгол улс бодит хувь нэмэр оруулах зорилгоор Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг 2022 оноос эхлүүлээд байна. Энэхүү санаачилга нь хүн байгаль хоорондоо шүтэн барилдлагатай оршдог хэмээн үздэг Бурханы шашны үзэл номлолтой нийцэж байгаа юм. Эх болсон байгаль дэлхийгээсээ зөвхөн авдаг бус өгдөг эерэг дадлыг бий болгож сав ертөнцдөө цэвэр агаар нэмж, шим болсон хөрс ургамлаа тэжээн тэтгэхүйн буянт үйлд мод тарьж, ургуулан амь бүтээж хувь нэмрээ оруулах нь хүн бүрийн эрхэм үүрэг болоод байна.

Зорилго: Хүн өөрийн амьдралд тохиолдсон хамгийн баяр жаргалтай, дурсамжтай цаг үеүүдээ болон бусдад сайныг ерөөж буян үйлдэх үедээ эх дэлхийдээ мод тарьж ургуулдаг байх, байгаль орчныг хайрлан хамгаалах үүрэг оролцоог нэмэгдүүлэх, эерэг амьдралын хэв маягийг төлөвшүүлэх.

Хүлээгдэж буй үр дүн: Монгол түмний үзэл санааны хамгийн том нэгдэл болох Бурханы шашны сургааль номлолоор дамжуулан эх дэлхийдээ мод тарьж ургуулах нь байгальд амь бүтээж буян хураах олон хэлбэрийг нэгтгэсэн хамгийн чухал үйл гэдгийг хүн бүрийн ухамсар, оюун санаанд нь хоногшуулж байгальд ээлтэй дадлыг төлөвшүүлэх, шашин, нийгэм, байгаль хамгааллын уялдааг шинэ шатанд гаргах

-Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар
- Нийслэл, дүүрэг, аймаг, сумдын хийдүүд
- Агнистын гэгээ фэйсбүүк хуудас
- 20K клуб

Энэхүү аянд “20K клуб”-ын зүгээс санаачилсан “Амьдралын 5 мод” төслөөр хүний амьдралын хамгийн чухал таван үе шатандаа ерөөл бэлгэдэл болгон тухайн мөч бүрт мод тарьж, ургуулдаг зан үйлийг хэвшүүлэх төслийг нэгтгэн зохион байгуулна.

Хугацаа: Жил бүрийн Хаврын улиралд байгаль дэлхий сэргэж үндэстэй бүхэн амь орж урган төлжих билэгт сайн өдрүүдээр Монгол хүн бүр, үндэстнээрээ мод тарьж ургуулдаг соёл уламжлалтай болж

“ТҮМЭН ЖИЛИЙН ӨВ БОЛЖ ҮЛДЭХ ТЭРБУМААР
ТООЛОГДОХ МОДЫГ ХАМТДАА УРГУУЛЦГААЯ”



“PLANT TREES IN THE LIVING WORLD, REAP MERIT IN THE GREATER UNIVERSE”

A National Campaign to Cultivate the Culture and Tradition of Tree Planting



Initiators:

- Gandantegchinlen Monastery, the Center of Mongolian Buddhism
- “Billion Trees Movement” NGO

Rationale:

To address one of the most pressing challenges facing humanity today—climate change—Mongolia launched the national “Billion Trees” movement in 2022 with the aim of making a tangible contribution to global environmental sustainability.

This initiative aligns closely with the philosophical teachings of Buddhism, which emphasize the interdependent relationship between humans and nature. It calls for a shift in human behavior—from merely taking from nature to giving back—by fostering positive, environmentally responsible habits.

Planting and nurturing trees is not only an act of ecological restoration—enriching the air we breathe and sustaining fertile soil and plant life—but also a virtuous deed that contributes to the creation and preservation of life itself. In this context, actively participating in tree planting has become a shared moral responsibility for all.

Objective:

The campaign seeks to establish a meaningful tradition whereby individuals plant and grow trees during life’s most joyful and memorable moments, as well as on occasions of goodwill and acts of merit. It aims to strengthen public responsibility for environmental protection while promoting a positive and sustainable lifestyle.

Expected Outcomes:

By drawing upon the spiritual and philosophical foundations of Buddhism—one of the most unifying belief systems among the Mongolian people—the campaign aspires to instill a deep awareness that planting and nurturing trees is among the most significant acts of creating life and generating merit.

It further aims to cultivate environmentally conscious habits, while elevating the synergy between religion, society, and environmental conservation to a new level.

Collaborating Organizations:

- Office of the President of Mongolia
- Forest Agency (Implementing Agency of the Government of Mongolia)
- Monasteries across the capital, districts, provinces, and soums
- Agnistiin gegee facebook page
- “20K” Club



As part of this campaign, the “20K Club” will integrate its “Five Trees of Life” initiative, which encourages individuals to plant and nurture trees at the most profound moments of life in their lives—each tree symbolizing blessings and meaningful life moments—thereby embedding this practice into cultural tradition.

Timeline:

Annually, during the spring season—on auspicious days when nature awakens, and all living things begin to grow and flourish. Let every Mongolian embrace the tradition of planting and nurturing trees and together

“LET US GROW BILLIONS OF TREES, A LEGACY FOR GENERATIONS TO COME.

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН 127,959,651 МОД ТАРИЛАА




“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 онд

21 аймаг, Улаанбаатар хотод **65,742,132**,
Уул уурхайн аж ахуйн нэгжүүд **46,923,696**
Банк, санхүүгийн байгууллага **3,093,742**
Төрийн байгууллагууд **4,880,602**
Бусад санаачилга, олон улсын төсөл
хөтөлбөрүүд **7,319,479**
нийт **127,959,651** ширхэг мод, сөөгийг
тарьжээ.

Энэ хугацаанд Сэлэнгэ аймаг **26,231,334**
мод, сөөг тарьж, бусад аймгуудаас тэргүүлсэн
амжилт үзүүлсэн байна.
Хөдөлгөөний зорилго нь байгаль орчныг
сэргээж, уур амьсгалын өөрчлөлтийг
сааруулахад чиглэсэн бөгөөд иргэд, аж ахуйн
нэгж, орон нутгийн байгууллагууд идэвхтэй
оролцсоор байна.

IN A FRAME OF THE BILLION TREES NATIONAL MOVEMENT, 129,959,651 TREES HAVE BEEN PLANTED



"Billion Trees" National Movement 2025

Within the framework of the "Billion Trees" national movement, between 2022 and 2025, a total of **127,959,651** trees and shrubs have been planted across 21 provinces and Ulaanbaatar city. This includes **65,742,132** planted by provinces and the capital, **46,923,696** by mining companies, **3,093,742** by banking and financial institutions, **4,880,602** by government organizations, and **7,319,479** through

other initiatives and international projects. During this period, Selenge Province planted **26,231,334** trees and shrubs, achieving the highest result among all provinces. The goal of the movement is to restore the environment and mitigate climate change, with active participation from citizens, businesses, and local organizations



EXCLUSIVELY TAILORED
for you



DANDY
atelier

We believe in crafting garments that last - using natural fibers
that respect both your skin and the planet.

CHECK US HERE

